

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын
санаачилга (ОУИТБС)**

**МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН
САНААЧИЛГА (ОУИТБС) – МОНГОЛ Улсын ХОЁР ДАХЬ
УДААГИЙН БУЮУ 2007 ОНЫ НЭГТГЭЛ ба ТАЙЛАН**

Төсөл тайлан – 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр

Агуулга

ТОВЧЛОЛ/ТОДОРХОЙЛОЛТ	i
ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ	ii
1. ОРШИЛ	1
1.1 Зорилго.....	1
1.2 Гүйцэтгэх ажлын хамрах хүрээ.....	1
1.3 Ажлын хамрах хүрээнд тавигдах хязгаарлалтууд.....	2
1.4 Талархал	2
2. АРГА ХАНДЛАГА.....	3
2.1 Бидний нарийвчилсан хандлага	4
3. ТОДРУУЛГА.....	11
3.1 Анхан шатны харьцуулалт	11
3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ	13
3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд	31
4. АСУУДЛУУД.....	37
4.1 Цаг хугацаа болон цагийн хуваарь.....	37
4.2 Засгийн газрын мэдээллийн бүрэн бус байдал.....	37
4.3 Маягтуудын загвар.....	38
4.4 Маягтуудыг нарийн зөв бөглөх асуудал	39
4.5 Маягтуудыг бөглөх зааварчилга	39
4.6 Маягтад оруулах төлбөрүүдийн талаарх нэгдсэн ойлголт	39
4.7 Засгийн газрын харьяа байгууллагуудад үзүүлсэн хандив, тусламж	40
4.8 Тэмдэгтийн болон бусад хураамж, үйлчилгээний хөлс.....	40
4.9 Тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл байхгүй байна.....	40
4.10 Засгийн газрын харьяа байгууллагууд ба компаниуд нь материаллаг дүнтэй төлбөрийн гүйлгээнүүдийг бүртгээгүй байна.....	40
5. ЗӨВЛӨМЖ, САНАЛ.....	41
5.1 Хугацаа болон цагийн график	41
5.2 Засгийн газрын өгч буй мэдээллийн бүрэн бус байдал	41
5.3 Маягтуудын загвар.....	43
5.4 Маягтуудыг нарийн зөв бөглөх	43
5.5 Тайлагнасан дүнгийн талаарх нэмэлт мэдээлэл	44
6. ДҮГНЭЛТ.....	45

Агуулга \үргэлжлэл\

Хавсралтууд

Хавсралт А:	Засгийн газрын байгууллагууд – мэдээллийн эх сурвалж
Хавсралт Б:	Уул уурхайн компаниудын жагсаалт
Хавсралт В:	Компани тус бүрээр бэлтгэсэн тайлан
Хавсралт Г:	Анхны зөрүү
Хавсралт Д:	Компанийн болон Засгийн газрын тайлангуудад хийсэн цэвэр залруулгууд
Хавсралт Е:	Шийдэгдээгүй зөрүүнүүд

Товчлол/Тодорхойлолт

ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
Эрнст энд Янг буюу “зөвлөхүүд”	Эрнст энд Янг Монгол Аудит ХХК ба Эрнст энд Янг Малайз
ГЕГ	Улсын гаалийн ерөнхий газар
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
Засгийн газар	Монгол Улсын Засгийн газар
Засгийн газрын нэгж байгууллагууд	Яам, засгийн газрын агентлаг, ҮТЕГ, ГЕГ, ЭБЭХЯ, БОЯЖЯ, АМГ, ТӨХ, ХХҮГ, орон нутгийн (аймаг болон сумдын) засаг захиргаа
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
МОУИТБСАА	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба
ЭБЭХЯ (өмнө нь ХҮЯ гэж байсан)	Эрдэс баялаг, эрчим хүчний яам (өмнө нь Худалдаа, аж үйлдвэрийн яам гэж байсан)
Төгрөг	Монгол төгрөг
СЯ	Сангийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуучлалын яам
АМГ (өмнө нь АМГТХЭГ–ын хэсэг байсан)	Ашигт малтмалын газар (өмнө нь АМГТХЭГ–ын хэсэг байсан)
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
ГТГ	Газрын тосны газар (өмнө нь АМГТХЭГ–ын хэсэг байсан)
ТӨХ	Монгол улсын Төрийн өмчийн хороо
Ам.доллар	Америкийн нэгдсэн улсын доллар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар

Гүйцэтгэлийн хураангуй

Үүрэгт ажлын арга хандлага дараах хоёр үе шаттай байлаа. Үүнд:

Үе шат 1 – Дүн шинжилгээ ба нэгтгэл

Үе шат 2 – Нягтлан шалгалт, үнэлгээ ба аудитын дүгнэлт

Үүрэгт ажлын үе шат 1-д уул уурхайн зарим компани хүссэн мэдээллийг гаргаж өгөхдөө ОҮИТБС-ын хуучин маягтуудыг хэвээр ашиглаж байсныг шийдвэрлэсэн. Энэ үе шатанд олж тогтоосон томоохон асуудал бол 27,221,026 мянган төгрөгийн дүнтэй зөрүү байсан ба энэ зөрүү нь НӨАТ, ажил олгогчид болон ажиллагсадын төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүмүүсийн ашиг орлогын татвар, даатгал болон компаниудын зүгээс орон нутгийн байгууллагуудад өгсөн хандив, тусламж зэрэг цаашид тайлагнах шаардлагагүй зүйлсийг оруулж тооцсонтой холбоотойгоор үүссэн байсан. Дара нь эдгээрийг нийт зөрүүнээс хассан. Гол зөрүү татвар, төлбөр, төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг гэсэн зүйлүүд дээр гарч байгааг шинжилгээ харуулав.

Уул уурхайн холбогдох компаниудаас ихэнх мэдээллийг хүлээн авсны дараа үе шат 2-ын ажил эхэлсэн. Гэхдээ Засгийн газраас ирүүлсэн хариу ядмагхан, эцсийн үе шатанд хүлээн авсан мэдээлэл бүрэн биш байлаа. Үүнээс улбаалаад хэд хэдэн удаа очиж уулзах шаардлага гарч байсан нь энэхүү тайланг оройтуулахад нэрмээс болсон.

Үе шат 2-т бидний тодруулж мэдсэн зүйл нь эдгээр зөрүүгийн үндсэн цөм нь уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагууд анхны тайлагнасан мэдээллээ хэд хэдэн удаа засч өөрчилж байснаас шалтгаалсныг харуулав. Уул уурхайн компаниудын зүгээс ийнхүү засч өөрчилсний гол учир шалтгаан нь тайлагналын шаардлагуудын талаарх ойлголт хангалтгүй болон хувь хүний алдаа зэргээс шалтгаалаад ОҮИТБС-д ирүүлсэн мэдээлэл Засгийн газрын байгууллагуудад өгсөн мэдээллээс зөрүүтэй байсанд оршино.

Төлсөн зарим төрлийн татвар, төлбөрийн талаарх мэдээллийг ОҮИТБС-ын маягтуудад буруу оруулсан болохыг бусад зөрүү харуулж байгаа юм. Жишээ нь: импортоор авсан шатах, тослох материалын онцгой албан татвар зэрэг өөр бусад татварыг гаалийн татварт оруулж тооцсон байсан ба үе шат 1-д бидний олж мэдсэнээр НӨАТ, хувь хүний орлогын албан татвар, татварын торгууль зэрэг шаардлагагүй мэдээллийг энд мөн оруулсан байлаа.

Засгийн газрын нэгж байгууллагууд уул уурхайн компаниудын зүгээс аймаг, сумдад хийсэн зарим төлбөр, ялангуяа Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж, газрын төлбөр болон ус ашигласны төлбөрийн дүнг тайлагнаагүйгээс болж зөрүү мөн үүссэн байна. Төлсөн дүнгээ эсвэл төлөх дүнгээ бөглөх эсэх талаарх эргэлзээ нь зарим зөрүү гарахад нөлөөлсөн. Зөвхөн ганц зүйл дээр буюу “Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг” гэсэн зүйл дээр гарсан зөрүү л Засгийн газрын нэгж байгууллагуудын тайлагнасан дүнг уул уурхайн компаниудын тайлагнасан дүнгээс илүү гаргаж байсан. Мөн үүнд ҮТЕГ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр ХХК-ийн 2006 онд хийсэн 59,151,641 мянган төгрөгийн ногдол ашгийн төлбөрийг 2007 оны төлбөрт оруулж тайлагнасан нь нэрмээс болсон.

Тодорхой зөрүүг шийдсэний дараа шийдэгдээгүй хэвээр үлдсэн зөрүүгийн тухайд гэвэл цааш тулган шалгаж нэгтгэхэд шаардлагатай нарийвчилсан мэдээлэл хангалттай бус байлаа. Үүнийг уул уурхайн компаниудын зүгээс хариуцсан ажилтан байхгүй, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн баазаас шаардлагатай мэдээлэл олж авах боломжгүй, баримтуудыг архивт шилжүүлсэн тиймээс мэдээллийг гаргаж өгөх боломжгүй гэсэн тайлбаруудыг өгч байсан.

Засгийн газрын нэгж байгууллагуудын тухайд авч үзвэл зөрүүг шийдэхэд нэрмээс болж байгаа гол зүйл нь ҮТЕГ-ын түвшинд цуглуулсан мэдээлэл бүрэн бус, АМГ ба компаниудын тайлагнасан дүнгүүд хоорондоо зөрүүтэй, маргаантай байсан явдал юм. Мөн гэрээт ажлыг гүйцэтгэх явцад сум болон аймгууд цуглуулж авсан бүх татварын дүнг ҮТЕГ-т тогтмол мэдээлэхгүй байгаа нь тодорхой харагдсан. Нэгтгэх ажиллагааг цаашид амжилттай болгоё гэвэл үүнийг даруй засч шийдвэрлэх шаардлагатай.

Гүйцэтгэлийн хураангуй \үргэлжлэл\

Эцэст нь хэлэхэд, дээр дурдсан бүхнээс үүдэн Монголын ОҮИТБС ОҮИТБС-ын маягтуудыг бөглөх үед гарч болох аливаа асуудлыг шийдэж өгөх тусламжийн ширээ ажиллуулахын зэрэгцээ уг маягтуудыг бөглөх зааврыг илүү нарийн тодорхой болгож өгвөл уул уурхайн компаниудаас ирүүлж байгаа тоо мэдээний чанар цаашид сайжирна гэж бид найдаж байна. Гэхдээ хамгийн чухал нь холбогдох бүх талуудаас ирж ОҮИТБС-ын маягтуудад бөглөгдөх мэдээллийн чанарыг сайжруулах зорилго бүхий албан ёсны тогтсон тайлагнах үйл явцыг боловсронгуй болгох чиглэлээр Сангийн яам болон Засгийн газрын холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллах шаардлагатай байна.

1. Оршил

“Харилцан тохирсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажил” ба Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба (МОУИТБСАА-тай байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ (МОУИТБС-ын хоёрдахь удаагийн буюу 2007 оны нэгтгэл ба тайланд зөвлөгөө өгөх үйлчилгээний нэг ба хоёрдугаар үе шатны 2009 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн гэрээ)-ний нөхцлүүдэд хамаарах “Холбогдох үйлчилгээний олон улсын стандартууд”-ын дагуу хийгдсэн Монгол Улсын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын хоёр дахь удаагийн буюу 2007 оны нэгтгэл ба тайланг шалгах ажилд /гэрээт ажил/ Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын алба (ОУИТБСАА) нь Эрнст энд Янг Монгол Аудит ХХК болон Эрнст энд Янг Малайз компаниудын нэгдлийг (“Эрнст энд Янг” буюу “Зөвлөхүүд”) шалгаруулж томилсон.

Энэ тайланд гэрээт ажлын хүрээнд хийгдсэн ажлуудын дэлгэрэнгүй тайлан, тулган шалгалт болон шинжилгээний үр дүн, эдгээрийн явцад тодруулж мэдсэн зүйлс, мөн холбогдох зөвлөмжүүд дэлгэрэнгүй багтаж орсон болно. Энэ тайланг энэ тайлангийн хавсралтуудтай холбон уншина.

1.1 Зорилго

Энэхүү гэрээт ажлын зорилго нь Олон улсын ОУИТБСАА-наас гаргасан журмын дагуу Монгол Улсын уул уурхайн салбарын төлбөр ба орлогын ил тод, найдвартай байдлыг тодорхойлоход оршино. Эл зорилгын үүднээс гэрээт ажлын хүрээнд 2007 оны санхүүгийн жилд уул уурхайн салбарт хийгдсэн материаллаг хэмжээний төлбөр, хүлээн авсан баримтуудад дүн шинжилгээ хийх болон тулган шалгах ажил хийнэ.

1.2 Гүйцэтгэх ажлын хамрах хүрээ

Энэхүү гэрээт ажлын зорилгыг ханган хэрэгжүүлэхийн тулд Эрнст энд Янг компани нь дараах ажлуудыг хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Үүнд:

- ▶ 2007 оны татварын жилд уул уурхайн компаниудаас Монгол улсын Засгийн газар (“Засгийн газар”)-т төлсөн материаллаг дүнтэй бүх төлбөрүүдэд болон Засгийн газрын уул уурхайн компаниудаас хүлээн авсан материаллаг дүнтэй бүх орлогуудад дүн шинжилгээ хийнэ. Дүн шинжилгээ нь эхний ээлжинд компани нэг бүрийн бөглөсөн болон Засгийн газраас компани тус бүр дээр бөглөсөн тайлангийн маягтуудад үндэслэнэ. (2007 оны татварын жилд компаниудын төлсөн төлбөрийн хувьд материаллаг байдлын түвшинг хамгийн багадаа 200 сая төгрөг байхаар тогтоосон /ойролцоогоор 38 компани/).
- ▶ Тайланг монгол, англи хэл дээр бэлтгэх ба уг тайланд компаниудын төлсөн бүх төлбөр, Засгийн газрын хүлээн авсан бүх орлогыг нийт болон дэлгэрэнгүй дүнгээр нь, төлбөрийн төрөл бүрээр нь харуулсан байна. Бид төлсөн болон хүлээн авсан төлбөрүүдийн хоорондох аливаа зөрүүг тайлбарлахын тулд хоёр талтай хамтран ажиллах ба тайлбарлаж чадаагүй зөрүүнүүд болон тэдгээрийн шалтгааныг тайланд тусгана. Тоо баримтын чанар, шалгалтын нийт үйл явцын талаарх санал дүгнэлтээ тайланд тусгана. Энэ ажлыг цаашид хэрхэн сайжруулах, зөрүү болон түүний шалтгааныг яаж илүү үл үндэстэй шалгах талаарх зөвлөмжийг тайланд мөн тусгана.

1. Оршил \үргэлжлэл\

1.3 Ажлын хамрах хүрээнд тавигдах хязгаарлалтууд

Дор тодорхойлсноос бусад тохиолдолд бэлэн мөнгөөр болон өөр бусад хэлбэрээр хийгдсэн төлбөрүүд (“Харилцан тохирсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажил”-д хамаарах “Холбогдох үйлчилгээний олон улсын стандартууд”-ын дагуу хийгдсэн) -ийг шинжлэхдээ нягтлан бодох бүртгэлийн мөнгөн суурь дээр үндэслэх ба бид үүнийг өөрсдийн тайланд тусгана. Бид энэ тайлангийн дараагийн хэсгүүдэд дэлгэрэнгүй танилцуулсан горимуудыг гүйцэтгэх ба өөрсдийн гүйцэтгэсэн ажлын бодит үр дүнг ОҮИТБСАА-нд тайлагнах болно.

Бидний гүйцэтгэх ажлын горим нь 2007 оны санхүүгийн жилд Монгол Улсын уул уурхайн салбарт хийгдсэн төлбөрүүд, хүлээн авсан орлогуудыг шинжлэх, тулгаж шалгах (дээр дурдсан ажлын хамрах хүрээнд заасанчлан) ажлыг гүйцэтгэхэд нь ОҮИТБСАА-нд туслах дан ганц зорилготой байна.

Бидний гүйцэтгэх ажлын горим нь Аудитын олон улсын стандартын дагуу хийгдэх аудитын ажил, эсвэл Хяналт, шалгалтын гэрээт ажлын олон улсын стандартын дагуу хийгдэх хяналт, шалгалтын ажил биш тул баталгаа гаргахгүй.

Гаргасан мэдүүлгүүдийг шалгахад ашиглах мэдээллүүдэд уул уурхайн компаниудаас ОҮИТБСАА-нд гаргаж өгсөн мэдээлэл, Монгол улсын Сангийн яамнаас гаргаж өгсөн нэгтгэл мэдээлэл, дээр дурдсан төлбөр, орлогуудтай холбоотойгоор ОҮИТБСАА-нд гаргаж өгсөн бусад мэдээлэл багтаж байна.

Хэрэв дурдсан хоёр маягтад компанийн зүгээс Засгийн газарт төлсөн төлбөр, эсвэл Засгийн газрын компаниудаас хүлээн авсан төлбөр тайлагнагдаагүй орхигдсон байвал бидний ажил тэдгээрийг илрүүлэхэд хангалттай биш байх тул манай тайланд тэдгээрийн талаар дурдахгүй.

Бид ажлаа Засгийн газрын холбогдох нэгж байгууллагууд болон уул уурхайн компаниудаас хүлээн авсан мэдээлэл, тайлбарууд дээр тулгуурлан гүйцэтгэсэн болно.

Мөн энэ тайланг Монгол хэл дээр бэлтгэсэн болно. Англи, Монгол хувиудын хооронд зөрүүтэй эсвэл зөрчилтэй зүйл гарсан тохиолдолд Англи хувь хүчин төгөлдөр байх болно.


Манай тайланд 2009 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийг хүртэлх хугацаанд хүлээн авсан мэдээллүүдийг нэгтгэн оруулсан болно. Энэ өдрөөс хойш хүлээн авсан мэдээллүүдийг энэ тайланд оруулаагүй болно.

1.4 Талархал

Үүрэгт ажлаа гүйцэтгэх бүхий л хугацаанд бидэнд үнэтэй дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монголын ОҮИТБС-ын ажилтан ноён Шарын Цолмон болон хатагтай Түмэнжаргалын Хүрэлчимэг нарт Эрнст энд Янг компани чин сэтгэлийн талархал илэрхийлэхийг хүсч байна. Нэн ялангуяа ноён Цолмон Засгийн газрын харьяа байгууллагуудын болон уул уурхайн компаниудын гол албан тушаалтнуудтай уулзалт зохион байгуулахад бидэнд ихээхэн тусалсан ба энэ нь холбогдох мэдээллийг цаг хугацаанд нь авч энэхүү тайланг бэлтгэхэд чухал ач холбогдолтой байсан болно.

2. Арга хандлага

Дээр тодорхойлсон зорилт болон өөрсдийн ойлголт дээр үндэслэн бидний баримталсан арга хандлагыг дараах байдлаар хоёр үе шат болгон авч үзэж болох юм. Нэгдүгээр үе шат: Шинжилгээ ба нэгтгэл: Хоёрдугаар үе шат: Нягтлан шалгалт, үнэлгээ ба дүгнэлт:



Хоёр үе шатны гол зорилтуудыг дор дэлгэрэнгүй илэрхийлэв:

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: ШИНЖИЛГЭЭ ба НЭГТГЭЛ

Төслийн зохион байгуулалт ба бэлтгэл

Үндсэн зорилтууд:

- ▶ Гүйцэтгэх үүрэг болон үйл ажиллагааны явцыг тайлагнах графикийг тогтоож, зөвшилцсөн байх.
- ▶ Мэдээлэл цуглуулах болон ярилцлагын цаг товлоход туслах үүрэг бүхий Төслийн үйлчлүүлэгч хариуцсан зохицуулагч томилсон байх.
- ▶ Одоогийн тайлагнах үйл явц, зааварчилга болон журмын талаар урьдчилсан ойлголт авсан байх.

Шинжилгээ ба нэгтгэл

Үндсэн зорилтууд:

- ▶ Сонгож авсан уул уурхайн компаниуд болон холбогдох яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн засаг захиргаа \аймаг, сум,\, татварын газрууд, орон нутгийн байгууллагуудын Монгол Улсын Сангийн Ямаар дамжуулан бөглөж ирүүлсэн тайлангуудыг хүлээн авч шинжилсэн байх.
- ▶ 2007 оны татварын жилийн хувьд мөнгөн болон мөнгөн бус байдлаар Засгийн газрын хүлээн авсан болон компаниудын төлсөн төлбөрийг харьцуулсан байх.
- ▶ Засгийн газрын хүлээн авсан болон компаниудын төлсөн төлбөрт зөрүү гарсан үед уул уурхайн компаниудаас болон Засгийн газрын харьяа байгууллагуудаас дэлгэрэнгүй мэдээлэл хүссэн байх.
- ▶ Зөрүү болон уул уурхайн компаниуд ба Засгийн газрын харьяа байгууллагууд руу илгээсэн лавлагааг дэлгэрэнгүй тусгасан явцын тайлан бэлтгэж, урьдчилсан байдлаар илэрсэн асуудлуудыг мөн уг тайланд тусгасан байх.
- ▶ Явцын тайланг МОҮИТБС-ын ажлын албанд илгээсэн байх.

2. Арга хандлага \үргэлжлэл\

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ: НЯГТЛАН ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ ба АУДИТЫН ДҮГНЭЛТ

Шалгалт ба үнэлгээ

Үндсэн зорилтууд:

- ▶ Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул уурхайн компаниуд руу илгээсэн лавлагааны явцын тухай мэдээллийг шинэчилсэн байх.
- ▶ Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул уурхайн компаниудын ирүүлсэн тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг авч хянасан байх.
- ▶ Боломжтой тохиолдолд зөрүүгийн талаар өгсөн тайлбарыг дахин нягтлан шалгах замаар баталгаажуулсан байх.
- ▶ Холбогдох албан бичгүүдэд илэрсэн материаллаг зөрүүг шаардлагатай баримтаар баталгаажуулан бүртгэсэн байх.
- ▶ Гарсан асуудлуудыг тэмдэглэж, сайжруулах шаардлагатай салбарыг тодорхойлсон байх.

Дүгнэлт

Үндсэн зорилтууд:

- ▶ Мэдээлэл цуглуулж, тайлан бэлтгэсэн байх.
- ▶ Тайланг хэлэлцүүлэхээр МОУИТБС-ын ажлын албанд илгээсэн байх.

2.1 Бидний нарийвчилсан хандлага

Үүрэгт ажлаа гүйцэтгэхэд баримталсан нарийвчилсан хандлагыг энэ хэсэгт тусгасан болно. Бидний санал болгосон хандлагад ямарваа өөрчлөлт орсон бол өөрчлөлт оруулах болсон учир шалтгааныг энд мөн тайлбарласан байгаа.

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: ШИНЖИЛГЭЭ ба НЭГТГЭЛ

Төслийн зохион байгуулалт ба бэлтгэл

Үндсэн зорилтууд:

- ▶ Гүйцэтгэх үүрэгт ажил болон үйл ажиллагааны явцыг тайлагнах графикийг тогтоож, тохиролцсон байх.
- ▶ Мэдээлэл цуглуулах болон ярилцлагын цаг товлоход туслах үүрэг бүхий Төслийн үйлчлүүлэгч хариуцсан зохицуулагч сонгож томилсон байх.
- ▶ Одоогийн тайлагнах үйл явц болон зааварчилга, журмын талаар урьдчилсан ойлголттой болсон байх.

Нэгдүгээр үе шатны эхний хэсэгт дараах уулзалтуудыг зохион байгуулсан болно:

- ▶ Төслийн гүйцэтгэх ажлын хүрээ, арга хандлага болон ажлын явцыг тайлагнах цаг хугацааг баттай тохирох зорилгоор Төслийн үйлчлүүлэгч хариуцсан зохицуулагч ноён Шарын Цолмонтой анхлан уулзсан бөгөөд энэ үеэр дараах хугацааг тохирсон болно:
 - ▶ Нэгдүгээр үе шатыг 2009 оны тавдугаар сарын 11-нээс эхлүүлэх.
 - ▶ Нэгдүгээр үе шатыг 2009 оны зургадугаар сарын 5-нд дуусгавар болгох.
- ▶ Багаа танилцуулах, Засгийн газраас гаргасан тайланд орсон тоон үзүүлэлтүүдийн талаарх нэмэлт мэдээллийг Засгийн газрын харьяа ямар байгууллагаас авахыг тодорхойлох зорилгоор Монгол улсын Сангийн Яам болон Ашигт малтмалын газар \АМГ\ -ын төлөөлөгчидтэй уулзаж ярилцсан.

2. Арга хандлага \үргэлжлэл\

2.1 Бидний нарийвчилсан хандлага \үргэлжлэл\

- ▶ Багаа танилцуулж, ОҮИТБС-ын маягтын зүйл бүрээр мэдээллийн эх сурвалжийг батлах зорилгоор Засгийн газрын харьяа дараах байгууллагуудын төлөөлөгчидтэй уулзалт хийсэн. (Хавсралт А “Мэдээллийн эх сурвалж – Засгийн газрын харьяа байгууллагууд”-аас мэдээллийн эх сурвалжийг харна уу)
 - ▶ Монгол Улсын Үндэсний татварын ерөнхий газар \ҮТЕГ\
 - ▶ Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам \БОАЖЯ\
 - ▶ Монгол Улсын Гаалийн ерөнхий газар \ГЕГ\
 - ▶ Монгол Улсын Газрын тосны газар \ГТГ\
 - ▶ Монгол Улсын Төрийн өмчийн хороо \ТӨХ\
 - ▶ Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний газар \ХХҮГ\

Энэ тайланд хэрэглэсэн “Засгийн газрын харьяа байгууллагууд” гэсэн нэр томъёонд ЭБЭХЯ,ҮТЕГ,БОАЖЯ, ГЕГ, ГТГ, ТӨХ, ХХҮГ болон орон нутгийн \аймаг,сум\ засаг захиргааг хамруулсан болно.


Энэ үе шатанд одоогийн тайлагнах үйл явц, зааварчилга болон журмын талаар урьдчилсан ойлголттой болоход шаардлагатай мэдээлэл олж авсан.

- ▶ Монгол Улсын ОҮИТБС-ын 2007 оны нэгтгэсэн тайлан гаргахад зориулан уул уурхайн 186 компани \2006 онд 137 компани\-иас Засгийн газарт хийсэн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг, засгийн газарт хийсэн бусад төлбөр, тухайлбал бүтээгдэхүүн хуваах гэрээгээр засгийн газарт ногдох бүтээгдэхүүний төлбөр, мөнгөн хандив, тусламж зэргийг хүлээн авсан тухай Монгол Улсын Сангийн Яам \СЯ\-наас тайлагнасан.
- ▶ Гэвч зөвхөн 102 уул уурхайн компани \2006 онд 64 компани\ дээр дурдсан зүйл ангиар хийсэн төлбөрүүдээ Монгол Улсын ОҮИТБС-ын маягтаар тайлагнасан байна.
- ▶ Энэхүү үүрэгт ажлын хүрээнд Монгол Улсын ОҮИТБС-ын 2007 оны нэгтгэл ба тайлангийн тоон үзүүлэлтүүдийг шинжлэх зорилгоор Монгол Улсын ОҮИТБС нь 2007 оны татварын жилийн хувьд компаниудын төлбөрийн материаллаг түвшний доод хэмжээг 200 сая төгрөг байхаар тогтоосон.
- ▶ Дээр дурдсан сонгох шалгуурыг үндэс болгон Монгол Улсын ОҮИТБС үйл ажиллагааг нь шинжлүүлэхээр 38 компанийг сонгож авсан. Гэвч Монгол Улсын ОҮИТБС-д ирүүлсэн мэдээлэл бүрэн бус байснаас хоёр компанийг солиход хүрсэн ба үүнээс үүдэн дээр дурдсан шалгуурыг хангаагүй 200,000,000 төгрөгөөс доогуур хэмжээнд төлбөр хийсэн компаниуд сонголтод хамрагдсан байна. Хавсралт Б “Уул уурхайн компаниудын жагсаалт”-г үзнэ үү.

2. Арга хандлага \үргэлжлэл\


2.1 Бидний нарийвчилсан хандлага \үргэлжлэл\

- 2007 оны татварын жилд 38 компанийг хийсэн төлбөрүүдийнх нь хэмжээгээр ангилж, мөнгөн дүн тус бүрээр дор харуулав.



Эх сурвалж: МОУИТБСАА

- Үүнээс гадна, сонгон авсан уул уурхайн компаниудын ихэнх нь алт, алт болон мөнгө, нүүрс болон төмрийн хүдэр олборлох үйл ажиллагаа явуулж байгааг доорхи диаграммаас харж болно.




Эх сурвалж: МОУИТБСАА

2. Арга хандлага \үргэлжлэл\

2.1 Бидний нарийвчилсан хандлага \үргэлжлэл\

- Компаниуд болон Засгийн газрын төрөл бүрийн нэгж байгууллагуудын тухайд ОУИТБС-ын тайлагнах үйл явц ямар байгааг дараах байдлаар бидэнд танилцуулсан болно.



Эх сурвалж: МОУИТБСАА

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ:ШИНЖИЛГЭЭ ба НЭГТГЭЛ

Шинжилгээ ба нэгтгэл

Үндсэн зорилтууд:

- Сонгогдсон уул уурхайн компаниуд болон холбогдох яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн засаг захиргаа \аймаг, сум,\, татварын газрууд, орон нутгийн байгууллагуудын Монгол Улсын Сангийн Яамаар дамжуулан бөглөж ирүүлсэн тайлангуудыг хүлээн авч хянасан байх.
- 2007 оны татварын жилийн хувьд мөнгөн болон мөнгөн бус байдлаарх Засгийн газрын хүлээн авсан болон компаниудын төлсөн төлбөрийг харьцуулсан байх.
- Засгийн газрын хүлээн авсан болон компаниудын төлсөн төлбөрийн хооронд зөрүү гарсан үед уул уурхайн компаниудаас болон Засгийн газрын харьяа байгууллагуудаас нэмэлт мэдээлэл хүссэн байх.
- Зөрүү болон уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудад илгээсэн лавлагааг тусгасан явцын тайлан бэлтгэж, урьдчилсан байдлаар илэрсэн асуудлуудыг мөн уг тайланд тусгасан байх.
- Явцын тайланг МОУИТБС-ын ажлын албанд илгээсэн байх.

2. Арга хандлага \үргэлжлэл\

2.1 Бидний нарийвчилсан хандлага \үргэлжлэл\

- ▶ Монгол Улсын ОУИТБС-ын 2007 оны нэгтгэл ба тайланг гаргах зорилгоор 2007 оны татварын жилд Засгийн газрын хүлээн авсан төлбөр болон компаниудаас хийсэн төлбөрийг тайлагнахдаа дараах маягтуудыг ашигласан болно.
 - ▶ **ОУИТБС-ын маягт 1.** Энэхүү маягтыг уул уурхайн холбогдох компаниуд бөглөдөг ба түүнд тухайн татварын жилд Засгийн газрын харьяа байгууллагуудад хийсэн төлбөрийг нэгтгэн тайлагнадаг ба татвараас чөлөөлсөн буюу хөнгөлсөн, татварыг хассан зардал, тухайлбал ажилтнуудын сургалт, хөгжлийн зориулалттай зардал зэрэг мэдээллийг сайн дурын үндсэн дээр үүнд оруулдаг.
 - ▶ **ОУИТБС-ын маягт 3.** Яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн засаг захиргаа \аймаг, сум\ болон татварын газрууд зэрэг Засгийн газрын харьяа байгууллагууд тухайн татварын жилд уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийг ОУИТБС-ын маягт 2-т оруулж нэгтгэх зорилгоор УТЕГ-т хүргэдэг бөгөөд УТЕГ ОУИТБС-ын маягт 3-ыг бөглөж нэгтгэсэн тайлан гаргадаг.
- ▶ ОУИТБС-ын маягт 1-ын дагуу тайлагнасан дараах зүйл ангиудыг гүйцэтгэх ажлын хүрээнээс хассаныг МОУИТБСАА нотолсон. Үүнд:
 - ▶ Хүрээ 1: Орлого ба ашгийн урсгал, тоон үзүүлэлт, Нэгдүгээр хэсэг. Үйлдвэрлэсэн болон худалдсан бүтээгдэхүүн.
 - ▶ Хүрээ 2: Орлого ба ашгийн урсгал (Сайн дурын үндсэн дээр)
- ▶ Сонгогдсон уул уурхайн компаниудаас 2007 оны татварын жилийн хувьд бөглөсөн бүх маягтыг (ОУИТБС-ын маягт 1) МОУИТБС-аас ирүүлсэн. Мөн УТЕГ-ын Мэпээллийн технологи, статистикийн хэлтсээс бөглөсөн тайлангийн маягт (ОУИТБС-ын маягт 3)-ын цахим хувилбарыг Монгол улсын Сангийн Яамнаас МОУИТБС –д ирүүлсэн байсан.
- ▶ Сангийн Яамнаас хүлээн авсан тайлангийн маягт (ОУИТБС-ын маягт 3)-ын цахим хувилбарыг болон бие даасан янз бүрийн компанийн хийсэн төлбөрүүдийн мэдээллийн Эксел хувилбарыг МОУИТБСАА-наас ирүүлсэн.
- ▶ ОУИТБС-ын маягт 1 болон 3-аар тайлагнасан сонгогдсон компани нэг бүрийн тоон үзүүлэлтүүдийг зүйл тус бүрээр харьцуулан шинжилсэн.
- ▶ ОУИТБС-ын Маягт 1 болон Маягт 3-т заасан мөнгөн дүнгийн хооронд үүссэн зөрүү бүр дээр уул уурхайн холбогдох компаниудаас хийсэн төлбөр болон Засгийн газрын харьяа байгууллагуудын хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлэх хүсэлт тавьсан.
- ▶ Илэрсэн дараах зөрүүний талаар мэдээлэл өгөхийг хүссэн. Үүнд:
 - ▶ Засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламж.
 - ▶ Холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн улсын бүртгэлийн тэмдэгтийн болон бусад хураамж.
 - ▶ Холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн үйлчилгээний хураамж.
 - ▶ “Бусад” гэсэн зүйл ангиар тайлагнасан зарим төлбөр.

Эхлээд холбогдох компаниудад хандан нарийвчилсан мэдээлэл өгөх хүсэлт тавьсан. Холбогдох уул уурхайн компаниудаас нарийвчилсан мэдээлэл авсны дараа Сангийн Яамаар дамжуулан Засгийн газрын холбогдох нэгж байгууллагуудад хандан нарийвчилсан мэдээлэл өгөхийг хүссэн. Гэвч Сангийн Яам дээрх асуудлаар байгууллага нэг бүрт, мөн яам, агентлагууд болон орон нутгийн засаг захиргаа \аймаг, сум\-нд шууд хандаж илүү тодорхой мэдээлэл авахыг Зөвлөгч нарт зөвлөсөн.

2. Арга хандлага \үргэлжлэл\

2.1 Бидний нарийвчилсан хандлага \үргэлжлэл\

- ▶ Мэдээлэл өгөх хүсэлтийг холбогдох компаниудад 2009 оны тавдугаар сарын 23-нд, Засгийн газрын нэгж байгууллагуудад 2009 оны тавдугаар сарын 29-нд тус тус тавьсан болно. Уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудад захидал илгээсэн өдрөөс эхлэн хоёр долоо хоногийн дотор мэдээлэл өгөхийг хүсэлт болгосон.
- ▶ Уул уурхайн компаниуд дараах хугацаанд хариу ирүүлсэн.

Хугацаа	2 долоо хоногийн дотор (5-р сарын 25- наас 6-р сарын 5)	2 долоо хоногийн дараа (6-р сарын 5)	Анхны сануулах захидал явуулсны дараа (6-р сарын 19)	2009.06.26-ны өдрийн байдлаар хариу ирүүлээгүй
Компанийн тоо	2	17	7	12

- ▶ Засгийн газрын нэгж 7 байгууллагаас 3 нь нарийвчилсан мэдээлэл үгүй хариуг, 2 нь зургадугаар сарын хоёр дахь долоо хоногт, нэг нь мөн сарын сүүлийн долоо хоногт тус тус ирүүлсэн.
- ▶ Нийтдээ гурван удаа Сануулах захидал явуулахаас зөвхөн эхний захидлыг 2009 оны зургадугаар сарын 19-нд хариу ирүүлээгүй Засгийн газрын харьяа байгууллагуудад болон уул уурхайн компаниудад илгээсэн. Иймд компаниуд дээр биеэр очиж уулзах нь илүү үр дүнтэй болох нь ажиглагдсан.
- ▶ Иймээс тайланд дурдсан тоон үзүүлэлтийн талаар баталгаа авах, нарийвчилсан мэдээлэл болон тайлбар авах зорилгоор уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудтай уулзалт хийсэн.
- ▶ ГЕГ болон БОАЖЯ-ны гол албан тушаалтнууд эзгүй байсан тул шаардлагатай мэдээллийг олж авч чадаагүй. Тэдний оронд Зөвлөгч нар дараах албан тушаалтнуудтай уулзсан:
 - ▶ ГЕГ-ын Мэдээллийн технологи, статистикийн хэлтсийн даргатай уулзаж туслалцаа хүссэн ба тэрээр ГЕГ-ын мэдээллийн сангаас мэдээлэл өгсөн.
 - ▶ БОАЖЯ-ны хувьд тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50% болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлын талаар нарийвчилсан мэдээлэл өгөхийг хүссэн захидлыг СЯ-ны Төрийн сангийн газарт илгээсэн боловч тэдэнд тийм мэдээлэл байхгүй байсан учраас ямарваа мэдээлэл өгч чадаагүй.
- ▶ Үүнээс гадна ҮТЕГ анхандаа ногдол ашгийн талаар мэдээлэл өгөөгүй бөгөөд ЭБЭХЯ-нд хандахыг Зөвлөгч нарт зөвлөсөн. Гэвч ЭБЭХЯ ямар хэмжээний төлбөр авснаа мэдэхгүй байсан тул мэдээлэл өгч чадаагүй.
- ▶ Холбогдох уул уурхайн компаниудаас мэдээлэл авсныхаа дараа дор дурдсан зүйлүүдээр баталгаа ирүүлэх хүсэлтийг Засгийн газрын холбогдох байгууллагуудад илгээсэн:
 - ▶ Засгийн газрын харьяа байгууллагуудад өгсөн хандив, тусламж
 - ▶ Холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн үйлчилгээний хураамж
 - ▶ Холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн улсын бүртгэлийн тэмдэгтийн болон бусад хураамж
 - ▶ “Бусад” гэсэн зүйл ангиар тайлагнасан зарим төлбөр
- ▶ Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул уурхайн компаниудаас төлбөрийн холбогдолтой нарийвчилсан мэдээллийн талаар ихэнх хариу ирсний дараа 2009 оны долдугаар сарын 20-нд үүрэгт ажлын хоёрдугаар үе шат эхэлсэн.

2. Арга хандлага \үргэлжлэл\

2.1 Бидний нарийвчилсан хандлага (үргэлжлэл)

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ: НЯГТЛАН ШАЛГАЛТ, ҮНЭЛГЭЭ БА ДҮГНЭЛТ

Нягтлан шалгалт ба үнэлгээ

Үндсэн зорилтууд:

- ▶ Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул уурхайн компаниудад илгээсэн лавлагааны явцын тухай мэдээллийг шинэчилсэн байх.
 - ▶ Засгийн газрын харьяа байгууллагууд болон уул уурхайн компаниудын ирүүлсэн задаргааны нарийвчилсан жагсаалтыг авч хянасан байх.
 - ▶ Боломжтой тохиолдолд зөрүүгийн талаар өгсөн тайлбарыг дахин хянаж үзэх замаар баталгаажуулсан байх.
 - ▶ Холбогдох албан баримтуудад илэрсэн материаллаг зөрүүг шаардлагатай баримтаар баталгаажуулан бүртгэсэн байх.
 - ▶ Гарсан асуудлуудыг тэмдэглэж, сайжруулах шаардлагатай салбарыг тодорхойлсон байх.
-
- ▶ Хүссэн бүх мэдээлэл ирсэн эсэхийг тогтоох үүднээс Засгийн газрын нэгж байгууллагууд болон уул уурхайн компаниудад илгээсэн лавлагааны явцын тухай мэдээллийг шинэчилсэн .
 - ▶ Уул уурхайн компаниудаас мэдээлэл урьтаж ирсэн тул илэрсэн зөрүүтэй холбогдуулж дараах үйл ажиллагааг явуулсан:
 1. Ирүүлсэн мэдээлэл нь ОУИТБС-ын маягт 1–ээр тайлагнасан тоон үзүүлэлттэй нийцэж байгааг баталгаажуулсан. Аливаа материаллаг дүнтэй өөрчлөлтийн үндэслэлийг гаргуулж авсан.
 2. Анх тайлагнасан тоон үзүүлэлтэд оруулсан өөрчлөлт бүрийг Засгийн газраас тайлагнасан тоон үзүүлэлттэй харьцуулан тулгасан.
 3. Ямар нэгэн зөрүү гараагүй тохиолдолд өөр арга хэмжээ цаашид аваагүй.
 4. Зөрүү гарсан тохиолдолд нэмэлт лавлагаа авсан.
 - ▶ Засгийн газрын нэгж байгууллагуудаас мэдээлэл авсны дараа ОУИТБС-ын маягт 3–аар тайлагнасан тоон үзүүлэлтүүдийн талаар дээр дурдсантай ижил үйл ажиллагаа явуулсан.
 - ▶ Цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай асуудлын тухайд дараах үйл ажиллагаа явуулсан:
 1. Зөрүү үүсэхэд хүргэсэн байж болох учир шалтгааныг тогтоох үүднээс төлбөрүүдийн нарийвчилсан задаргаа болон төлбөр хүлээн авсан баримтуудыг хянан үзсэн.
 2. Зөрүүг тогтоосны дараа тэдгээрийг бүртгэж, холбогдох компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудтай уулзах, и-мэйл бичих, утсаар ярих замаар тайлбар авсан.
 3. Бүх материаллаг зөрүүний хэмжээг тогтоож, энэ тайлангийн 3–р хэсэгт боломжтой газар нь холбогдох талуудаас өгсөн тайлбарын хамт тусган оруулсан.
 - ▶ Энэхүү гэрээт ажлын үр дүн, олж илрүүлсэн зүйлүүдийг 2009 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр МОУИТБС-ын ажлын хэсэгт танилцуулсан болно.
 - ▶ Уг танилцуулгын дараа МОУИТБС-ын ажлын хэсэг Зөвлөхүүдээс шийдэгдээгүй, материаллаг дүнтэй зөрүүнүүдийг Засгийн газрын харьяа байгууллагуудаас лавлаж шийдэхийг хүссэн. Энэхүү хүсэлтийг биелүүлэх үүднээс эцсийн тайланг гаргаж өгөх хугацааг сунгасан.

3. Тодруулга

Энэ хэсэгт нэгтгэлийн нийт үр дүнг харуулсан бөгөөд Засгийн газрын нэгж байгууллагууд болон компаниудаас ОУИТБС-ын маягтын дагуу гаргаж ирүүлсэн тайлангийн зүйл бүрд хамааралтай нийтлэг асуудлууд буюу илэрсэн зөрүүний шалтгааныг нэгтгэн дүгнэсэн.

Энэ хэсгийг тайлангийн дараахь хавсралтуудтай холбон унших ёстой. Үүнд:

- ▶ **Хавсралт В** – Компани нэг бүрийн тайлан. (Компани нэг бүрээр тайлагнасан дүнгүүдийг тулган шалгаж, шинжилсэн ажлын үр дүн харуулсан)
- ▶ **Хавсралт Г** – Анхны зөрүүнүүд. (Компани нэг бүрийн, үзүүлэлт нэг бүр дээр анхлан гарсан зөрүүнүүдийн жагсаалт)
- ▶ **Хавсралт Д** – Компанийн болон Засгийн газрын тайлангуудад хийсэн цэвэр залруулгууд (Компани нэг бүрийн, үзүүлэлт нэг бүр дээр гарсан бүх цэвэр залруулгуудын жагсаалт)
- ▶ **Хавсралт Е** – Шийдэгдээгүй зөрүүнүүд. (Компанийн нэг бүрийн шийдэгдээгүй зөрүүнүүдийн жагсаалт)

Тайланд орсон бүх тоон үзүүлэлт нь өөрөөр тодорхойлоогүй бол монгол төгрөгөөр илэрхийлэгдсэн болно. Компанийн тайлагнасан дүн нь Засгийн газрын тайлагнасан дүнгээс илүү байгаа бол дүнг хаалтанд хийсэн.

3.1 Анхан шатны харьцуулалт

Нэгдүгээр үе шатанд Засгийн газрын харьяа байгууллагууд болон компаниудаас гаргасан тайланг үндэслэн анхан шатны харьцуулалт хийсэн бөгөөд ОУИТБС-ын маягтын зүйл тус бүрээр илэрсэн цэвэр зөрүүг доорх хүснэгтээр харуулав.

Хэсгүүд	Засгийн газрын нэгж байгууллагуудын тухайд (мян.төг)	Компаниудын тухайд (мян.төг)	Зөрүү (мян.төг)
а) Татвар	485,995,569	541,717,007	(55,721,438)
б) Хураамж	108,739,039	123,453,990	(14,714,951)
в) Төлбөр болон үйлчилгээний хураамж	22,397	2,230,353	(2,207,956)
г) Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	138,635,635	79,662,181	58,973,454
д) Хүлээн авагч Засгийн газарт хийсэн бусад төлбөр	7,690,371	11,673,994	(3,983,623)
е) Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж	1,776,238	6,543,559	(4,767,321)
ё) Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	5,923,712	6,944,238	(1,020,526)
Нийт зөрүү			(23,442,361)

Дээрх хүснэгтэд “цэвэр” зөрүү (23,442,361) мянган төгрөг гэж харуулсан хэдий ч, цэвэр зөрүү нь дараахь хоёр дүнгийн зөрүү гэдгийг тодруулахгүй бол буруу ойлголт төрүүлж магадгүй. Үүнд:

	(мян.төг)
Компанийн тайлагнасан дүн нь Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүнгээс их	(82,415,815)
Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүн нь компанийн тайлагнасан дүнгээс их	58,973,454

3. Тодруулга \үргэлжлэл\

3.1 Анхан шатны харьцуулалт (үргэлжлэл)

Анхан шатны харьцуулалтын явцад зарим компани НӨАТ, ажил олгогчид болон ажилтнуудаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, даатгалын төлбөр болон компаниас орон нутгийн байгууллагуудад өгсөн нийт 27,221,026 мянган төгрөгийн мөнгөн хандив зэргийг тайландаа оруулсан байсан нь тогтоогдов.

Эдгээр зүйлийг тайлагнах шаардлагагүй ба үүний улмаас компанийн тайлагнасан татвар болон мөнгөн хандивын дүн өндөр болоход хүргэсэн. Тэдгээрийг хассанаар цэвэр зөрүүний дүн (23,442,361) мянган төгрөгөөс 3,778,665 мянган төгрөг болон буурахад нөлөөж байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хэсгүүд	Засгийн газрын нэгж байгууллагуудын тухайд (мян.төг)	Компаниудын тухайд (мян.төг)	Зөрүү (мян.төг)
а) Татвар	485,995,569	518,023,089	(32,027,520)
б) Хураамж	108,739,039	123,453,990	(14,714,951)
в) Төлбөр болон үйлчилгээний хураамж	22,397	2,230,353	(2,207,956)
г) Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	138,635,635	79,662,181	58,973,454
д) Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөр	7,690,371	11,673,994	(3,983,623)
е) Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж	1,776,238	3,016,451	(1,240,213)
ё) Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	5,923,712	6,944,238	(1,020,526)
Нийт зөрүү			3,778,665

Дээр дурьдсан зүйлүүдийг хассаны дараа цэвэр зөрүүний дүн дараахь дүнтэй болж өөрчлөгдсөн. Үүнд:

	(мян.төг)
Компанийн тайлагнасан дүн нь Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүнгээс их	(55,194,789)
Засгийн газрын байгууллагын тайлагнасан дүн нь компанийн тайлагнасан дүнгээс их	58,973,454

Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийг оролцуулахгүйгээр ихэнх зөрүү компаниудын тайлагнасан тоон үзүүлэлт Засгийн газрын нэгж байгууллагуудын хүлээн авсан төлбөрийн дүнгээс дээгүүр байгаатай холбоотойг дээрх хүснэгтээс харж болно.

Гол зөрүүнүүд татвар, хураамж, мөн төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн хэсгээс гарч байна.

Татварын хэсэгт илэрсэн гол зөрүү аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, гаалийн татвар, зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвараас үүссэн бөгөөд 8,863,564 мянган төгрөг (28%), 14,347,295 мянган төгрөг (45%), 8,258,502 мянган төгрөг (26%)-тэй тус тус тэнцэж байна.

Хураамжийн хэсэгт илэрсэн зөрүүнүүд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын татвар болон гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөрөөс үүсэлтэй бөгөөд 2,448,533 мянган төгрөг (17%), 9,411,530 мянган төгрөг (64%) болон 1,275,101 мянган төгрөг (9%)-тэй тус тус тэнцэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашгийн хэсэгт илэрсэн зөрүүнүүд нь УТЕГ төрийн өмчийн ногдол ашигт хүлээн авсан төлбөрийн хэмжээг дээгүүр тайлагнасантай гол төлөв холбоотой байна.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ

Дээр дурдсан зөрүүнүүдийн нэгтгэсэн дүнг тайлагнасан зүйл бүрээр дараах байдлаар задлан шинжилж болох юм. Энэ тайлангийн 3.1-д үзүүлсэн анхны дүнгүүдийг харьцуулж үзсний дараа зүйл нэг бүр дээр гарсан анхны зөрүүнүүдэд хийгдсэн залруулгуудыг тайлангийн энэ хэсэгт тайлбарлах болно. Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн энэ тайлангийн 3.3-р хэсэгт дэлгэрүүлэн тайлбарласан болно.

Залруулга хийх болсон хамгийн нийтлэг шалтгаан нь (бараг бүх зүйл дээр) дүнг анх тайлагнахдаа алдаатай тайлагнасан гэсэн шалтгаан байсан. Эдгээр алдаа нь голдуу санаандгүй орхигдуулсан, мөн түүнчлэн бичихдээ алдаатай бичсэн зэргийг улмаас гарсан байсан. Дүнгүүдийг тулган баталгаажуулж байх үед эдгээр алдааны зарим нь материаллаг дүнтэй байгааг олж мэдсэн.

Өмнөх хүснэгтэд үзүүлсэн зүйл нэг бүр дээр гарсан нийт зөрүүнүүдийг дараахь байдлаар шинжилсэн болно.

а\ Татвар

“Татвар” гэсэн хэсэгт үзүүлсэн татварын төрөл нэг бүр дээр дараахь нийт зөрүү гарсан. Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
ААНОАТ	(8,863,564)	8,681,430	(182,134)
Гаалийн албан татвар	(14,347,295)	14,336,682	(10,613)
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн татвар	(8,258,502)	586,697	(7,671,805)
Үл хөдлөх хөрөнгийн татвар	4,930	(5,503)	(573)
Импортлосон шатах, тослох материалын онцгой албан татвар	1,147,502	(1,185,991)	(38,489)
Автобензин болон дизель түлшний албан татвар	(93,085)	98,946	5,861
Автомашин, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	4,835	9,070	13,905
Мөнгөн хэлбэрийн бусад татвар /1/	(298,626)	-	(298,626)
Мөнгөн хэлбэрийн бусад татвар /2/	(1,323,715)	1,323,467	(248)
Нийт	(32,027,520)	23,844,798	(8,182,722)

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
ААНОАТ	(8,863,564)	8,681,430	(182,134)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Петро Чайна Дачин Тамсаг ХХК нь гаалийн татварын төлбөрийг ААНОАТ-ын төлбөр гэж тайлагнасан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

a\ Татвар \үргэлжлэл\

1. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар \үргэлжлэл\

- ▶ 2007 онд төлсөн ААНОАТ-ын төлбөрийг л тайлагнах ёстой байсан. Гэсэн хэдий дараахь компаниуд ААНОАТ-ын өглөгийн дүнг оруулж тайлагнасан байсан. Үүнд:
 - ▶ Шим Технологи ХХК ба Шижир Алт ХХК нь 2007 онд төлсөн ААНОАТ-ын дүнг биш уг татварын өглөгийн дүнг тайлагнасан байсан.
 - ▶ Эрдэс Холдинг ХХК нь 2007 онд төлсөн ААНОАТ-ын дүнг тайлагнаагүй. Учир нь энэ төлбөр 2006 оны ААНОАТ-ын өглөгтэй холбоотой байсан.
- ▶ ААНОАТ-ын төлбөрийг НӨАТ-ын буцаан авалт эсвэл урьдчилж төлсөн татварын дүнгээс суутган төлсөн байсан. Үүнд:
 - ▶ Шивээ Овоо ХК нь НӨАТ-ын буцаан авалтаас суутган төлсөн байсан учраас ямар нэгэн дүнг тайлагнаагүй
 - ▶ Дацан Трэйд ХХК нь 2006 онд төлсөн татварын илүү төлөлтийн дүнг тайлагнасан байсан. Энэ дүнг 2007 ААНОАТ-ын дүнд суутгасан байсан.
- ▶ Зарим компани татварын хэмжээг тайлагнахдаа түүнд тайлагнах ёсгүй хувь хүний ашиг орлогын албан татвар, татварын хураамж болон торгуулийн төлбөрийг оруулсан байсан. Энэ нь дараах компаниуд дээр гарсан:
 - ▶ Монголын Алт \МАК\ корпораци ХХК хувь хүний орлогын албан татварын төлбөрийг оруулсан байсан.
 - ▶ Бороо Гоулд ХХК Ба Монгол-Чех Металл ХХК татварын торгуулийн төлбөрийг оруулсан байсан.
- ▶ ҮТЕГ Бороо Гоулд ХХК болон Тэфис Майнинг ХХК-ийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварт хийсэн төлбөрийг өөр татварын төлбөр хэмээн буруу бүртгэсэн байсан.
- ▶ Эрдэнэт уул уурхайн корпораци нь ААНОАТ-ын төлбөрт гадаадын аж ахуйн нэгжээс суутган авсан орлогын албан татварын дүнг оруулсан байсан боловч ҮТЕГ энэ төлбөрийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төлбөр гэж бүртгээгүй байсан.
- ▶ Гоби Коул энд Энержи ХХК нь Түлш Алтай ХХК-ын тэдний өмнөөс хийсэн төлбөрийг тайландаа оруулаагүй байсан. Нэгэнт тус компани татварын газарт бүртгэлтэй, ногдсон татварыг төлөх үүрэгтэй тул тэд холбогдох өр төлбөр ба төлбөрийг оруулж тайлагнах ёстой байсан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

a\ Татвар \үргэлжлэл\

2. Гаалийн албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Гаалийн албан татвар	(14,347,295)	14,336,682	(10,613)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Дээр дурьдсанчлан Петро Чайна Дачин Тамсаг ХХК нь гаалийн татварын төлбөрийг ААНОАТ-ын төлбөр гэж тайлагнасан.
- ▶ Компаниудын анх тайлагнасан дүнд импортолсон шатах, тослох материалын онцгой албан татвар, НӨАТ зэрэг өөр татварын төлбөрийг оруулсан байсан. Жишээ нь:
 - ▶ Анхлан Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь ГЕГ-ын тайлагнасан дүнгээс илүү өндөр дүнг гаалийн татварт төлсөн тайлагнасан байсан. Гэвч энэхүү тайлагнасан дүнд импортолсон шатах, тослох материалын онцгой албан татвар, автобензин, дизелийн түлшний татвар, гаалийн үйлчилгээний төлбөр болон НӨАТ-ыг оруулж тооцсон байсныг тогтоосон.
 - ▶ Болд Төмөр Ерөө Гол компанийн анх тайлагнасан нь дүн нь НӨАТ-ын төлбөр байсан тул үүнийгээ залруулж зөв болгосон.
 - ▶ Дацан Трэйд ХХК хувь хүний орлогын татварт төлсөн дүнг гаалийн татвар гэж буруу тайлагнасан байсан.
- ▶ ГЕГ нь ихэнх компаниас хүлээн авсан төлбөрийн анх тайлагнасан дүнг өөрчилсөн ба үүнийг ОУИТБС-ын маягтыг бөглөх зорилгоор зөвхөн “дотоодын хэрэгцээнд зориулан импортолсон бараа”-ны гаалийн татварт хүлээн авсан төлбөрийг тайлагнасан, харин компаниуд тоон үзүүлэлтэд гаальтай холбоотой бүх төлбөрийг оруулсан гэсэн тайлбар өгсөн. Иймд ГЕГ-ын системээс холбогдох тоо баримтыг олж авсны дүнд дараахь компаниудын тоон үзүүлэлтүүд дээр өөрчлөлт орсон байна. Үүнд:
 - ▶ Бороо Гоулд ХХК
 - ▶ Чинхуа Мак ХХК
 - ▶ Коулд Гоулд Монгол ХХК
 - ▶ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр
 - ▶ Эрдмин ХХК
 - ▶ Гоби Коул энд Энержи ХХК
 - ▶ Айвенхоу Майнс Монгол Инк. ХХК
 - ▶ Жамп ХХК
 - ▶ ПетроЧайна Дачин Тамсаг ХХК
 - ▶ Шин Шин ХХК
 - ▶ Тефис Майнинг ХХК

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

a\ Татвар \үргэлжлэл\

2. Гаалийн албан татвар \үргэлжлэл\

- ▶ Импортлолсон шатах, тослох материалын онцгой албан татвар, гаалийн үйлчилгээний хураамж, НӨАТ болон ачаа тээвэрлэлтийн ажилтнуудад хийсэн төлбөрийг нийтэд нь нэгтгэн тайлагнаж, нарийвчилсан мэдээлэл өгөөгүй тул зарим компаниудын хувьд гаалийн татварын хэмжээг тодорхойлох боломжгүй байна. Энэ нь дараах компаниуд дээр гарч байна. Үүнд:
 - ▶ Шин Шин ХХК нь тодорхой тооны төлбөрүүдийг тайландаа оруулаагүй ба ГЕГ мөн хүлээн авсан хэд хэдэн төлбөрийг тайлагнаагүй байсан.
 - ▶ Адамс Майнинг ХХК-ийн хувьд, ГЕГ-ын тайлагнасан дүнд компанийн төлсөн төлбөр ороогүй байсан.
 - ▶ Говь Коул энд Энержи компани нь зөвхөн хайгуулын лицензтэй холбоотой төлбөрийг тайлагнах ёстой гэсэн буруу ойлголттой байснаас олборлолтын лицензтэй холбоотой төлбөрийг оруулаагүй байсан.
- ▶ Шижиер Алт компани 2007 оны гаалийн татварт хийсэн төлбөрийн дүнг бус, гаалийн албан татварын глгийн днг тайлагнасан байсан.

3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	(8,258,502)	586,697	(7,671,805)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Шивээ Овоо ХК үл хөдлөх хөрөнгийн албан татварыг төлбөрийг зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын төлбөрөөр тайлагнасан байсан.
- ▶ Дараахь компаниуд 2007 онд төлсөн татварын дүнг бус, төлбөл зохих татварын дүнг тайлагнасан байсан.
 - ▶ Шижиер Алт ХХК
 - ▶ Гацуурт ХХК
 - ▶ Буд Инвест ХХК
 - ▶ Монполиммет ХХК
- ▶ Эрдэс холдинг ХХК 2006 онд борлуулсан алттай холбоотой татварын төлбөрийг 2007 онд хийсэн тул дүнг тайлагнаагүй орхисон. Нэгэнт төлбөр 2007 онд хийгдсэн учир төлбөрийг зохих ёсоор тайлагнах ёстой байсан.
- ▶ Мон Дулаан Трэйд ХХК нь торгууль, шимтгэлд төлсөн төлбөрийг тайландаа оруулсан байсан. Зүй ёсондоо үүнийг тайлагнасан тоон үзүүлэлтээс хасах хэрэгтэй байсан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

a\ Татвар \үргэлжлэл\

4. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	4,930	(5,503)	(573)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Дээр тайлбарласанчлан, Шивээ Овоо ХК нь ҮХХ-ийн татварт төлсөн дүнгээ зарим бүтээгдэхүүний үний өсөлтийн татварын төлбөр гэж тайлагнасан байсан.
- ▶ Шанлун ХХК нь 2007 бодитоор төлсөн татварын дүнг биш татварын өглөгийн дүнг тайлагнасан байсан.
- ▶ ҮТЕГ нь Бороо Гоулд ХХК-ны 2006 онд төлсөн төлбөрийг хүлээн авсан татварын дүнд оруулсан байсан. 2006 онд хийсэн төлбөрийн дүнг оруулах ёсгүй байсан.
- ▶ Цайрт Минерал ХХК нь газрын нөхөн төлбөрийн дүнг оруулж тайлагнасан байсан. Энэ төлбөрийг оруулах ёсгүй байсан.

5. Импортлолсон шатах, тослох материалын онцгой албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Онцгой албан татвар	1,147,502	(1,185,991)	(38,489)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь импортлолсон шатах, тослох материалын онцгой албан татварт төлсөн дүнг гаалийн албан татварын дүнд оруулсан байсан.

6. Автобензин болон дизелийн түлшний албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Автобензин болон дизель түлшний албан татвар	(93,085)	98,946	5,861

Энэ татварын хувьд анхны зөрүүнд хийгдсэн залруулгууд нь ҮТЕГ нь Петро Чайна Дайчин Тамсаг ХХК болон Жамп ХХК-аас хүлээн авсан татварын дүнг дахин нягталж, анх тайлагнасан дүнгээ өөрчилж тайлагнаснаас болж үүссэн.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

a\ Татвар \үргэлжлэл\

7. Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	4,835	9,070	13,905

Энэ татварын хувьд анхны зөрүүнд хийгдсэн залруулгууд нь УТЕГ нь Монросцвемет ХХК-ийн Хэнтий аймаг, Улаанбаатар хот, Төв аймгийн татварын хэлтэст тушаасан зарим нэг төлбөрүүдийг орхигдуулж тайлагнаснаас үүссэн.

8. Мөнгөн хэлбэрийн бусад татвар \2\

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Мөнгөн хэлбэрийн бусад татвар (2)	(1,323,715)	1,323,467	(248)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Чинхуа МАК ХХК нь өөрийн компанийн Хятад талын хувьцаа эзэмшигчид олгосон ногдол ашгаас суутган авч татварт шилжүүлсэн хувь хүний орлогын албан татварын төлбөрийг тайлагнасан байсан.
- ▶ Бүүргэнт ХХК нь өөрийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг тайлагнасан байсан.

МОУИТБС-ын маягтад хувь хүний орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн дүнг тайлагнах шаардлагагүй ба тиймээс хасах хэрэгтэй.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр

“Төлбөр” гэсэн хэсэгт орсон зүйл нэг бүр дээр дараахь нийт зөрүүнүүд гарсан.
Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (“Роялти”)	(2,448,533)	(1,318,181)	(1,130,352)
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	102,974	(170,060)	(67,086)
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	(411,277)	101,083	(310,194)
Газрын төлбөр	(9,411,530)	9,284,738	(126,792)
Ус, рашаан ашигласны төлбөр	(666,722)	110,054	(556,668)
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	(974)	250	(724)
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	(1,275,101)	1,015,955	(259,146)
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(602,396)	592,497	(9,899)
Бусад	(1,392)	1,392	-
Нийт	(14,714,951)	12,254,090	(2,460,861)

1. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр \ “Роялти” \

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(2,448,533)	(1,318,181)	(1,130,352)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Эрдмин ХХК ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төлсөн дүнг ашигт малтмалын ашиглалт ба хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр гэж тайлагнасан.
- ▶ Петро Чайна Дачин Дамсаг ХХК нь Газрын тосны газарт төлсөн сургалтын төлбөрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр гэж тайлагнасан.
- ▶ УТЕГ нь Шарын гол ХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны илүү төлөлтийг оруулж тайлагнасан байхад Шарын гол ХК нь зөвхөн 2007 онд төлөх ёстой төлбөрийн дүнг тайлагнасан байна.
- ▶ Таван Толгой ХХК нь УТЕГ-ын тайлагнасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ба татварын торгуульд төлсөн дүнг тайлагнаагүй байна.
- ▶ УТЕГ-ын тайлагнасан дүнд зарим нэг төлбөрийн гүйлгээ ороогүй орхигдсон байсан. Энэ нь Болд Төмөр Ерөө Гол ХХК ба Монголросцветмет ХХК -иудын хувьд тохиолдсон.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр \үргэлжлэл\

2. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	102,974	(170,060)	(67,086)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Дээр тайлбарласанчлан, Эрдмин ХХК ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төлсөн дүнг ашигт малтмалын ашиглалт ба хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр гэж тайлагнасан.
- ▶ Гоби Коул энд Энержи компани нь зөвхөн хайгуулын лицензтэй холбоотой төлбөрийг тайлагнах ёстой гэсэн буруу ойлголттой байснаас олборлолтын лицензтэй холбоотой төлбөрийг оруулаагүй байсан.
- ▶ Монголын Алт (МАК) корпораци ХХК нь АМГ-ын тайлагнаагүй үйлчилгээний хөлс, лицензийн сунгалтын төлбөрийг оруулж тайлагнасан байсан.
- ▶ Элтрана ХХК нь АМГ-ын тайлагнаагүй 2006 онд төлсөн урьдчилгаа төлбөр, лицензийн сунгалтын төлбөр, лиценз шилжүүлсний төлбөрийг оруулж тайлагнасан байсан.
- ▶ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь өөр компанийн төлсөн лицензийн нөхөн төлбөрийг оруулаагүй байсан ба АМГ-ын тайлагнаагүй лицензийн сунгалтын төлбөрийг оруулж тайлагнасан байсан.
- ▶ Адамс Майнинг ХХК ба Тефис Майнинг ХХК-ийн хувьд, АМГ нь 2006 онд хүлээн авсан лицензийн төлбөрийг оруулсан байсан. Адамс Майнинг ХХК-ийн 2008 онд хийсэн зарим нэг төлбөрийг оруулсан байсан.
- ▶ Айвенхоу Майнз ХХК-ийн хувьд АМГ нь уг компанийн холбоотой компанийнх нь лицензийн төлбөрийг оруулсан байсан.
- ▶ Зарим нэг төлбөрийн гүйлгээ компаниудын болон АМГ-ын тайланд ороогүй байсан. Энэ нь дараахь компаниуд дээр ажиглагдсан. Үүнд:

Компанийн тайланд

- ▶ Гоби Коул энд Энержи ХХК
- ▶ Дацан Трэйд ХХК
- ▶ Эрдэс Холдинг ХХК
- ▶ Мон Дулаан Трэйд
- ▶ Жамп ХХК

АМГ-ын тайланд

- ▶ Бороо Гоулд ХХК
- ▶ Дацан Трэйд ХХК
- ▶ Эрдэс Холдинг ХХК
- ▶ Жамп
- ▶ Мон Дулаан Трэйд ХХК
- ▶ Монголросцветмет ХХК
- ▶ Монголын Алт (МАК) ХХК
- ▶ Шин Шин ХХК
- ▶ Тефис Майнинг ХХК

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр \үргэлжлэл\

3. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөр	(411,277)	101,083	(310,194)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Компаниуд анх тайлагнасан дүнгээ өөрчилсөн.
- ▶ Цайрт Минерал ХХК ба Шин Шин ХХК дээр ажиглагдсан валютын ханшийн зөрүү.

4. Газрын төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Газрын төлбөр	(9,411,530)	9,284,738	(126,792)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ Дараах компаниудаас зарим аймаг, сумдын газрын алба болон татварын газруудад хийсэн төлбөрүүдийг ҮТЕГ дараах компаниудтай холбоо бүхий тайландаа оруулаагүй байсан. Үүнд:

Компаниуд	Хаашаа төлсөн
Адамс Майнинг ХХК	Булган аймгийн Дашинчилэн сум
Багануур ХК	Багануур дүүргийн газрын алба
Дацан Трэйд ХХК	Улаанбаатар хот, Төв аймаг, Увс аймгийн Тариалан сум
Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр	Орхон сумын газрын алба
Эрдмин ХХК	Орхон аймаг
Гацуурт ХХК	Нийслэлийн газрын алба
Жамп ХХК	Нийслэлийн газрын алба ба Баянхонгор аймгийн Галуут сум
Хан Шижир ХХК	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум
Монгол Чех Метал ХХК	Баянцагаан сум ба Нийслэлийн газрын алба
Монполиммет ХХК	Төв ба Булган аймаг
Монголросцветмет ХХК	Хэнтий ба Төв аймаг
Петро Чайна Дачин Тамсаг ХХК	Дорнод аймаг

- ▶ Болд Төмөр Ерөө Гол ХХК нь 2008 оны төлбөрөө оруулсан байсан.
- ▶ Бороо Гоулд ХХК нь төлсөн төлбөрөө тайландаа оруулаагүй байсан.
- ▶ ТЕГ-ын тайлагнасан газрын төлбөр нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэрийн НӨАТ-ын авлагаас суутгасан дүн байсан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр \үргэлжлэл\

5. Ус, рашаан ашигласны төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Ус, рашаан ашигласны төлбөр	(666,722)	110,054	(556,668)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- Компаниудын зүгээс зарим сум, аймгийн татварын хэлтэс болон усны албадад хийсэн төлбөрүүдийг ҮТЕГ тайлагнаагүй орхигдуулсан байсан. Тухайлбал.

Компаниуд	Хаашаа төлсөн
Адамс Майнинг ХХК	Булган аймгийн Дашинчилэн сум
Хан Шижир ХК	Баянхонгор аймгийн татварын хэлтэс
Петро Чайна Дачин Тамсаг ХХК	Дорнод аймгийн Халх гол сум
Монполимет ХХК	Төв ба Булган аймаг
Төфис Майнинг ХХК	Архангай аймгийн Жаргалант сум

- Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь төлсөн төлбөрийн дүнгээ тайландаа оруулаагүй байсан.

6. Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	(974)	250	(724)

Энэ төлбөрийн хувьд анхны зөрүүнд хийсэн залруулгууд нь голдуу компаниудын тайлагнасан дүн өөрчлөгдсөний улмаас болж гарсан.

7. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр	(1,275,101)	1,015,955	(259,146)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- Айванхоу Майнс Монголия Инк ХХК ба Гацуурт ХХК-ийн хувьд тайлагнасан дүнд ХХҮГ-аас буцаан олгсон дүнг оруулаагүй байсан

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр \үргэлжлэл\

7. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр \үргэлжлэл\

- ▶ Тайлагнасан тоон үзүүлэлтэд бусад төлбөрийг оруулсан байсан.

Компанийн нэр	Гадаадын мэргэжилтэн, ажилтны ажлын байрны тайлагнасан төлбөрийн дүнд багтаасан зүйлс
Шин Шин ХХК	СЯ-д төлсөн үйлчилгээний хураамж, гадаадын мэргэжилтний хөлс
Гоби Коул энд Энержи ХХК	Өөр компанид төлсөн ажлын байрны төлбөр
Элтрана ХХК	Хараат компанийн өмнөөс төлсөн төлбөр
Тефис Майнинг ХХК	Цалингийн төлбөр

- ▶ Тайлагнасан дүнд шилжүүлгийн төлбөр ороогүй байсан. Энэ нь дараах компаниуд дээр гарсан.
 - ▶ Бороо Гоулд компанийн зарим ажилтнууд өөрсдийн төлбөрийг ХХҮГ-т шууд төлсөн байсан ба компани үүнийг тайлагнаагүй орхисон байсан.
 - ▶ Бүүргэнт ХХК
 - ▶ Шим Технологи ХХК
 - ▶ Шанлун ХХК

8. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	(602,396)	592,497	(9,899)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ АМГ нь дараахь компаниудын хийсэн төлбөрийг бүртгээгүй байсан.
 - ▶ Бороо Гоулд ХХК-ийн Сэлэнгэ аймгийн Мандал сумын төрийн санд төлсөн төлбөр.
 - ▶ Петро-Чайна Дайчинь Тамсаг ХХК-ийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд төлсөн төлбөр Эрдэнэца гаан суманд хийсэн тлбр.
- ▶ Айвенхоу Майнз ХХК-ийн төгрөгийн төлбөрийг орхигдуулснаас зөрүү үүссэн.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

б\ Төлбөр \үргэлжлэл\

9. Бусад

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Бусад	(1,392)	1,392	-

Энэхүү тоон үзүүлэлт нь Айвенхоу Майнз Монгол Инк.ХХК-иас Өмнөговь аймгийн Ханбогд болон Манлай сумдад зам ашигласны төлбөрт төлсөн дүнтэй холбоотой. Энэ төлбөрийг тайлагнах шаардлагагүй тул үүнийг хасвал зохино.

в\ Хураамж болон үйлчилгээний хөлс

“Хураамж болон үйлчилгээний хөлс” гэсэн хэсэгт орсон зүйл нэг бүр дээр гарсан нийт зөрүүг доорх хүснэгтэнд үзүүлэв. Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Холбогдох хууль, тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн улсын бүртгэлийн тэмдэгтийн болон бусад хураамж	(83,553)	68,748	(14,805)
Холбогдох хууль, тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн үйлчилгээний хураамж	(422,683)	176,532	(246,151)
Гаалийн үйлчилгээний хураамж	(1,627,121)	1,662,305	35,184
Бусад	(74,599)	29,019	(45,580)
Нийт	(2,207,956)	1,936,604	(271,352)

1. Холбогдох хууль, тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн улсын бүртгэлийн тэмдэгтийн болон бусад хураамж

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Тэмдэгтийн болон бусад хураамж	(83,553)	68,748	(14,805)
Үйлчилгээний хөлс	(422,683)	176,532	(246,151)

Энэ зүйлийн анхны зөрүүнд хийсэн залруулга нь АМГ ба ХХҮГ-ын компаниудаас хүлээн авсан төлбөрүүдийн дүнг өөрчлөн тайлагнаснаас болж гарсан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

в\ Хураамж болон үйлчилгээний хөлс \үргэлжлэл\

2. Гаалийн үйлчилгээний хураамж

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Гаалийн үйлчилгээний хураамж	(1,627,121)	1,662,305	35,184

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн.

- ▶ ГЕГ нь Чинхуа МАК ХХК-ийн нүүрсний экспортод төлсөн гаалийн үйлчилгээний хураамжийг тайлагнаагүй байсан.
- ▶ Эрмин ХХК нь гаалийн үйлчилгээний хураамжийн тайлагнасан дүнд гаалийн албан татвар ба НӨАТ-ын төлбөрийн дүнг оруулсан байсан.

3. Бусад

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Бусад	(74,599)	29,019	(45,580)

Анхны зөрүүнд хийсэн залруулга нь Айвенхоу Майнз компани нь анх тайлагнасан дүнгээ өөрчилснөөс болж үүссэн.

г\ Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг

“Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг” гэсэн хэсэгт орсон зүйл нэг бүр дээр гарсан нийт зөрүүг доорх хүснэгтэнд үзүүлэв. Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Төрийн өмчийн ногдол ашиг	59,415,473	(59,415,473)	-
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	(442,019)	442,019	-
Нийт	58,973,454	(58,973,454)	-

1. Төрийн өмчийн ногдол ашиг

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Төрийн өмчийн ногдол ашиг	59,415,473	(59,415,473)	-

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

г\ Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг \үргэлжлэл\

1. Төрийн өмчийн ногдол ашиг \үргэлжлэл\

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн:

- ▶ УТЕГ нь Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр ХХК-ийн 2006 онд хийсэн төрийн өмчийн ногдол ашгийн төлбөрийг оруулж тайлагнасан байсан.
- ▶ Монгол Улсын ОУИТБС-ын анхны буюу 2006 оны нэгтгэл ба тайланд тэмдэглэсэнчлэн Шижиер Алт ХХК төрийн өмчийн ногдол ашгийг буруу ойлгосны улмаас Монголпроцветмет-д төлсөн ногдол ашгийг төрийн өмчийн ногдол ашигт оруулсан байсан.
- ▶ Монгол Улсын ОУИТБС-ын анхны буюу 2006 оны нэгтгэл ба тайланд тэмдэглэж байсанчлан УТЕГ Таван Толгой ХХК-иас 2007 онд хүлээн авсан төлбөрийг орон нутгийн өмчийн ногдол ашиг гэхийн оронд төрийн өмчийн ногдол ашгийн зүйлээр тайлагнасан.

2. Орон нутгийн өмчийн ногдол ашиг

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Орон нутгын өмчийн ногдол ашиг	(442,019)	442,019	-

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Дээр тайлбарласанчлан, УТЕГ Таван Толгой ХХК-иас 2007 онд хүлээн авсан төлбөрийг орон нутгийн өмчийн ногдол ашиг гэхийн оронд төрийн өмчийн ногдол ашгийн зүйлээр тайлагнасан.
- ▶ Таван Толгой ХХК-ийн анх тайлагнасан дүн нь буруу байсан ба өөрчилж ирүүлсэн дүнд өөр компанид төлсөн ногдол ашгаас суутган авч, шилжүүлсэн татварын төлбөрийг оруулаагүй байхад харин УТЕГ энэ дүнг оруулж тайлагнасан байсан.

д\ Хүлээн авагч Засгийн газарт хийсэн бусад төлбөр

1. Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр Засгийн газарт хийсэн төлбөр

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн төлбөр	(3,983,623)	3,983,623	-

Сонгож авсан 38 компаниас зөвхөн Петро-Чайна Дайчинь Тамсаг ХХК бүтээгдэхүүн хуваах гэрээтэй ажиллаж байна. Илэрсэн зөрүү Петро-Чайна Дайчинь Тамсаг ХХК 2007 онд хийсэн төлбөрөө хасч, оронд нь 2008 онд хийсэн төлбөрийг оруулан тайлагнасантай гол төлөв холбоотой үүссэн.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

e\ Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж

“Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, дэмжлэг” гэсэн хэсэгт орсон зүйл нэг бүр дээр гарсан нийт зөрүүг доорх хүснэгтэнд үзүүлэв. Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Компаниудаас яам, агентлагуудад өгсөн мөнгөн хандив, тусламж	(652,816)	256,199	(396,617)
Компаниудаас аймагт өгсөн мөнгөн хандив, тусламж	(556,158)	428,969	(127,189)
Компаниудаас сумдад өгсөн мөнгөн хандив, тусламж	555,062	(35,521)	519,541
Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө	(546,893)	450,459	(96,434)
Бусад	(39,408)	-	(39,408)
Нийт	(1,240,213)	1,100,106	(140,107)

1. Компаниудаас яам, агентлагуудад өгсөн мөнгөн хандив, тусламж

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Компаниудаас яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	(652,816)	256,199	(396,617)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Компаниудаас дараах яам, агентлагуудад өгсөн мөнгөн хандив, тусламжийг Засгийн газрын тайланд тусгаагй байсан. нд:
 - ▶ Үндэсний онцгой байдлын газар
 - ▶ Эрдэс баялаг, эрчим хүчний яам \ЭБЭХЯ\ өмнө нь Худалдаа, аж үйлдвэрийн яам гэж байсан
 - ▶ Улсын мэргэжлийн хяналтын газар
 - ▶ Ашигт малтмалын газар
- ▶ Дараахь компаниуд төрийн бус байгууллагууд өгсөн хандивыг энэ зүйл ангид хамааруулан буруу тайлагнасан.
 - ▶ Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр ХХК
 - ▶ Шим Технологи ХХК

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

e\ Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж \үргэлжлэл\

2. Компаниудаас аймаг, сумдад өгсөн мөнгөн хандив, тусламж

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Компанийн зүгээс аймагт өгсөн мөнгөн хандив	(556,158)	428,969	(127,189)
Компанийн зүгээс суманд өгсөн мөнгөн хандив	555,062	(35,521)	519,541

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Компаниудаас дараахь аймаг, сумдад өгсөн мөнгөн хандив, тусламжийг Засгийн газрын тайланд тусгаагүй байсан. Үүнд
 - ▶ Мандал сум
 - ▶ Баянгол сум
 - ▶ Дархан-Уул аймаг
 - ▶ Сэлэнгэ аймаг
 - ▶ Баянхонгор аймаг
 - ▶ Өмнөговь аймаг
 - ▶ Дорноговь аймаг
- ▶ Хан Шижир ХК өөрийнх нь өмнөөс Одод Мөнх ХХК-ийн өгсөн мөнгөн хандивыг оруулж тайлагнаагүй байсан.
- ▶ Жамп ХХК нь сумдад өгсөн мөнгөн хандив, тусламжийг “Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө” гэсэн зүйлээр тайлагнасан байсан.
- ▶ Эрдмин ХХК нь орон нутаг дахь байгууллагуудад өгсөн мөнгөн хандив, тусламжийг энэ зүйлд хамааруулж буруу тайлагнасан.
- ▶ Дараахь компаниуд тогтвортой хөгжлийн санд өгсөн мөнгөө аймагт өгсөн мөнгөн хандив, тусламж гэж тайлагнасан байсан. Аймаг, сумын тогтвортой хөгжлийн санд шилжүүлсэн хандив, тусламжийг “Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө” гэсэн зүйлээр тайлагнах ёстой байсан.
 - ▶ Дацан Трэйд ХХК
 - ▶ Гурван Төхөм ХХК
 - ▶ Монголросцветмет ХХК
 - ▶ Шин Шин ХХК

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

е\ Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж \үргэлжлэл\

3. Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Компанийн зүгээс орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжилд зориулан зарцуулсан хөрөнгө	(546,893)	450,459	(96,434)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Зөвхөн аймаг, сумдын тогтвортой хөгжлийн санд шилжүүлсэн мөнгийг энд тайлагнах ёстой. Гэсэн хэдий ч дараахь компаниуд бусад хандив, тусламжийг энд оруулан тайлагнасан байсан. Үүнд:
 - ▶ Болд Төмөр Ерөө Гол ХХК
 - ▶ Чинхуа МАК ХХК
 - ▶ Айванхоу Майнс Монголия Инк ХХК
 - ▶ Мон Дулаан ХХК
 - ▶ ПетроЧайна Дачин Тамсаг ХХК
 - ▶ Шим Технологи ХХК
 - ▶ Цайрт Минерал ХХК

Үүнээс гадна, дээр дурьдсанчлан зарим компаниуд тогтвортой хөгжлийн санд төлсөн мөнгийг “Аймагт үзүүлсэн мөнгөн хандив, тусламж” гэсэн зүйлд оруулж тайлагнасан байсан.

ж\ Байгаль орчныг хамгаалах зардал

“Байгаль орчныг хамгаалах зардал” гэсэн хэсэгт орсон зүйл нэг бүр дээр гарсан нийт зөрүүг доорх хүснэгтэнд үзүүлэв. Үүнд:

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	(25,961)	(11,811)	(37,772)
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	(994,565)	519,302	(475,263)
Нийт	(1,020,526)	507,491	(513,035)

1. Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	(25,961)	(11,811)	(37,772)

3. Тодруулга \үргэлжлэл\

3.2 Татвар, төлбөр, хураамж ба үйлчилгээний хөлс гэх мэт зүйлүүдээр хийсэн шинжилгээ \үргэлжлэл\

ж\ Байгаль орчныг хамгаалахад зориулсан зардал \үргэлжлэл\

1. Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал \үргэлжлэл\

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Айвенхоу Майнс Монголия Инк ХХК нь байгаль хамгаалахад зарцуулсан зардлын дүнг энэ зүйлд оруулж тайлагнасан байсан.
- ▶ Шарын гол ХК нь тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийг байгаль хамгаалахад зарцуулсан зардлын дүнгээр тайлагнасан.
- ▶ БҮАЖЯ-ны тайлагнасан дүнгүүдийг дараахь компаниуд өөрсдийн тайланд оруулаагүй байсан.

Компанийн нэр	
Шарын Гол ХК	2 төлбөр тайлагнаагүй.
Монгол Чех Метал ТӨҮГ	Байрыг нь түрээслэдэг өөр нэг компанийн, өөрийнх өмнөөс төлсөн төлбөрийг орхигдуулсан байсан.
Эрдэс Холдинг ХХК	Эрдэс Холдинг ХХК ямар нэгэн дүн тайлагнаагүй

2. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал

Зүйл	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	(994,565)	519,302	(475,263)

Энэ зүйлийн анхны зөрүүнд дараахь залруулгуудыг хийсэн. Үүнд:

- ▶ Бүүргэнт компани нь байгаль орчныг хамгаалахтай холбоогүй бусад зардлуудыг оруулж тайлагнасан байсан.
- ▶ Дээр тайлбарласанчлан,
 - ▶ Айвенхоу Майнс Монголия Инк ХХК нь байгаль хамгаалахад зарцуулсан зардлын дүнг энэ зүйлд оруулж тайлагнасан байсан.
 - ▶ Шарын гол ХК нь тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50 хувийг байгаль хамгаалахад зарцуулсан зардлын дүнгээр тайлагнасан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд

Дээрх хэсэг тус бүрээр гарсан тодорхой зөрүүнүүдийг залруулсны дараа нийт шийдэгдээгүй зөрүүний үлдэгдэл ямар байгааг доорх хүснэгтээс харж болно. Хавсралт Е-ээс шийдэгдээгүй зөрүүг компани тус бүрээр дэлгэрэнгүй харж болно.

Хэсэг	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
а) Татвар	(32,027,520)	23,844,798	(8,182,722)
б) Хураамж	(14,714,951)	12,254,090	(2,460,861)
в) Төлбөр болон үйлчилгээний хураамж	(2,207,956)	1,936,604	(271,352)
г) Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	58,973,454	(58,973,454)	-
д) Хүлээн авагч Засгийн газарт хийсэн бусад төлбөр	(3,983,623)	3,983,623	-
е) Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж	(1,240,213)	1,100,106	(140,107)
ё) Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал	(1,020,526)	507,491	(513,035)
Нийт зөрүү	3,778,665	(15,346,742)	(11,568,077)

Дээрх хүснэгтээс харахад нийт зөрүү нь 3,778,665 мянган төгрөгөөс (11,568,077) мянган төгрөг болсон өссөн юм шиг харагдаж байна. Гэхдээ илүү тодорхой дүр зургийг дараахь хүснэгтээс харж болно.

	Анхны зөрүү (мян.төг)	Залруулга (мян.төг)	Шийдэгдээгүй зөрүү (мян.төг)
Тайлагнасан дүн:			
Компанийн дүн Засгийн газрын дүнгээс их гарсан	(55,194,789)	43,626,712	(11,568,077)
Засгийн газрын дүн компанийн дүнгээс их	58,973,454	(58,973,454)	-
Нийт зөрүү	114,168,243	102,600,166	11,568,077

Хаалтанд байгаа дүнгүүд нь компанийн тайлагнасан дүн нь Засгийн газрын тайлагнасан дүнгээс уг дүнгээр илүү гарч байгааг илэрхийлж байгаа учраас зөрүүний нийт дүн нь 102,600,166 мянган төгрөгөөр буурч, шийдэгдээгүй зөрүүний дүн 11,568,077 мянган төгрөг болсон.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд \үргэлжлэл\

Алтан Дорнод Монгол ХХК ба Тун Шин ХХК мэдээлэл гаргаж өгөх боломжгүй учраас энэ хоёр компани дээр гарсан зөрүүг хасвал шийдэгдээгүй зөрүүний нийт дүн дараахь байдалтай болно. Үүнд:

Хэсэг	Анхны зөрүү (мян.төг)	Алтан Дорнод Монгол ХХК ба Туншин ХХК (мян.төг)	Шийдэгдээгүй үлдсэн зөрүү (мян.төг)
а) Татвар	(8,182,722)	(8,140,373)	(42,349)
б) Төлбөр	(2,460,861)	(1,523,556)	(937,305)
в) Хураамж, үйлчилгээний хөлс	(271,352)	(8,745)	(262,607)
г) Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-
д) Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-
е) Засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламж	(140,107)	(339,426)	199,318
ё) Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал	(513,035)	(780,834)	267,799
Цэвэр зөрүү	(11,568,077)	(10,792,934)	(775,143)

Дээрх хүснэгтээс харахад шийдэгдээгүй үлдсэн зөрүү нь ерөнхийдөө “Төлбөр” гэсэн хэсгээс болж гарсан байна. Шийдэгдээгүй үлдсэн зөрүүг дараахь шалтгаануудын улмаас цаашид тулган баталгаажуулж багасгах боломжгүй болсон.

а) Татвар

Энэ хэсгийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь голчлон гаалийн албан татвар, импортлосон шатах, тослох материалын онцгой албан татвараас болж гарсан. Бараг компани бүр дээр гаалийн албан татварын шийдэгдээгүй зөрүү үлдсэн ба мтаериаллаг том зөрүүнүүдийг дараахь хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Багануур ХК	25,935
Болд Төмөр Ерөө Гол ХХК	(66,281)
Коулд Гоулд Монгол ХХК	(53,847)
Эрдэнэт үйлдвэр	(138,153)
Эрдэс Холдинг ХХК	143,302
Эрдмин ХХК	147,149
Айвенхоу Майнс Монголия Инк ХХК	(24,828)
Жамп ХХК	(36,649)
Мон Дулаан Трэйд ХХК	(21,759)
Монголросцветмет ХХК	31,673
Монполимет ХХК	(55,373)
Цайрт Минерал ХХК	32,363
Улз Гол ХХК	(15,568)
Бусад	14,213

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд \үргэлжлэл\

а) Татвар (үргэлжлэл)

Гаалийн албан татвар дээр шийдэгдээгүй зөрүү үлдэж байгаа гол шалтгаанууд нь:

- ▶ Компаниуд нэмэлт мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байсан. Жмшээ нь:
 - ▶ Эрдэнэт уул баяжуулах үйлдвэр тайлагнасан дүнгээс өөр дэлгэрэнгүй задаргааг гаргаж өгөх боломжгүй байсан.
 - ▶ Эрдмин ба Мон Дулаан Трэйд компаниудын хувьд, мэдээлэл, тайлбар гаргаж өгч чадах ажилтан нь эзгүй байсан.
 - ▶ Цайрт Минерал ХХК нь нийт дүнг тайлагнасан байхад ГЕГ гаалийн мэдүүлэг нэг бүрийн төлбөрөөр нь задалж харуулсан дэлгэрэнгүй жагсаалтыг гаргаж өгсөн
- ▶ Тайлагнасан дүнд НӨАТ, импортлосон шатах, тослох иатериалын онцгой албан татвар, гаалийн үйлчилгээний хураамж гэх мэт бусад татваруудыг оруулсан байсан. Гэхдээ, эдгээр татвар, хураамжуудаар задалсан задаргаа дараахь компаниудын хувьд байхгүй байсан.
 - ▶ Коулд Гоулд Монгол ХХК
 - ▶ Жамп ХХК
 - ▶ Монполимет ХХК
- ▶ Эрдэс Холдинг ХХК гаалийн татварт ямар нэгэн мөнгө төлөөгүй гэсэн байхад ГЕГ энэ компаниас төлбөр хүлээн авсан гэж тайлагнасан байна.

б) Төлбөр

Энэ хэсгийн хувьд шийдэгдээгүй зөрүү нь голчлон ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр ба улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн хайгуулийн ажлын нөхөн төлбөрөөс болж гарсан.

i. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (Роялти)

Дараахь компаниуд дээр шийдэгдээгүй томоохон зөрүүнүүд гарсан. Үүнд:

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Коулд Гоулд Монгол ХХК	(38,078)
Монголросцветмет ХХК	(89,843)
Шанлун ХХК	(423,542)
Бусад	(13,179)

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр дээр шийдэгдээгүй зөрүү үлдэж байгаа гол шалтгаанууд нь:

- ▶ Шанлун компани төлбөр төлсөн гэж тайлагнасан байхад УТЕГ уг компаниас ямар нэгэн төлбөр хүлээн аваагүй гэж тайлагнасан
- ▶ Монголросцветмет ХХК-ийн хувьд үүнээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй байсан.
- ▶ Коулд Гоулд Монгол ХХК-ийн НББ-ийн мэдээллийн баазаа хулгайд алдсан, нөөц хувь байхгүй учраас дэлгэрэнгүй задаргаа мэдээллийг гаргаж өгч чадаагүй.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд \үргэлжлэл\

б) Төлбөр (үргэлжлэл)

ii. Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын нөхөн төлбөр

Дараахь компаниуд дээр шийдэгдээгүй томоохон зөрүүнүүд гарсан. Үүнд:

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	(280,615)
Монголын Алт (МАК) ХХК	(36,842)
ПетроЧайна Дачин Тамсаг ХХК	67,791
Шанлун ХХК	(41,052)
Шарын Гол ХХК	(19,477)

Шийдэгдээгүй зөрүү үлдэж байгаа гол шалтгаанууд нь:

- ▶ АМГ нь Бороо Гоулд ХХК, Монголын Алт (МАК) ХХК, Шанлун ХХК, Шарын Гол ХХК-иудын төлсөн гэж тайлагнасан төлбөрүүдийг алиныг нь ч хүлээн аваагүй гэж тайлагнасан.
- ▶ ПетроЧайна Дачин Тамсаг ХХК ба АМГ хоёулаа МОУИТБСАА-нд гаргаж өгсөн Засгийн газрын маягт дээр бөглөсөн төлбөрийн дүнгүүдийн талаар мэдэхгүй байсан.

iii. Ус, рашаан ашигласны төлбөр

Дараахь компаниуд дээр шийдэгдээгүй томоохон зөрүүнүүд гарсан. Үүнд:

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Эрдэс Холдинг ХХК	(19,660)
Жамп ХХК	(11,415)
Монголросцветмет ХХК	(45,995)
Монполимет ХХК	(44,449)
Шижир Алт ХХК	(44,791)
Бусад	(5,607)

- ▶ Шижир Алт ХХК дээр гарсан зөрүүг эс тооцвол эдгээр зөрүүнүүд нь, ус рашаан ашигласны төлбөр нь аймаг, сумдын төсөв төлөгддөг учраас ҮТЕГ нь бүрэн задаргаа мэдээллийг өгөх боломжгүй байснаас шалтгаалан гарсан.

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд \үргэлжлэл\

в) Хураамж, үйлчилгээни хураамж

Энэ хэсгийн хувьд шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд нь үйлчилгээний хураамжтай холбоотой.

i. Холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн засаг захиргаанд төлсөн үйлчилгээний хураамж

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	(67,193)
ПетроЧайна Дачин Тамсаг ХХК	(166,530)
Бусад	(12,428)

Шийдэгдээгүй зөрүүнүүд нь ХХҮГ нь энэ хоёр компани дээр тайлагнасан дүнгийнхээ талаар нэмэлт мэдээлэл гаргаж өгөх боломжгүй байснаас үүссэн.

г) Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж

Энэ хэсгийн хувьд шийдэгдээгүй зөрүүнүүд нь Засгийн газрын харъяа байгууллагуудаас мэдээллийг гаргаж өгөх боломжгүй байснаас болж голдуу гарсан. Доорх хүснэгтэнд том дүнтэй зарим нэг шийдвэрлэгдээгүй зөрүүнүүдийг үзүүлээ.

i. Компанийн зүгээс яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн хандив, тусламж

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	(60,518)
Монполимет ХХК	(15,000)
ПетроЧайна Дачин Тамсаг ХХК	(10,720)
Цайрт Минерал ХХК	(28,000)
Бусад	(41,552)

ii. Компанийн зүгээс аймагт үзүүлсэн мөнгөн хандив, тусламж

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	(39,963)
Коул Гоулд Монгол ХХК	10,000
Гоби Коул энд Энержи ХХК	(10,073)
Айвенхоу Майнс Монголия Инк ХХК	(31,804)
ПетроЧайна Дачин Тамсаг ХХК	(11,916)
Таван Толгой ХХК	(14,545)
Бусад	(9,581)

3. Тодруулга \үргэлжлэл\

3.3 Шийдэгдээгүй зөрөөнүүд \үргэлжлэл\

г) Засгийн газрын байгууллагуудад өгсөн хандив, тусламж (үргэлжлэл)

iii. Компанийн зүгээс суманд өгсөн мөнгөн хандив, тусламж

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	571,032
Чинхуа МАК ХХК	(20,337)
Гацуурт ХХК	88,868
Гоби Коул энд Энержи ХХК	(51,465)
Монголын Алт (МАК) ХХК	(26,830)
Монполимет ХХК	54,000
Шанлун ХХК	(13,760)
Таван Толгой ХХК	(18,111)
Цайрт Минерал ХХК	(12,138)
Бусад	(2,559)

д) Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал

Энэ хэсгийн хувьд шийдэгдээгүй зөрүүнүүд нь голдуу байгаль орчныг хамгаалахтай холбогдон гарсан зардлаас болж гарсан. Шийдэгдээгүй зөрүү гарах болсон шалтгаан нь БОАЖЯ ба компаниуд нь тайлагнасан дүнгийнхээ задаргаа дэлгэрэнгүй мэдээллийг гаргаж өгөөгүй явдал юм.

i. Байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардал

Дараахь компаниуд дээр шийдэгдээгүй томоохон зөрүүнүүд гарсан. Үүнд:

Компанийн нэр	Шийдэгдээгүй Зөрүү (мян.төг)
Бороо Гоулд ХХК	(268,700)
Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр	136,656
Эрдэс Холинг ХХК	170,763
Гацуурт ХХК	293,520
Жамп ХХК	131,800
Монполимет ХХК	150,200
Монголросцветмет ХХК	(167,313)
ПетроЧайна Дачин Тамсаг ХХК	(157,550)
Бусад	9,637

Зарим компаниудын хувьд шийдэгдээгүй зөрүүнүүд нь мэдээллийг өөр өөр эх үүсврүүдээс бэлтгэж тайлагнаснаас болж үүссэн байж болно. Бидний ойлгож байгаагаар БОАЖЯ дүнг “Байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан” дээрээс авч бөглөсөн ба компаниуд өөрсдийн санхүүгийн тайлан дээр байгаа дүнг авч бөглөсөн байна.

4. Асуудлууд

Энэ хэсэгт гэрээт ажлын явцад гарсан асуудлуудыг зохих газарт нь харьцуулж үзэх боломж олгох үүднээс Монгол Улсын анхдугаар аудитын нэгтгэсэн тайлангийн бүтэцтэй ижил маягаар гаргаж тусгав.

4.1 Цаг хугацаа болон цагийн хуваарь

Монгол Улсын ОУИТБС-ын 2007 оны хоёрдугаар нэгтгэл ба тайланг гаргах ажлыг хоёр үе шаттай явууллаа. Нэгдүгээр үе шат 2009 оны тавдугаар сарын 11-нд, хоёрдугаар үе шат 2009 оны долдугаар сарын 20-ны өдөр эхэлсэн. Үүрэгт ажлыг гүйцэтгэх хугацаа нь үндэсний их баяр Наадам болон зуны амралтын өдрүүдтэй давхцаж, уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудын гол албан тушаалтнуудын ихэнх нь эзгүй байснаас шалтгаалан холбогдох талуудаас тоон үзүүлэлтийн талаар нарийвчилсан мэдээлэл болон тайлбар авах ажил биднээс үл хамааран хугацаа алдсан.

Уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудад нэгтгэл гаргах ажилд туслах үүднээс мэдээлэл өгөхийг хүссэн анхны захидал илгээсэн өдрөөс эхлэн хоёр долоо хоногийн хугацаанд МОУИТБС-д хариу ирүүлэхийг мэдэгдсэн. Уул уурхайн компаниудын тал хувь нь эхний хоёр долоо хоногийн дотор ямар нэгэн хариу өгсөн бөгөөд Засгийн газрын харьяа долоон байгууллагаас зөвхөн гурван нь хугацаандаа хариу өгсөн болно. Ирүүлсэн мэдээлэл нь ихэвчлэн өмнө өгсөн тоон үзүүлэлтээ баталгаажуулсан буюу хянан өөрчилсөн л агуулгатай байсан болохоос хийсэн болон хүлээн авсан төлбөрийн холбогдолтой нарийвчилсан мэдээлэл ирүүлээгүй.

Хангалтгүй хариу авсан тул мэдээлэл авах үүднээс уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудтай тус тус уулзалт зохион байгуулсан. Ийм уулзалтын дараа л ихэнх мэдээлэл орж ирсэн. Гэвч мэдээлэл хомс буюу бүрэн бус байгаагаас шалтгаалан ногдол ашиг болон ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөртэй холбоотой шинэчилсэн мэдээллийг Засгийн газрын харьяа холбогдох байгууллагуудаас хожимдуу хүлээн авсан.

Уул уурхайн компаниудын мэдээлэл хоцорч ирсэн тул мөнгөн хандив, тусламж, тэмдэгийн болон бусад хураамж, үйлчилгээний хөлс, газрын болон ус ашигласны төлбөртэй холбоотой тоон үзүүлэлтүүдийг баталгаажуулсан мэдээллийг мөн хожуу хүлээн авсан. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлын талаарх мэдээллийг БОАЖЯ-наас мөн хожуу хүлээн авсан хариу хүлээгдсээр байгаа болно.

4.2 Засгийн газрын мэдээллийн бүрэн бус байдал

ОУИТБС-ын маягт 2-ыг нэгтгэн ОУИТБС-ын маягт 3-ыг бөглөх ажлыг ҮТЕГ-ын Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс хариуцан гүйцэтгэсэн ба дараа нь Сангийн Яаманд хүргүүлсэн. Мөнгөн дэмжлэгийн талаар Засгийн газрын харьяа байгууллагуудаас мэдээлэл цуглуулж авахад Сангийн Яам туслалцаа үзүүлсэн гэсэн. Мөнгөн хандив, тусламжийн талаар мэдээлэл цуглуулах ажиллагаа явуулсан боловч энэ талаарх мэдээлэл нэгтгэл гаргахад хангалттай бус байсан.

Анхан шатны харьцуулалтаар Засгийн газрын харьяа байгууллагууд уул уурхайн компаниудын тайлагнасан дараах зүйл ангийн төлбөрүүдийг тайлагнаагүй байсныг тогтоосон. Үүнд:

- ▶ Автобензин болон дизель түлшний албан татвар.
- ▶ Орон нутгийн өмчийн ногдол ашиг.
- ▶ Холбогдох хууль тогтоомжийн дагуу төв, орон нутгийн ТЗБ-д төлсөн улсын бүртгэлийн тэмдэгийн болон бусад хураамж.

4. Асуудлууд \үргэлжлэл\

4.2 Засгийн газрын мэдээллийн бүрэн бус байдал \үргэлжлэл\

Өмнөх жилийн тайланд үүнийг мөн тэмдэглэж байсан ба энэ нь дараах учир шалтгаантай болно:

- ▶ УТЕГ нь Засгийн газрын харьяа холбогдох зарим нэг байгууллагуудаас мэдээлэл гаргах өгөх хүсэлт тавиагүй.
- ▶ УТЕГ хүн хүчний хүрэлцээ муу байсны улмаас Засгийн газрын харьяа байгууллагуудаас мэдээлэл авах талаар хангалтгүй хөөцөлдсөн тул мэдээлэл өгөх ажил маш удаашралтай явагдсан.
- ▶ Мөн Засгийн газрын харьяа байгууллагууд хүссэн мэдээлэл гаргаж өгөх талаар хамтарч ажиллаагүй.

Мөн түүнчлэн, газрын болон ус ашигласны төлбөрийн талаар сумдаас ирүүлсэн мэдээлэл нарийвчилсан задаргаагүй байсныг тэдгээрээс аймгийн татварын газруудад тоон үзүүлэлтүүдийг утсаар ирүүлдэг гэж тайлбарлаж байсан.

4.3 Маягтуудын загвар

Монгол Улсын ОУИТБС-ын 2006 оны анхдугаар нэгтгэл тайланд өгсөн зөвлөмжийн дагуу ОУИТБС-ын маягтыг 2008 оны гуравдугаар сард шинэчилж гаргасан бөгөөд шинэчилсэн загварт маягтыг сайжруулах талаарх өмнөх зөвлөгч нарын санал зөвлөмжийг тусгасан.

Ийнхүү 2007 оны татварын жилд ОУИТБС-ын маягт 1 болон 3-т дараах өөрчлөлт орсон:

- ▶ НӨАТ болон компаниас орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэгийг шинэчилсэн маягтын дагуу тайлагнах шаардлагагүй болсон.
- ▶ Тусгай дансанд хадгалах байгаль орчныг хамгаалах зардлын 50 хувийн биет хандивыг өмнөх маягтаар Орлого ба ашгийн урсгал (сайн дурын үндсэн дээр) гэсэн Хүрээ 2-ын дагуу тайлагнах шаардлагатай байсныг өөрчилж, "Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал" гэсэн хэсэгт тусгайлан тайлагнах болсон. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал гэсэн зүйл ангийг мөн нэмж оруулсан. Энэхүү хоёр зүйл ангийг нэгтгэлд оруулсан болно.
- ▶ Хэсэг бүрийн төгсгөлд "Бусад" гэсэн зүйл анги нэмсэн.

Шинэчилсэн загвар 2008 оны гуравдугаар сард дөнгөж гарсан тул тэр үед зарим компани хуучин маягтаар тайлангаа ирүүлчихсэн байсан. Илүү ажил удахгүйн тулд МОУИТБС тайлангуудыг хүлээн авсан. Иймд зарим компани НӨАТ болон компаниас орон нутгийн байгууллагуудад өгсөн мөнгөн хандив, тусламжийн талаар тайлагнасан байсан. Гэвч тайлагнах шаардлагагүй, мөн бусад тоон үзүүлэлтэд хамруулах шаардлагагүй зүйлийг компаниуд тусгайлан тайлагнасаар байна. Тухайлбал:

- ▶ Ажил олгогчдоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл (38 компаниас 13 нь)
- ▶ Ажилтнуудын төлсөн нийгмийн даатгалын шимтгэл (38 компаниас 5 нь)
- ▶ Хувь хүний ашиг орлогын албан татвар (38 компаниас 15 нь)
- ▶ Даатгал (38 компаниас 1 нь)

4. Асуудлууд \үргэлжлэл

4.3 Маягтуудын загвар \үргэлжлэл

Дээрхээс гадна, “Засгийн газрын харьяа байгууллагуудад үзүүлсэн хандив, тусламж” гэсэн гарчиг болон “Мөнгөн хандив” гэсэн зүйл анги буруу ойлголт өгч байж болзошгүй байна. Учир нь хандив гэсэн томъёолол мөнгөн хандиваас гадна мөнгөн бус хандив, тусламжийг ч мөн адил хамардаг билээ. Иймд зарим компани эхлээд зөвхөн мөнгөн хандивын дүнг оруулсан байснаа тоон үзүүлэлтээ хянаж мөнгөн бус хандив, тусламжийг оруулж тооцсон байсан. Мөн хувь хүмүүст болон төрийн бус байгууллагуудад өгсөн хандиваа оруулж тайлагнасан компаниуд ч байсан.

Компаниас орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн хандив, тусламж гэсэн хэсгийг хассан тул зарим компани орон нутгийн байгууллагуудад өгсөн хандиваа өөр зүйл анги, тухайлбал компаниас тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө гэсэн зүйл ангид хамруулан тайлагнасан. Энэ нь компаниуд юу тайлагнах ёстойгоо ойлгохгүй байгааг харуулж байна.

4.4 Маягтуудыг нарийн зөв бөглөх асуудал

Уул уурхайн олон компани болон Засгийн газрын харьяа байгууллагууд тайлагнасан дүнгийн үзүүлэлтээ баталгаажуулах болон нарийвчилсан мэдээлэл өгөх бидний хүсэлтэд хариу ирүүлэхдээ анх тайлагнасан дүнгээ хянан өөрчилсөн байсан нь аль аль тал нь ОҮИТБС-ын маягтуудыг ирүүлэхээс өмнө тэдгээрийг нягтлан шалгадгүй юм болов уу гэсэн сэтгэгдэл төрүүлж байна. Өөрчлөлт оруулсан нь гол төлөв хувь хүний алдаа, маягтуудыг бөглөж байгаа ажилтан хийх ёстой ажлаа сайн ойлгохгүй байгаатай холбоотой байсан. Энэ тухай дор мөн тэмдэглэсэн болно.

4.5 Маягтуудыг бөглөх зааварчилга

Монгол Улсын ОҮИТБС-ын 2007 оны хоёрдугаар нэгтгэл ба тайланг гаргах хүрээнд ОҮИТБС-ын маягтуудыг бөглөх зааварчилгад өмнөх жилийн тайланд тусгасан зарим зөвлөмжийг багтаасан.

Гэвч зааварчилгад зүйл анги бүр дээр тавих тодорхой шаардлагыг тодорхойлоогүй байна. Жишээлбэл, ямар үндсэн дээр тооцоо хийхийг тодорхой заагаагүй учраас Засгийн газрын харьяа байгууллагууд тайлагнасан тоон үзүүлэлтээ бэлэн мөнгөөр тооцсон байхад компаниуд өссөн байдлаар тайлагнаснаас зөрүү үүссэн.

4.6 Маягтад оруулах төлбөрүүдийн талаарх нэгдсэн ойлголт

Татвар, лицензийн төлбөр гэх мэт тодорхой нэг зүйлүүдэд юуг оруулж тайлагнах талаар ойлголцолын зөрүү байгаагын улмаас Засгийн газрын харьяа байгууллагууд ба компаниудын тайлагнасан дүнгүүдийн хооронд зөрүү гарч байна. Жишээлбэл: татварын торгууль эсвэл лицензийн сунгалт, шилжүүлгийн төлбөрийг тайлагнах дүн оруулах ёстой эсэх нь тодорхойгүй байна.

4. Асуудлууд \үргэлжлэл

4.7 Засгийн газрын харьяа байгууллагуудад үзүүлсэн хандив, тусламж

Засгийн газрын харьяа байгууллагууд компаниудаас авсан мөнгөн хандив, тусламжийг тайлагнаагүйтэй холбоотойгоор зөрүү нь гол төлөв үүсэж байна. Мөн түүнчлэн Засгийн газрын харьяа байгууллагуудын тайлагнасан мөнгөн хандивын талаар нарийвчилсан мэдээлэл гаргаж өгч чадахгүй байна. Иймээс Засгийн газраас болон компаниудаас тайлагнасан мөнгөн хандивын дүнг хооронд нь тулган баталгаажуулах боломжгүй байсан.

Компаниудаас өгсөн мөнгөн хандивын дүнг баталгаажуулах хүсэлтийг Засгийн газрын харьяа байгууллагуудад хүргүүлсэн. Компаниудаас тайлагнасан мөнгөн хандивын хэмжээ баталгаажуулсан зарим тоон үзүүлэлттэй нийцэж байсан. Бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээний хэлбэрээр үзүүлсэн мөнгөн бус дэмжлэгийн хувьд компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудын тоон үзүүлэлт өөр өөр байгаа тал гарсан.

Тайлагнах албан ёсны болон төвлөрсөн процесс байхгүй учраас орон нутгийн засаг захиргааны хувьд олон тооны байгууллагад үзүүлсэн бүхий л хандив, тусламжийг бүртгэх явдал хүндрэлтэй байх болно.

4.8 Тэмдэгтийн болон бусад хураамж, үйлчилгээний хөлс

Засгийн газрын төрөл бүрийн нэгж байгууллагуудад (ялангуяа аймаг, сумдад байгаа) компанийн зүгээс төлсөн төлбөр Засгийн газрын тайланд тусгагдахгүй байна.

Дээр хандив, тусламжийн хэсэгт дурьдсантай адил энэ нь тайлагнах албан ёсны болон төвлөрсөн процесс байхгүйгээс болж байна.

4.9 Тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл байхгүй байна

Шийдэгдээгүй үлдсэн ихэнх зөрүү нь нэгтгэл хийхэд шаардлагатай нарийвчилсан мэдээлэл байхгүй байсантай холбоотой. Ийм байдал компаниудын хувьд нийтлэг тохиолдож байсан бөгөөд гол албан тушаалтнууд эзгүй байсан, нарийвчилсан мэдээлэл бүртгэл, тооцооны тогтолцоонд бүртгэгдээгүй байсан, хяналт шалгалт байхгүй байсан гэсэн тайлбар өгч байсан.

Засгийн газрын харьяа байгууллагуудын хувьд компаниудаас өгсөн мэдээллийн мониторинг байхгүй, мэдээллийг дээшээ дутуу танилцуулдаг тал байна.

4.10 Засгийн газрын харьяа байгууллагууд ба компаниуд нь материаллаг дүнтэй төлбөрийн гүйлгээнүүдийг бүртгээгүй байна

Уул уурхайн компаниудаас тайлагнасан материаллаг хэмжээний төлбөр Засгийн газрын харьяа байгууллагуудын тайланд ороогүй байсан, эсвэл эсрэгээр компаниудын тайлагнаагүй төлбөрийг тайландаа оруулсан байсан тохиолдлууд гарсан.

Юуны өмнө энэ нь Бороо Гоулд болон Монголын Алт \МАК\ компаниуд дээр гарсан ба тэдгээрийн тайлагнасан төлбөрүүд ЭБЭХЯ-нд бүртгэгдээгүй байсан.

Өөр нэг жишээ бол, ГЕГ Сонор Трейд болон Эрдэс Холдинг компаниудаас гаалийн татварын төлбөр авсан гэж тайлагнасан байхад эдгээр компани ийм төлбөр хийгээгүй гэсэн.

5. Зөвлөмж, санал

Монгол улсын 2006 оны аудитын анхны нэгтгэсэн тайланд санхүүгийн баримтуудыг нэгтгэн тайлагнах өнөөгийн үйл явцыг эрчимжүүлэхэд МОУИТБС-ын хэрэглэж байгаа арга ажиллагааг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гаргасан байгаа. Энэ хэсэгт үйл ажиллагааг сайжруулах талаар өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн явцыг тайлагнах, мөн түүнчлэн шинээр олж мэдсэн асуудлуудтай холбоотойгоор нэмэлт зөвлөмж, саналыг өгөх болно.

Энэ нь юуны өмнө санхүүгийн баримтуудыг нэгтгэж, тулган шалгах үйл ажиллагаа болох учраас оршиж байж болох бүхий л дутагдал доголдлыг илрүүлэхэд зөвхөн үүнд тулгуурлах аргагүй юм. Тиймээс дор дурдсан санал, зөвлөмжүүд нь бүх талыг хамарсан өргөн хүрээтэй биш бөгөөд зарим тохиолдолд эдгээрийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд цаашид зөвлөн хэлэлцэх, ихээхэн ур чадвар, мөн үлэмж хүчин чармайлт гаргах шаардлагатай байж болох юм.

5.1 Хугацаа болон цагийн график

Хэдийгээр энэ жил төрөл бүрийн компани болон Засгийн газрын нэгж байгууллагуудад Үе шат 1-д олж тодорхойлсон зөрүүнүүдийг залруулах ихээхэн боломжийн цаг хугацаа байсан боловч үндэсний баяр наадам болон зуны амралттай давхцаад зарим гол гол албаны хүмүүс эзгүй байснаас шалтгаалан ажил цалгардах, саатах явдал гарсаар байлаа.

Энэхүү үйл ажиллагааны цаг хугацааг цаашид товлохдоо ОУИТБС-ын дараагийн нэгтгэсэн тайлан гаргахдаа амралт, баяр ёслолын өдрүүдтэй давхцуулахгүй байх үүрэг болон санхүүгийн тайлан гаргах цаад хугацааг харгалзан үзвэл зохино. Боломжтой бол уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудад цаашид мэдээлэл болон холбогдох тайлбар өгөх хангалттай хугацаа олгох үүднээс хуваарийг эдгээр цаг үетэй давхцуулахгүй байвал зохино.

Гэхдээ дээрх асуудлуудыг авч үзэхдээ тулган баталгаажуулах ажлыг санхүүгийн жил дууссаны дараа зохистой хугацааны дотор хийж байх явдлыг баталгаажуулах ёстой. Энэ нь МОУИТБС-ын маягт дээр бөглөж өгсөн дүнгүүдийг компанийн болоод Засгийн газрын харъяа байгууллагын холбогдох ажилтан мартаж амжихааргүй хугацаанд хийгдэх ёстой гэсэн үг юм.

Түүнээс гадна уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудын холбогдох гол хүмүүс эзгүй байх үед тэднийг орлох хүмүүсийг томилсон байх ёстой.

5.2 Засгийн газрын өгч буй мэдээллийн бүрэн бус байдал

ОУИТБС-ыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тогтоол гаргаж, уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийн талаар мэдээлж байхыг Засгийн газрын бүх нэгж байгууллагад үүрэг болгосон. Гэвч бидний тодруулснаар Засгийн газрын ихэнх байгууллага энэхүү тогтоолын талаар ойлголт байхгүй эсвэл уг тогтоолыг хэрэгжүүлэх, хянаж үйл явц байхгүй байна.

Тайланг цаг хугацаанд нь гаргаж өгөх, өгсөн мэдээллийн бүрэн, үнэн зөв байдлыг хангах үүднээс Засгийн газрын эдгээр байгууллагад хяналт тавьж ажиллах үүргийг нийтэд нь Сангийн Яаманд хариуцуулах хэрэгтэй.

Тэмдэгтийн болон үйлчилгээний хураамж, авто бензин болон дизель түлшний албан татвар болон орон нутгийн өмчийн ногдол ашиг зэрэгтэй холбоотой мэдээлэл үгүйгээс бүрэн бус тайлан гаргаж байгаа газарт эдгээр мэдээллийг харьцуулж үзэх үүрэг бүхий Засгийн газрын тусгай нэгж байгууллага, энэ тохиолдолд ҮТЭГ, Засгийн газрын янз бүрийн нэгж байгууллагад хяналт тавих, шаардлагатай үед эдгээрийг Сангийн Яаманд танилцуулж цаашид арга хэмжээ авахуулах ажлыг хариуцах ёстой. Нэгтгэх зориулалтаар ОУИТБС-ын Маягт 3-ын дагуу гаргаж өгсөн бүхий л мэдээлэл бүрэн байх ёстой.

5. Зөвлөмж, санал \үргэлжлэл\

5.2 Засгийн газрын өгч буй мэдээллийн бүрэн бус байдал \үргэлжлэл\

Улсын бүртгэлийн тэмдэгтийн болон бусад хураамж, холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн болон орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад төлсөн үйлчилгээний хураамж болон компаний зүгээс яам, агентлагуудад өгсөн мөнгөн хандив, тусламжийн тухайд энэ дагуу ОҮИТБС-ын гаргасан санаачилгууд болон тайланд тавигдах шаардлагуудыг танилцуулах мэдээлэлтэй байх ёстой.

Сумдаас гаргаж ирүүлсэн газрын төлбөр болон ус ашигласны төлбөрийн талаарх мэдээллийн тухайд ҮТЕГ уул уурхайн компаниудаас хүлээн авсан төлбөрийн нарийвчилсан жагсаалтыг сум тус бүр тогтмол үндсэн дээр бэлтгэн аймгуудад хүргүүлж нэгтгүүлж байх ажлыг хангаж өгвөл зохино. Тайлангийн бүрэн төгс байдлыг хангах үүднээс юу ч хүлээж аваагүй тухай мэдээллийг ч үүнд оруулж байвал зохино.

Хэдийгээр энэ жил Засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламжийн дүнг тайлагнах илүүтэй шаардлага байгаагүй ч Засгийн газрын ямар байгууллага хандив авснаа тайлагнасан, ямар компани хандив, тусламж өгснийг тодорхойлоход гаргаж ирүүлсэн нарийвчилсан тайлан мэдээ хангалтгүй байлаа. Тайлагнасан ихэнх зүйлсээс илүүтэй авлига өгч авалцаж буй сэжиг таамаг байгаа учраас сайтар нягтлан шалгах боломж олгох үүднээс хандив, тусламжийн талаар нарийвчилсан мэдээлэл авч байх шаардлагатай.

Урьд онд гаргасан санал, зөвлөмжүүдийн нэг нь уул уурхайн компаниудын тухайд тайлагнасан хандив, тусламжийн талаар бүрэн төгс ойлголт өгөх үүднээс сум, аймаг болон Засгийн газрын нэгж байгууллагуудад өгсөн хандив, тусламжийн талаарх нарийвчилсан мэдээллийг үе үе гаргаж өгч байх явдал юм. Нөгөө нэг хувилбар нь уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудын хувьд баталгаажуулалтын зарим маягтыг загварчлах үндсэн дээр эдгээр компани болон Засгийн газрын нэгж байгууллагад хүргүүлж болохуйц байдлаар бөглөсөн маягтуудад хандив, тусламжийн жагсаалтыг оруулах (зааварт зааснаар) явдал юм. Гэхдээ эдгээр нь баталгаажуулж илгээх боломж олгохуйцаар өргөн хэрэглэгдэхгүй байгаа юм.

Мөнгөн бус хандивын хувьд тулган баталгаажуулалтыг хийх нь хүндрэлтэй. Өртөг зардлын тухай мэдээлэл зөвхөн уул уурхайн компаниудад ихэвчлэн бэлэн байх учраас нэгтгэлийн гол анхаарал хандивын дүнд бус харин хандив болгосон бараа буюу үйлчилгээнд чиглэх ёстой. Өмнөх жилийн тайланд зөвлөмж болгосон хандивын зарим төрлийн баримтыг (буюу хандивласан бараа буюу үйлчилгээний өртгийг тэмдэглэсэн, дүнгүй нэхэмжлэлийн маягт)-ыг хүлээн авагчид хандив, тусламж нэг бүрээр өгөөгүй байна.

МОҮИТБСАА нь Компаниуд ба Засгийн газрын нэгж байгууллагуудад маягт бөглөх талаар ирээдүйд өгөх зааварчилгаандаа дээр дурьдсан зөвлөмжүүдийг оруулах ёстой.

Дээрхээс харахад, Компаниас хүлээн авсан төлбөрийг тайлагнах үйл явцад Засгийн газрын хэд хэдэн байгууллага оролцож байгаа ба хүлээн авч байгаа болон тайлагнаж буй мэдээллийг иж бүрэн байдлыг баталгаажуулахын тулд СЯ нь Засгийн газрын бүх түвшний байгууллагууд дээр хүлээн авч байгаа дүнгүүдийг тайлагнаж, тулган баталгаажуулах боломжийг олгох, тогтсон үйл явцыг бий болгохын тулд бодитой идэвх зүтгэлийг гаргах хэрэгтэй байна. Энэ нь ярвигтай, өргөн цар хүрээтэй ажил ба нарийвчилсан судалгаа шаардлагатай болно.

Үүнээс гадна, МОҮИТБСАА-наас зохион байгуулсан сургалт нь тайлагналтын шаардлагуудыг өргөн хүрээнд хамраагүй байж болох юм. Зааварчилгаанд өөрчлөлт оруулсны дараа Компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулж, тайлагналын шаардлагуудыг тэдэнд танилцуулах хэрэгтэй.

Компаниуд болон Засгийн газрын байгууллагуудад маягтыг бөглөх үед аливаа нэг хүндрэл эсвэл асуулт гарсан тохиолдолд тэдэнд туслах тусгай ажилтанг томилох ёстой.

5. Зөвлөмж, санал \үргэлжлэл\

5.3 Маягтуудын загвар

Мөнгөн болон мөнгөн бус хандив хоёуланг нь хамтатгах үүднээс “мөнгөн” гэх нэр томъёог хандив, тусламж гэсэн зүйл ангиар тайлагнах зүйлсээс хасах нь зүйтэй. Ингэх нь мөнгөн бус хандивыг мөн тайлагнах ёстой гэж заасан зааварчилгаандөө ч мөн нийцэх болно.

Тайлагнах шаардлагатай зүйл нэг бүрийг ойлгомжтой тодорхойлох ба юуг тайлагнах ёстойг зааж өгсөн зааварчилгааг өгөх ёстой. Үүнээс гадна, татварын торгууль ба алдангийн төлбөр, хандив болон хоёрдмол утгатай өөр бусад зүйлүүд гэх мэт энэ тайланд хэлэлцсэн асуудлуудын талууд маш тодорхой, нарийвчилсан зааварчилгааг оруулж өгөх хэрэгтэй.

5.4 Маягтуудыг нарийн зөв бөглөх

Өмнөх жилийн тодруулгатай хэр нийцэж буйг үзвэл уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагууд гол нь ирүүлсэн тайландаа алдаа, ташаарал гаргасан байсан учраас анхлан тайлагнасан дүнгээ олонтаа засч өөрчилсөн байна. Энэ нь тэд ОУИТБС-ын маягтуудыг бөглөхдөө анхаарал болгоомжгүй хандаж байгааг харуулж байж болох юм.

Бүх мэдээлэл үнэн зөв бөгөөд бүрэн дүүрэн эсэхийг тогтоохын тулд түүнийг ирүүлэхийнхээ өмнө газар дээр нь нягталж үзвэл зохино. Нэгтгэх үйл явцыг хөнгөвчлөх үүднээс ОУИТБС-ын маягтад шаардлагатай газар нь баталгаажуулсан материалуудыг хавсаргах ба ОУИТБС-ын Аудитын жил бүрийн нэгтгэсэн тайлан бүрэн гартал хадгалбал зохино. Энэ нь цаг хэмнэж, нарийвчилсан тоо мэдээ үгүйгээс зөвхөн ирүүлсэн мэдээллийг “зохицуулах” ажиллагаа явуулахын оронд нэгтгэсэн тайлан гаргах эхний үе шатанд илүүтэй үнэлгээ өгөх боломж олгох юм.

Тайлагнах шаардлагад аливаа тодорхой бус, хоёрдмол санаа байх ахул уул уурхайн компаниуд болон Засгийн газрын нэгж байгууллагуудын нэгтгэсэн тайлан бэлтгэх явцад батлагдахгүй асуудал гарахыг хүлээлгүй МОУИТБС-тай аль болох хурдан зөвлөж ярилцвал зохино.

Дэлхийн Банкны Групп-ээс саяхан гаргасан “ОУИТБС-ын тайлагналыг сайжруулах чиглэлд” гарчигтай баримт бичигт, Компанийн болон Засгийн газрын байгууллагуудын зүгээс ОУИТБС-ын маягтад мэдээллийг алдаагүй, зөв бөглөх талаар өгсөн зөвлөмжүүд нэг нь “Засгийн газрын зүгээс гаргаж ОУИТБС-ын маягаар гаргаж өгсөн мэдээллийг Үндэсний аудитын газар хянаж дүгнэлт өгөх, Компанийн ОУИТБС-ын маягаар гаргаж өгсөн мэдээлэл нь компанийн санхүүгийн тайлангууд болон бусад бичиг баримтууд дээр үндэслэсэн болохыг баталгаажуулсан баталгааг компанийн аудитор гаргах (эсвэл/ба компанийн удирдах дээд албан тушаалтан гарын үсэг зурсан баталгаажуулах захидал) ёстой.” гэсэн зөвлөмж байсан.

5. Зөвлөмж, санал \үргэлжлэл\

5.5 Тайлагнасан дүнгийн талаарх нэмэлт мэдээлэл

Гаалийн татвар, гаалийн үйлчилгээний хураамж болон байгаль хамгаалахтай холбоотой зардал

Дээр дурдсан татвар, хураамжийн дүнг хамтатгаж тайлагнаснаас ч юмуу, үүнийг илтгэх нарийвчилсан дүн мэдээ үгүй буюу үүнийг данснаас гадуур зарлагадсанаас ч юмуу энэ талаарх мэдээлэл ихэнх тохиолдолд байхгүй байсан.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн тогтолцоон дахь мэдээллийг олж авах үед дээрх явдал хойшид давтагдахгүй байх үүднээс уул уурхайн компаниуд нягтлан бодогч нарт зориулсан зохих ёсны зааварчилга болон удирдамж боловсруулж гаргах шаардлагатай байна.

Бусад зүйлсийн талаарх мэдээлэл

Зарим зүйл дээр, тодорхой нэг компанийн хувьд мэдээллийг архивласан, олдохгүй буюу эрэх аргагүй байгаа нь тогтоогдсон. Тайлагнасан дүнг илтгэх нарийвчилсан мэдээллийг ОУИТБС-ын Аудитын жил бүрийн нэгтгэсэн тайлан бүрэн гартал хадгалбал зохино.

6. Дүгнэлт

Энэ тайлангийн “Тодруулга” гэсэн гуравдугаар хэсэгт тусгасан шийдэгдсэн зөрүүгээс үзэхэд хэрэв Засгийн газрын харьяа байгууллагууд болон компаниуд юуны өмнө ОҮИТБС-ын маягтыг бөглөх ажилд илүү анхаарал хандуулсан бол эдгээр зөрүүний ихэнх нь гарахгүй байх боломжтой байжээ.

Мөн илэрсэн зөрүүг шийдвэрлэсэн байдлаас үзэхэд аль аль тал нь ОҮИТБС-ын маягтыг бөглөх зааварчилгыг ойлгоогүй байгаа нь зарим зүйл ангиар тайлагнасан тоон үзүүлэлтүүд хоорондоо тохирохгүй байх шалтгаан болжээ. Зарим татварын төлбөрийг буруу ангилсан, уул уурхайн компаниудын төлсөн татвар, ногдол ашгийн хугацаа болон тэдгээрийг Засгийн газрын харьяа байгууллагууд хүлээн авсан цаг хугацаа ялгаатай байсантай холбоотой будлиан гарсан нь мөн зөрүү үүсэх шалтгаан болсон.

ОҮИТБС-ын шинэчилсэн маягтуудыг бүх холбогдох талууд хүлээн зөвшөөрч байгаа тул ОҮИТБС-ын хуучирсан маягтыг ашигласнаас үүссэн зөрүү цаашид давтагдахгүй гэж найдаж байна.

Харин шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн учир шалтгаан төдийлөн тодорхой биш байна. Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн нийт дүн анх илэрсэн зөрүүнүүдийн нийт дүнгээс бага гарах болсон шалтгаан нь тодорхой зөрүүнүүдийн учир шалтгаан олж, залруулсантай холбоотой.

Уул уурхайн компаниуд болон Засгийн газрын харьяа байгууллагуудаас нарийвчилсан мэдээлэл олдоогүй тул бид шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүдийн талаар тулгалт, нэгтгэл хийх боломжгүй байсан. Голчлон өгч буй тайлбарууд нь хариуцсан ажилтан байхгүй байгаа, НББ-ийн мэдээллийн баазад байхгүй, баримт архивт шилжсэн, тиймээс гаргаж өгөх боломжгүй байна гэсэн тайлбарууд байсан.

Засгийн газрын нэгж байгууллагуудын тухайд авч үзвэл зөрүүг шийдэхэд нэрмээс болж байгаа гол зүйл нь ҮТЕГ-ын түвшинд цуглуулсан мэдээлэл бүрэн бус, АМГ ба компаниудын тайлагнасан дүнгүүд хоорондоо зөрүүтэй, маргаантай байсан явдал юм. Бидний үүрэгт ажлаа гүйцэтгэх үеэр сум, аймгийн түвшинд хийсэн татварын бүх төлбөрийн талаар ҮТЕГ-т тогтмол үндсэн дээр тайлагнахгүй байгаа явдал ажиглагдсан. Дараа дараагийн нэгтгэлийг амжилттай болгох үүднээс энэхүү асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Эцэст нь тэмдэглэхэд, ОҮИТБС-ын маягтуудыг бөглөх зааварчилгааг улам нарийн тодорхой болгох, МОҮИТБС-ын зүгээс ОҮИТБС-ын маягтыг бөглөх явцад гарах аливаа асуудлыг шийдвэрлэхэд туслах алба байгуулвал компаниудаас өгөх мэдээллийн чанар улам сайжирна гэж бид үзэж байна. МОҮИТБС нь Сангийн Яам болон Засгийн газрын харьяа холбогдох байгууллагуудтай хамтран ОҮИТБС-ын маягтад оруулах тоо баримтыг бүх түвшинд бүртгэж түүний чанар чансааг сайжруулах зорилгоор тайлагнах үйл явцыг албажуулах арга хэмжээ авах явдал хамгийн чухал болно.

Хавсралтууд

Хавсралт А: Засгийн газрын байгууллагууд – мэдээллийн эх сурвалж

	Засгийн газрын харьяа байгууллагууд
а) Татвар	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	ҮТЕГ
Гаалийн татвар	ГЕГ
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	ҮТЕГ
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	ҮТЕГ
Онцгой албан татвар	ГЕГ
Автобензин болон дизелийн түлшний албан татвар	ГЕГ
Автотээврийн болон, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	ҮТЕГ
Бусад татвар	ҮТЕГ
б) Хураамж	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	ҮТЕГ
Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	АМГ
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	АМГ
Газрын төлбөр	ҮТЕГ
Ус ашигласны төлбөр	ҮТЕГ
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	ҮТЕГ
Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр	ХХҮГ
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	ҮТЕГ

Хавсралтууд (үргэлжлэл)

Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	-	-	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	440,200	303,544	136,656	-	136,656	xii
НИЙТ ДҮН	599,962,592	564,692,970	35,269,622	(35,180,548)	89,074	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

ЭУУК тайлагнасан 75,999,388 мянган төгрөгийн татварын төлбөрийн дүнг зөв хэмээн баталгаажуулсан ба төлбөрийн дүнгийн талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн. УТЕГ 75,999,388 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба төлбөрийн дүнгийн талаарх нарийвчилсан мэдээллийг мөн өгсөн.

Нарийвчилсан мэдээллээс үзвэл ЭУУК “гадаадын аж ахуйн нэгжээс ЭУУК-ийн суутгаж авсан татвар”-ын дүн 2,080,644 мянган төгрөгийг аж ахуйн нэгжийн орлогын албан татварт оруулж тайлагнасантай гол төлөв холбоотойгоор зөрүү үүссэн байна.

ii. Гаалийн татвар

ЭУУК гаалийн татварт 19,117,438 мянган төгрөг төлснөөр тайлагнасан. Гэхдээ буруу тайлагнасан дүнд импортолсон шатах, тослох материалын онцгой албан татвар, автобензин болон дизелийн түлшний татвар, мөн НӨАТ-ын 13,303,651 мянган төгрөгийн төлбөр орсон болохыг мэдэгдсэн. Эдгээр татварыг хасч тооцох юм бол төлсөн гаалийн татварын дүн 5,813,787 мянган төгрөг болж өөрчлөгдөх юм. Гэвч ЭУУК төлсөн татварын дүнгийн талаар цааш нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

ГЕГ тайлагнасан 5,671,713 мянган төгрөгийн дүнг 5,675,634 мянган төгрөг болгож өөрчилсөн ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 138,153 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр байна.

iii. Импортолсон шатах, тослох материалын онцгой албан татвар

Дээр тайлбарласнаар ЭУУК импортолсон шатах, тослох мэтериалын онцгой албан татварт төлсөн 880,466 мянган төгрөгийн төлбөрийн дүнг анхандаа тусад нь салгаж тайлагнаагүй ба үүнийг гаалийн татварын төлбөрийн дүнд оруулсан байсан. Гэвч ЭУУК тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

ГЕГ тайлагнасан 883,705 мянган төгрөгийн дүнг зөв гэж баталгаажуулж, хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 3,239 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

iv. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

ЭУУК тайлагнасан 269,551 мянган төгрөгийн төлбөрийг баталгаажуулж, төлбөрийн дүнгийн талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн.

АМГ 347,925 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулж, энэ талаарх нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн.

Гаргаж өгсөн задаргаа мэдээллээс харахад Эрдэнэт уул баяжуулах үйлдвэр ХХК-ийн тайлагнасан дүнд өөр компаниас нөхөн төлсөн 132,602 мянган төгрөгийн дүнтэй лицензийн төлбөр ороогүй байсан ба 3,480 мянган төгрөгийн дүнтэй бусад төлбөрүүд орсон байсан.

Мөн лиценз сунгасны төлбөр 5,826 мянган төгрөг багтсан болохыг тогтоосон.

Үлдэж байгаа 44,922 мянган төгрөгийн зөрүү гадаад валютын ханшийн зөрүүнээс үүссэн байна.

v. Газрын төлбөр

ЭУУК өөрийн тайлагнасан 8,693,816 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба Орхон сумын газрын албанд төлсөн төлбөрийн талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн.

ЭУУК-ийн ирүүлсэн нарийвчилсан мэдээллийн үндсэн дээр газрын төлбөрт 6,230,000 мянган төгрөг бэлнээр төлсөн ба үүний 2,463,816 мянган төгрөг нь НӨАТ-ын нөхөн төлбөр болохыг тогтоосон.

ҮТЕГ ЭУУК-иас газрын төлбөрт хүлээн авсан аливаа дүнг тайлагнаагүй. Гэхдээ Орхон сумын Газрын хэлтэс 6,230,000 мянган төгрөг хүлээн авснаар тайлан гаргажээ.

vi. Ус ашигласны төлбөр

ЭУУК тайлагнасан 1,283,000 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. ҮТЕГ тайлагнасан төлбөрийн дүн 1,285,288 мянган төгрөг байх нь зөв гэж нотолж, хүлээн авсан төлбөрийн дүнтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Өгсөн нарийвчилсан мэдээллээс харвал ЭУУК нь 2007 оны долдугаар сарын 6-нд хийсэн 2,087 мянган төгрөгийн төлбөрийг оруулж тайлагнаагүйг байна. 2,088 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн.

vii. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

ЭУУК тайлагнасан 724,834 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ХХҮГ гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөрт ямар хэмжээний төлбөр хүлээн авснаа анхлан тайлагнаагүй. Харин дараа нь дээрх хэмжээний төлбөр хүлээн авснаа нотолж, холбогдох нарийвчилсан мэдээллийг өгсөн.

viii. Гаалийн үйлчилгээний хураамж

ЭУУК өөрийн төлсөн гаалийн үйлчилгээний хураамжийн дүнг тайлагнаагүй бөгөөд өөрийн системээс гаалийн үйлчилгээний хураамжтай холбоотой мэдээллийг олоогүй тул энэ талаар мэдээлэл өгч чадаагүй.

ГЕГ тайлагнасан 5,775 мянган төгрөгийн дүнгээ 80,631 мянган төгрөг болгож өөрчилсөн ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ix. Төрийн өмчийн ногдол ашиг

Компани өөрийн тайлагнасан 76,426,750 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба энэ талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн. ҮТЕГ өөрийн тайлагнасан 135,578,391 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ҮТЕГ 2006 онд төлсөн 59,151,641 мянган төгрөгийн дүнтэй лицензийн төлбөрийг оруулж тайлагнаснаар болж зөрүү үүссэн.

х. Компаниас яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ЭУУК өөрийн тайлагнасан 48,069 мянган төгрөгийн хандивын дүнг зөв гэж баталгаажуулсан ба уг төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Хандивыг Монголын боксын холбоонд өгсөн байна. Энэхүү мөнгөн хандивыг орон нутгийн байгууллагад өгсөн тул энэ зүйл ангиар тайлагнах ёсгүй.

Засгийн газрын харьяа байгууллагууд тус компаниас яам, агентлагуудад өгсөн аливаа хэмжээний хандив, тусламжийн талаар тайлагнаагүй.

xi. Компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ЭУУК суманд өгсөн хандив, тусламжийн аливаа дүнг тайлагнаагүй. Орон нутгийн захиргаа ЭУУК-иас 5,000 мянган төгрөгийн хандив авснаар тайлагнасан. Гэхдээ УТЕГ өгсөн хандив, тусламжийн дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч чадаагүй.

xii. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

ЭУУК өөрийн тайлагнасан 303,544 мянган төгрөг нь байгаль орчныг хамгаалах тухайд гарсан бөгөөд компанийн санхүүгийн тайланд тусгагдсан бодит зардал гэдгийг баталгаажуулсан. БОАЖЯ 440,200 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаар тайлагнасан боловч нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. 136,657 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

Тодруулга:

Мэдээлэл ирүүлэх хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. ЭУУК хүссэн ёсоор нарийвчилсан мэдээлэл өгсөн. Гэхдээ хариу нь хугацаандаа ирээгүй. Хариуг хүсэлт тавьсан захидлыг факсаар илгээснээс хойш бараг нэг сарын дараа буюу 2009 оны долдугаар сарын 7-нд хүлээж авсан. Ирүүлсэн мэдээллийг хэлэлцэх, илэрсэн зөрүүтэй холбогдуулан тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 17-нд ЭУУК-тай уулзаж ярилцсан. Нягтлан бодогч нь нарийвчилсан мэдээлэл болон тайлбар өгсөн.

ЭУУК хуучин загвар ашиглан ОУИТБС-ын маягт 1-ийг бөглөсөн байсан. МОУИТБСАА маягтыг сайжруулах талаар өмнөх зөвлөгчийн өгсөн зөвлөмжийг тусгаж оруулах шаардлагатай байсан тул ОУИТБС-ын шинэчилсэн маягт 2008 оны гуравдугаар сард л дөнгөж гараад байсан юм. Зарим компани нэгэнт хуучин маягтаар тайлагнасан байсан тул тэдэнд илүү ажил удахгүйн тулд МОУИТБС тайлангуудыг хүлээн авсан байсан.

Хуучин маягт ашигласан болохоор ЭУУК компаниас орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг болон НӨАТ-ыг гаалийн татварт оруулан тайлагнасан байсан. Монгол Улсын 2006 оны анхдугаар нэгтгэсэн тайланд орсон зөвлөмж ёсоор 2007 онд эдгээрийг тайлагнах шаардлага байхгүй.

Гэсэн хэдий ч тэд онцгой албан татвар, бензин болон дизелийн түлшний албан татвар, гаалийн үйлчилгээний хураамж болон НӨАТ-ыг гаалийн татварт оруулан тайлагнажээ. Бусад татвар болон хураамжийг маягтын холбогдох зүйл ангиудаар тайлагнах ёстой байсан.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй үлдсэн зөрүү гаалийн татвар, гаалийн үйлчилгээний хураамж, байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал зэрэг дээр голчлон гарсан байна.

Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр нь гаалийн татвар, гаалийн үйлчилгээний хураамжийн төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадахгүй байсан учраас нэмэлт үйл ажиллагаа явуулж чадаагүй. Мөн үүний адил, байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлын тухайд БОАЖЯ тайлагнасан дүнгийн талаар аливаа нэг нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

Хавсралт В13

Эрдэс Холдинг

ЭРДЭС ХОЛДИНГ (“ЭХ”)

ЭХ ХХК нь 100% Монголын эзэмшлийн компани бөгөөд Сэлэнгэ аймгийн Баянгол, Шарын гол сумдад алтны ордын хайгуулын ажил эрхэлдэг.

ЭХ Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн төлсөн төлбөрийн хоорондын зөрүү

Тайланд дурдсан дүнд тулгуурлаж үзвэл, Засгийн газрын хүлээж авсан болон компанийн зүгээс төлсөн төлбөрийн хоорондын цэвэр зөрүү дараах байдалтай байна. Хүлээн авсан болон төлбөр хийсэн баримтуудын нарийвчлан шинжилгээ болон илэрсэн зөрүүнүүдийг дараах хэсэгт харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	352,251	4,303	347,949	(199,409)	148,540	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	79,232	-	79,232	(79,232)	-	i
Гаалийн албан татвар	143,302	-	143,302	-	143,302	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	120,178	-	120,178	(120,178)	-	iii
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	-	-	-	-	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	5,238	-	5,238	-	5,238	iv
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	4,303	4,303	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	53,625	72,580	(18,955)	(3,635)	(22,590)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	53,211	49,570	3,641	(3,635)	6	v
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	2,033	(2,033)	-	(2,033)	vi
Ус, рашаан ашигласны төлбөр	-	19,660	(19,660)	-	(19,660)	vii
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	414	1,317	(903)	-	(903)	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	123	-	123	-	123	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	123	-	123	-	123	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	1,300	(1,300)	(700)	(2,000)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	1,000	(1,000)	-	(1,000)	viii
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	300	(300)	(700)	(1,000)	ix
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ё. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	185,000	9,237	175,763	500	176,263	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	5,000	-	5,000	500	5,500	x
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	180,000	9,237	170,763	-	170,763	xi
НИЙТ ДҮН	590,999	87,419	503,580	(203,244)	300,336	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

ЭХ анхны тайландаа аливаа төлбөрийн дүнг дурдаагүй. Учир нь 2006 онд ногдох аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болох 79,231 мянган төгрөгийг 2007 онд төлсөн байна. ҮТЕГ ЭХ-ийг 79,231 мянган төгрөгийн татвар төлснөөр тайлагнажээ.

ii. Гаалийн албан татвар

ЭХ хийсэн төлбөрийн аливаа дүнг тайлагнаагүй. ГЕГ 143,302 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаар тайлагнаснаа зөв гээд холбогдох нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн. 143,302 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

iii. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

ЭХ 2006 онд алт худалдсаны татварт өгөх ёстой 120,177 мянган төгрөгийг 2007 онд төлсөн болохоор анхлан тайлан гаргахдаа аливаа нэг хэмжээний төлбөрийн талаар дурдаагүй. ҮТЕГ тайланд дурдсан 120,177 мянган төгрөгийн дүн зөв гэж нотлоод, тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн. Үүнийг 2007 онд төлсөн болохоор тэр дагуугаа тайлагнах ёстой.

iv. Импортолсон шатах, тослох материалын онцгой албан татвар

ЭХ аливаа дүн тайлагнаагүй бөгөөд импортоор авсан шатах тослох материалын онцгой албан татварт ямар ч төлбөр хийгээгүй гэж нотолсон. ГЕГ тайлагнасан татварын дүн 5,238 мянган төгрөг байх нь зөв гээд үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн. 5,238 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

v. Ашигт малтмалын хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр

ЭХ тайлагнасан төлбөрийн дүн 49,570 мянган төгрөгийг зөв гэж нотлоод, төлсөн дүнд холбогдох нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн. АМГ өөрийн тайлагнасан 53,211 төгрөгийн дүнг 46,521 төгрөг болгон өөрчилсөн ба үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Нарийвчилсан мэдээллээс үзэхэд ЭХ 2007 оны долдугаар сард төлсөн 3,649 мянган төгрөгийн хэд хэдэн төлбөрийг оруулж тооцоогүйтэй холбоотойгоор зөрүү үүссэн байна.

Үүнээс гадна АМГ тус компаниас 2007 оны 4, 5, 9, 10 дугаар саруудад хийсэн 6,704 мянган төгрөгийн хэд хэдэн төлбөрийг Эрдэнэс Майнинг нэрээр буруу бүртгэсэн байсан тул уг дүнг тайлагнаагүй орхисон байсан.

vi. Газрын төлбөр

ЭХ тайланд дурдсан 2,032 мянган төгрөгийн төлбөрийн дүн зөв гэдгийг баталгаажуулж, энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэн. Газрын төлбөрийг Сэлэнгэ аймгийн Хүдэр, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд хийснээ дурджээ. ҮТЕГ аливаа дүнг тайлагнаагүй. 2,032 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vii. Ус ашигласны төлбөр

ЭХ тайланд дурдсан 19,660 мянган төгрөгийн төлбөрийн дүн зөв гэдгийг баталгаажуулж, тайлагнасан дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэн. Ирүүлсэн нарийвчилсан мэдээллээс үзвэл ус ашигласны төлбөрийг Сэлэнгэ аймгийн Хүдэр, Дархан-Уул аймгийн Шарын гол суманд хийжээ. ҮТЕГ аливаа дүнг тайлагнаагүй. ҮТЕГ ЭХ-ийн хийсэн төлбөрийн ямар нэг баримт олж чадаагүй байна. 19,660 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

viii. Компаний зүгээс яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ЭХ тайланд дурдсан хандивын дүн 1,000 мянган төгрөгийг зөв гэж баталгаажуулсан. Энэ хандивыг АМГ-д өгсөн байна. Засгийн газрын харьяа байгууллагууд ЭХ-оос аливаа хандив авсан тухай тайлагнаагүй. 1,000 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ix. Компаний зүгээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ЭХ тайландаа 300 мянган төгрөг гэснийгээ 1,000 мянган төгрөг болгон өөрчилжээ. Хандивыг Булган аймгийн Өндөршил суманд өгсөн байна. Орон нутгийн захиргаа ЭХ-оос аливаа хандив авсан тухайгаа тайлагнаагүй. 1,000 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

х. Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал

ЭХ аливаа дүн тайлагнаагүй. БОАЖЯ тайлагнасан дүн 5,000 мянган төгрөгийг 5,500 мянган төгрөг болгон өөрчиж, энэ талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлсэн. Ийнхүү өөрчилсөн нь БОАЖЯ 2009 оны долдугаар сарын 17-нд хийсэн 500 мянган төгрөгийн төлбөрийг оруулаагүй орхисонтой холбоотой байна. 5,500 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xi. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

ЭХ тайланд тусгагдсан 9,237 мянган төгрөгийн зардлын дүн зөв болохыг баталгаажуулж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн. БОАЖЯ 180,000 мянган төгрөг зарцуулснаар тайлан гаргажээ. Гэхдээ тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлээгүй. 170,763 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна

Тодруулга:

Мэдээлэл хүссэн хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн ба ЭХ-ийн хариуг анхны Сануулах захидал явуулахаас гурав хоногийн өмнө буюу 2009 оны зургадугаар сарын 16-нд хүлээж авсан. Тэд тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн ба түүндээ төлбөрийн зарим баримтыг хавсаргажээ. Тайлагнасан дүнгийн талаар тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 15-нд ЭХ-той уулзсан. Уулзалтын үеэр нягтлан бодогч нь гаалийн татвар болон гаалийн үйлчилгээний хураамжийн талаар дараа нарийвчилсэн мэдээлэл өгөхөөр болж тохирсон. Гэвч тэрээр хүссэн мэдээллийг хараахан ирүүлээгүй байна.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй үлдсэн зөрүү нь гаалийн татвар, ус ашигласны төлбөр болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлаас голчлон үүссэн байна.

ГЕГ ЭХ-иас гаалийн татварын төлбөр авснаар тайлагнасан. Харин ЭХ төлбөр хийгээгүй гэж мэдэгдсэн. ҮТЕГ тус компаниас орон нутгийн байгууллагад төлсөн ус ашигласны аливаа төлбөрийг бүртгэлдээ аваагүй байсан. БОАЖЯ тайланд дурдсан байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлын дүнгийн талаар ямар нэг нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

Хавсралт В14

Эрдмин

Эрдмин

Эрдмин компани нь Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдсан Монгол-Америкийн хамтарсан компани бөгөөд Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг ба Эрдэнэтийн зэсийн уурхайн хаягдлаас зэс катод боловсруулдаг.

Эрдмин компани Монгол Улсын Үндэсний татварын ерөнхий газарт бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүний талаар дараах хэсэгт тусгасан болно.

(мян.төг)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	5,977,289	5,977,381	(92)	147,149	147,057	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	5,955,998	5,955,998	-	-	-	
Гаалийн албан татвар	-	-	-	147,149	147,149	i
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-	-	-	-	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	20,941	20,941	(0)	-	(0)	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	350	442	(92)	-	(92)	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	1,238,622	1,298,535	(59,913)	59,176	(737)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1,238,622	-	1,238,622	(1,238,622)	-	ii
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	1,238,622	(1,238,622)	1,238,622	-	iii
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	59,176	(59,176)	59,176	-	iv
Ус, рашаан ашигласны төлбөр	-	737	(737)	-	(737)	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	-	-	-	-	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	-	148,929	(148,929)	147,484	(1,445)	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	-	148,929	(148,929)	147,484	(1,445)	v
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	7,964	(7,964)	7,964	-	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	7,964	(7,964)	7,964	-	vi
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ё. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	5,650	16,084	(10,434)	1,234	(9,200)	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	5,400	5,400	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	250	10,684	(10,434)	1,234	(9,200)	vii
НИЙТ ДҮН	7,221,561	7,448,894	(227,333)	363,008	135,675	

i. Гаалийн татвар

Эрдмин компани болон ГЕГ аль аль нь анхандаа ямар ч дүн тайлагнаагүй. Харин дараа нь ГЕГ 147,149 мянган төгрөгийн төлбөр авснаар өөрчлөн мэдээлсэн ба хүлээн авсан төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Харин Эрдмин компанийн нягтлан бодогч өвчтэй байсан тул тус компани төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй. 147,149 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ii. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

Эрдмин компани ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1,238,622 мянган төгрөгийг ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр гэж буруу тайлагнажээ.

iii. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

Дээр тайлбарласнаар, Эрдмин компани ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт төлсөн төлбөрийн дүнг ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр хэмээн буруу тайлагнажээ.

iv. Газрын төлбөр

Эрдмин компани тайлагнасан 59,176 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Газрын төлбөрийг Орхон аймагт төлсөн байна. ҮТЕГ Эрдмин компаниас газрын төлбөрт төлсөн төлбөрийн ямар нэг дүн буюу энэ талаарх нарийвчилсан мэдээллийг бидэнд гаргаж өгч чадаагүй. Орхон аймаг 59,176 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаа дараагаар нь нотолсон.

v. Гаалийн үйлчилгээний хураамж

Эрдмин компаний анхлан тайлагнасан дүнд гаалийн татвар болон НӨАТ-ыг оруулсан байсан тул түүнийг 148,929 мянган төгрөг гэснийг өөрчилж 3,125 мянган төгрөг болгосон. Гэхдээ Эрдмин компани НӨАТ-ыг тусгайлан тайлагнаж чадаагүй учраас шинэчилсэн дүнд НӨАТ-т төлсөн төлбөрийн дүн мөн багтаж байгаа болно.

ГЕГ анхандаа Эрдмин компаниас авсан төлбөрийн аливаа дүнг мэдээлээгүй. Харин дараа нь ГЕГ дүнг 1,680 мянган төгрөг болгон өөрчилж тайлагнасан ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 1,445 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг

Эрдмин компани аймгуудад бус, орон нутгийн байгууллагуудад мөнгөн дэмжлэг үзүүлсэн тул анх тайлагнасан 7,964 мянган төгрөгийн дүнг тэглэсэн. Орон нутгийн захиргаа Эрдмин компаниас ямарваа дэмжлэг авсан тухай тайлагнаагүй.

vii. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

Эрдмин компани тайлагнасан 10,684 мянган төгрөгийн зардлын дүнг өөрчилж 9,450 мянган төгрөг болгосон ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Эрдмин компани өөрчилсөн дүн нь байгаль орчныг хамгаалахтай холбоотой гарсан бодит зардал гэж тайлбарласан ба БОАЖЯ-наас тайлагнасан 250 мянган төгрөгийн төлбөрийн дүн нь “Байгаль орчныг хамгаалах жилийн төлөвлөгөө”-нд төсөвлөгдөж орсон бөгөөд 2007 онд БОАЖЯ-нд олгосон хөрөнгийн дүнд үндэслэсэн хэмээн нэмж тодруулсан. 9,200 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

Тодруулга:

Мэдээлэл ирүүлэх хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. Эрдмин компани анхны сануулах захидал илгээснээс хойш 5 хоногийн дараа буюу 2009 оны зургадугаар сарын 24-нд хариу ирүүлсэн. Тэд хариу захидалдаа өөрсдийн тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээллийг оруулсан байсан. Зарим мэдээллийг тодруулах зорилгоор 2009 оны долдугаар сарын 17-нд уулзаж ярилцсан. Эрдмин компаниас өгсөн мэдээлэл болон тайлбар хангалттай байсан. Нягтлан бодогч нь тухайн үед өвчтэй байснаас Эрдмин компани зөвхөн гаалийн татвартай холбоотой мэдээллийг ирүүлээгүй байсан юм.

Хураангуй тайлбар:

Гаалийн татвар болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал дээр ихэвчлэн зөрүү гарсан байна.

Эрдмин компанийн нягтлан бодогч тухайн үед өвчтэй байснаас гаалийн татварт хийсэн төлбөрийн талаар ямар нэг нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй тул нэмэлт ажиллагаа явуулах боломжгүй байсан. БОАЖЯ байгаль орчныг хамгаалахтай холбоотой гарсан зардлын талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй.

Хавсралт В15

Гацуурт

Гацуурт

Гацуурт нь 100 хувь Монголын өмчийн компани бөгөөд Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт сум, Дархан-Уул аймгийн Хонгор сум болон Сэлэнгэ аймгийн Ерөө суманд алтны уурхай ажиллуулдаг.

Гацуурт компани УТЕГ-т бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүний талаар дараах хэсэгт тусгасан болно.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	1,169,090	1,167,085	2,005	(6,000)	(3,995)	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	-	4,153	(4,153)	-	(4,153)	i
Гаалийн албан татвар	607,605	442,916	164,689	(164,689)	-	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	540,000	707,733	(167,733)	167,733	-	iii
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3,206	3,206	0	(0)	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	9,320	-	9,320	(9,320)	-	iv
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	8,959	9,077	(118)	276	158	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	768,966	658,619	110,346	(107,372)	2,974	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	200,205	199,259	946	(946)	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	272,163	437,982	(165,819)	165,139	(680)	v
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн орддын нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	16,973	10,064	6,909	(5,556)	1,353	vi
Ус, рашаан ашигласны төлбөр	5,055	6,610	(1,555)	576	(979)	vii
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	274,569	4,704	269,865	(266,585)	3,280	viii
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	3,083	-	3,083	(3,083)	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	3,083	-	3,083	(3,083)	-	ix
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	89,868	4,000	85,868	-	85,868	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	500	(500)	-	(500)	
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	2,500	(2,500)	-	(2,500)	x
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	89,868	1,000	88,868	-	88,868	xi
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1б.Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	305,220	11,700	293,520	-	293,520	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	11,700	11,700	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	293,520	-	293,520	-	293,520	xii
НИЙТ ДҮН	2,336,226	1,841,404	494,822	(116,455)	378,367	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Гацуурт компани нь тайлагнасан 4,153 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан боловч татварын төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. УТЕГ Гацуурт компаниас хүлээн авсан төлбөрийн аливаа дүнг тайлагнаагүй. 4,153 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ii. Гаалийн татвар

Гацуурт компани гаалийн татварт 442,916 мянган төгрөг төлснөөр анхлан тайлагнасан. Гэхдээ хэлэлцүүлгийн үеэр тайлагнасан гаалийн татварын дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй боловч тайлагнасан дүн ГЕГ-ын тайлагнасан дүнтэй ижил байх ёстой гэж мэдэгдсэн. ГЕГ өөрийн тайлагнасан 607,605 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба хүлээн авсан төлбөрийн дүнтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн.

iii. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

Гацуурт компани анхлан 2007 онд төлсөн татварын бодит дүнг бус, төлөх ёстой татварын хэмжээг мэдээлсэн тул дараа нь тайланд дурдсан 707,733 мянган төгрөгийн дүнг 540,000 мянган төгрөг болгон өөрчилсөн.

iv. Импортлолсон шатах, тослох материалын онцгой албан татвар

Гацуурт компани импортлолсон шатах, тослох материалын онцгой албан татварт ямар хэмжээний төлбөр хийснээ анхлан тайлагнаагүй. Гэхдээ хэлэлцүүлгийн явцад тэд төлбөрийн дүнг ГЕГ-ын тайлагнасан дүнтэй бараг ижил байх ёстой гэж мэдэгдсэн. Төлсөн төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. ГЕГ өөрийн тайлагнасан 9,320 мянган төгрөгийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба хүлээн авсан төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

v. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

Анх тайлагнасан дүнд тооцооны алдаа байсан болон зарим төлбөрийг давхардуулж оруулснаас шалтгаалан уг дүн өндөр гарсан тул Гацуурт компани анх тайлагнасан 437,982 мянган төгрөгийн дүнг 272,843 мянган төгрөг болгон өөрчилсөн. АМГ өөрийн тайлагнасан 272,163 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

vi. Газрын төлбөр

Гацуурт компани анх тайлагнасан дүнд тооцооны алдаа байсан тул 10,064 мянган төгрөгийн уг дүнг 19,802 мянган төгрөг болгон өөрчилсөн ба төлбөрийг нийслэлийн болон Сэлэнгэ аймгийн газрын албанд төлснөө мэдэгдсэн. УТЕГ Гацуурт компаниас 16,973 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаар тайлан гаргажээ. Гэхдээ тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй. Нийслэлийн Газрын алба 4,182 мянган төгрөг хүлээн авснаа дараа нь нотолсон. 1,353 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vii. Ус ашигласны төлбөр

Гацуурт компани өөрийн тайлагнасан 6,610 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба үүнийг Өвөрхангай аймаг болон Нийслэлийн Газрын албанд төлсөн гэж мэдэгдсэн. Гэхдээ Гацуурт компани тайлагнасан төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй. УТЕГ өөрийн тайлагнасан 5,055 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан боловч тайлагнасан дүнгийн талаар аливаа нарийвчилсан мэдээлэл өгч чадахгүй байсан. Нийслэлийн Газрын алба дараагаар нь 576 мянган төгрөг хүлээн авснаа нотолсон.

viii. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

Гацуурт компани анх тайлагнасан төлбөрийн дүнд зарим алдаа гарсан тул 4,704 мянган төгрөгийн дүнг өөрчилж, 276,937 мянган төгрөг болгосон. ХХҮГ өөрийн тайлагнасан 274,569 мянган төгрөгийн дүнг 266,426 мянган төгрөг болгон өөрчилсөн ба тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Нарийвчилсан мэдээллийн үндсэн дээр Гацуурт компани ХХҮГ-аас хүлээн авсан 13,791 мянган төгрөгийн нөхөн төлбөрийг оруулж тооцоогүй байсныг тогтоосон. 3,280 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ix. Гаалийн үйлчилгээний хураамж

Гацуурт компани гаалийн үйлчилгээний хураамжийн аливаа дүн тайлагнаагүй. Гэхдээ хэлэлцүүлгийн явцад тэд энэ дүн ГЕГ-ын тайлагнасан дүнтэй ижил байх ёстой гэж мэдэгдсэн. Төлсөн төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. ГЕГ тайлагнасан тоон үзүүлэлтээ 4,774 мянган төгрөг болгон өөрчилсөн ба тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

x. Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг

Гацуурт компани өөрийн тайлагнасан 2,500 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба мөнгөн дэмжлэгийг Сэлэнгэ аймагт үзүүлсэн болохоо мэдэгдсэн.

Орон нутгийн захиргаа тус компаниас ямар нэг хэмжээний мөнгөн дэмжлэг авсан тухай тайлагнаагүй. 2,500 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xi. Компаниас сумдад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

Гацуурт компани өөрийн тайлагнасан 1,000 мянган төгрөгийн хандивын дүнг баталгаажуулсан ба үүнийг Мэдлэг хөгжүүлэх санд хандивласнаа мэдэгдсэн.

Орон нутгийн захиргаа 89,868 мянган төгрөг хүлээн авсан тухайгаа тайлагнасан боловч энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. Гацуурт компани орон нугийн захиргаанд 89,868 төгрөгийн төлбөр хийснээ хэлж мэдэхгүй байгаа юм 88,868 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xii. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

Гацуурт компани байгаль орчныг хамгаалахтай холбоотойгоор гарсан аливаа зардлын дүнг анхлан тайлагнаагүй. Гацуурт компани газар нөхөн сэргээхэд зориулж 2007, 2008 онд ойролцоогоор 2,400,000 мянган төгрөг зарцуулсан гэж тайлбарласан. Гэхдээ гарсан зардлын талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

БОАЖЯ 293,520 мянган төгрөгийг Гацуурт компанийн хувьд байгаль орчныг хамгаалахтай холбоотойгоор гаргасан зардал гэж тайлагнасан. Гэхдээ тайлагнасан дүнгийн талаар БОАЖЯ нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. 293,520 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна

Тодруулга:

Гацуурт компанийхан тэр үеэр ажил ихтэй байсан тул мэдээлэл ирүүлэх талаар бидний тавьсан хүсэлтэд хариу өгөөгүй. Нарийвчилсан мэдээлэл болон илэрсэн зөрүүний талаар нэмж тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 24-нд Гацуурт компанийхантай уулзсан. Уулзалтын үеэр нягтлан бодогч нь тайлагнасан зарим тоон үзүүлэлтийг баталгаажуулж, зөрүүний талаар зарим тайлбар өгсөн. Гэхдээ тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй.

Үүнээс гадна уулзалтын үеэр нягтлан бодогч нь зарим зөрүүний талаар дараа нэмэлт мэдээлэл өгөхөөр болж тохирсон боловч бидний хүссэн мэдээллийг одоогоор ирүүлээгүй байна. Мөн нягтлан бодогч нь 2009 оны наймдугаар сарын дунд хүртэл эзгүй байх тухайгаа бидэнд мэдэгдсэн.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй үлдсэн зөрүүнүүд компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой гарсан зардалтай голчлон холбоотой байсан. Орон нутгийн

захиргаа компанийн зүгээс суманд үзүүлэх мөнгөн дэмжлэг болгож хүлээн авсан хандивын дүнг тайлагнасан боловч тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй. Ийм байдлаар нэгтгэх ажиллагаа цааш явуулж чадаагүй. Гацуурт компани ч тэр, БОАЖЯ ч тэр байгаль орчныг хамгаалах тухайд гарсан зардлын талаар нэмэлт мэдээлэл өгч чадаагүй юм.

Хавсралт В16

Гоби Коул энд Энержи

ГОБИ ЭНД КОУЛ ЭНЕРЖИ \ ГКЭ\

ГКЭ компани нь голчлон Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулдаг ба нүүрс олборлодог. ГКЭ компани Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүг дараах хэсэгт харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	95,073	0	95,073	(95,073)	-	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	93,384	0	93,384	(93,384)	-	i
Гаалийн албан татвар	365	-	365	(365)	-	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-	-	-	-	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	-	-	-	-	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1,324	-	1,324	(1,324)	-	iii
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	929,167	10,019	919,148	(925,434)	(6,286)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	917,575	3,011	914,564	(914,564)	-	iv
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	4,464	(4,464)	-	(4,464)	v
Ус, рашаан ашигласны төлбөр	-	579	(579)	-	(579)	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	11,592	840	10,752	(10,870)	(118)	vi
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	1,125	(1,125)	-	(1,125)	vii
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	44	-	44	81	124	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	44	-	44	81	124	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	37,721	(37,721)	(27,317)	(65,038)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	3,500	(3,500)	-	(3,500)	viii
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	8,000	(8,000)	(2,073)	(10,073)	ix
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	26,221	(26,221)	(25,244)	(51,465)	x
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ж. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	2,500	1,000	1,500	(8,420)	(6,920)	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	500	1,000	(500)	(6,420)	(6,920)	xi
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	2,000	-	2,000	(2,000)	-	xii
НИЙТ ДҮН	1,026,784	48,741	978,043	(1,056,163)	(78,120)	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

ГКЭ компани зөвхөн аж ахуйн нэгжийн орлогын албан татварт дөнгөж 0.20 мянган төгрөг төлснөөр тайлагнасан. ГЕГ 93,384 мянган төгрөгийн татвар төлснөөр тайлагнасан нь зөв гэж баталгаажуулсан ба хүлээн авсан төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Хэлэлцүүлгийн үеэр ГКЭ компани 2007 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөөгүй, төлбөрийг түүний өмнөөс нүүрс олборлох хамтын ажиллагааны гэрээтэй Түлш Алтай компани хийсэн гэж тайлбарласан. Уг гэрээ ёсоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг Түлш Алтай компани төлөх үүрэгтэй ажээ. ГКЭ компани өөрөө төлбөр хийгээгүй болохоор энэ талаар тайлагнаагүй юм байна.

Төлбөрийг өмнөөс нь хийсэн хэдий ч төлбөрийг ГКЭ компани хариуцах ёстой болохоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг өөрөө тайлагнах ёстой.

II. Гаалийн татвар

ГКЭ тайлагнах тоон үзүүлэлт зөвхөн уул уурхайн олборлолтын лицензэд хамаарах ёстой учир хайгуулын лицензтэй холбоотой тоон үзүүлэлтүүд энд орохгүй гэсэн ташаа ойлголттой байснаас гаалийн татварт төлсөн төлбөрийн дүнг огт тайлагнаагүй. ГКЭ компани гаалийн татварт төлсөн төлбөрийн тодорхой дүнг гаргаж өгч чадаагүй боловч эдгээр дүн ГЕГ-ын тайлагнасан тоон үзүүлэлттэй адил байх ёстой гэж мэдэгдсэн.

ГЕГ хүлээн авснаар тайлагнасан төлбөрийн дүн 365 мянган төгрөгийг 12,606 мянган төгрөг болгон өөрчилж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

iii. Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар

Өмнө тайлбарласан шалтгаанаар ГКЭ авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварт төлсөн төлбөрийн аливаа хэмжээг тайлагнаагүй. ГКЭ компани татварт ямар хэмжээний төлбөр хийсэн талаар мэдээлж чадахгүй байсан. Гэхдээ УТЕГ-ын мэдээлсэн дүнтэй дүйж байх ёстой гэж мэдэгдсэн.

УТЕГ 1,324 мянган төгрөгийн дүнг тайлагнасан боловч нарийвчилсан мэдээлэл ирүүлээгүй.

iv. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

ГКЭ компани дээр тайлбарласан шалтгаанаар 3,011 мянган төгрөг төлснөөр анхлан тайлагнасан. ГКЭ компани дараагаар нь ашигт малтмалын олборлолт болон хайгуулын лицензтэй холбоотой төлбөрийн дүнг 1,024,654 мянган төгрөг болгож өөрчилсөн ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. АМГ тайлагнасан 917,576 мянган төгрөгийн дүнг өөрчилж 1,070,332 мянган төгрөг болгосон ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

Нарийвчилсан мэдээллээс үзвэл ГКЭ компани 8041Х дугаартай лицензийн төлбөр 123,836 мянган төгрөгийг тайлагнасан дүндээ оруулаагүй байна. Түүнээс гадна АМГ ГКЭ-ийн хийсэн хэд хэдэн төлбөрийн дүн 78,158 мянган төгрөгийг тайлагнасан дүндээ оруулаагүй байна.

v. Газрын төлбөр

ГКЭ компани тайлагнасан 4,464 мянган төгрөгийн төлбөрийг зөв гэж баталгаажуулсан ба төлсөн төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн. Нарийвчилсан мэдээллээс үзвэл газрын төлбөрийг Говь-Алтай аймгийн Чандмань сумын татварын албанд хийжээ.

УТЕГ аль нэг хэмжээний төлбөр хүлээн авсан тухайгаа тайлагнаагүй. 4,245 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

Дээр тайлбарласан шалтгаанаар ГКЭ компани 840 мянган төгрөгийн төлбөр хийснээр анхлан тайлагнасан. Харин дараа нь ГКЭ компани төлбөрийн дүнг 11,296 мянган төгрөгөөр тайлагнасан ба олборлолт болон хайгуулын лицензтэй холбоотой төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ХХҮГ тайлагнасан 11,592 мянган төгрөгийн дүнг өөрчилж, 10,764 мянган төгрөг болгосон ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

Нарийвчилсан мэдээллийн үндсэн дээр ГКЭ нь өөр компанид төлсөн ажлын байрны зөвшөөрлийн 414 мянган төгрөгийн төлбөрийг тоон үзүүлэлтэд буруу оруулсан нь тогтоосон.

vii. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр

ГКЭ компани өөрийн тайлагнасан 1,125 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба энэ талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн. Төлбөрийг Говь-Алтай аймгийн Чандмань сумын татварын албанд хийснийг тэмдэглэжээ.

УТЕГ нь түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт хүлээн авсан аливаа дүнг тайлагнаагүй. 1,125 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

viii. Компаниас яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ГКЭ компани тайлагнасан 3,500 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэгийн дүн зөв бөгөөд хандивыг Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд үзүүлснийг баталгаажуулсан. Засгийн газрын харьяа байгууллагууд тус компаниас аливаа мөнгөн дэмжлэг авсан тухай тайлагнаагүй. 3,500 төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

ix. Компаниас аймгуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ГКЭ компани дээр тайлбарласан шалтгаанаар анх тайлагнасан 8,000 мянган төгрөгийн төлбөрийг 120,314 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 5,000 мянган төгрөг, 110,241 мянган төгрөг болон 5,073 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэгийг Говь-Алтай, Баянхонгор болон Дорнод аймагт тус тус үзүүлснийг тэмдэглэжээ. Орон нутгийн захиргаа тус компаниас аливаа мөнгөн хандив авсан тухай тайлагнаагүй. Гэхдээ 110,241 мянган төгрөгийн төлбөр хүлээн авсан гэж Баянхонгор аймгийн захиргаа сүүлд нь нотолсон. 10,073 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

x. Компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ГКЭ компани дээр тайлбарласан шалтгаанаар анх тайлагнасан 26,221 мянган төгрөгийн төлбөрийг 51,464 мянган төгрөг болгон өөрчилсөн ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Нарийвчилсан мэдээллээс үзвэл 42,695 мянган төгрөгийн мөнгөн болон 8,769 мянган төгрөгийн мөнгөн бус дэмжлэгийг Говь-Алтай аймгийн Чандмань суманд тус тус үзүүлсэн байна. Мөнгөн бус дэмжлэгийн тухайд ГКЭ усны худаг барихад нь зориулж материал хандивласан байна. Орон нутгийн захиргаа тус компаниас аливаа мөнгөн дэмжлэг авсан тухай тайлагнаагүй. 51,464 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

xi. Тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50%

ГКЭ компани тайлагнасан 1,000 мянган төгрөгийн тоон үзүүлэлтээ 7,920 мянган төгрөг болгон өөрчилж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн. БОАЖЯ тайлагнасан 500 мянган төгрөгийн тоон үзүүлэлтийг 1,000 мянган төгрөг болгон өөрчилж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

Нарийвчилсан мэдээлэлээс харахад БОАЖЯ-ны тайлагнасан тоон үзүүлэлт нь ГКЭ компаний зүгээс орон нутгийн захиргаанд төлсөн нийт 6,920 мянган төгрөгийн дүнтэй хэсэг төлбөр ороогүй байсан.

6,920 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xii. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

ГКЭ компани нь дээр тайлбарласан шалтгаанаар байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлын ямар нэг дүнг анхандаа тайлагнаагүй. Дараа нь 2,000 мянган төгрөгийн төлбөр

хийснээр тайлагнасан боловч нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. БОАЖЯ тайландаа ГКЭ компани 2,000 мянган төгрөг төлснийг дурджээ.

Тодруулга:

Мэдээлэл хүссэн хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. Хариуг эхний Сануулах захидал илгээхээс хэд хоногийн өмнө буюу 2009 оны зургадугаар сарын 16-нд хүлээн авсан. Тэд тайланд орсон тоон үзүүлэлтүүдтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн байсан.

Нэмэлт мэдээлэл болон тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 8-нд ГКЭ компанитай уулзалт хийсэн. Уулзалтын үеэр нягтлан бодогч нь ОУИТБС-ын маягтаар юу юу тайлагнах ёстой талаар ташаа ойлголттой байсан учраас зөвхөн олборлолтын лицензээр төлсөн төлбөрийн дүнг тайлагнасан ба хайгуулын лицензийн холбогдолтой төлбөрийг орхисон байсан.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй зөрүү гол нь газрын төлбөр, Засгийн газрын харъяа байгууллагуудад өгсөн хандив, тусламж болон тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50%-тай холбоотой байсан.

ҮТЕГ ГКЭ компаний зүгээс орон нутагт төлсөн газрын төлбөрийн ямар нэгэн баримтыг олоогүй. ГКЭ компаний зүгээс орон нутгийн захиргаанд төлсөн тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50%-тай холбоотой аливаа төлбөрийн дүнг БОАЖЯ олоогүй байна. Засгийн газрын харъяа байгууллагууд ГКЭ компаний зүгээс Яам, агентлагуудад мөнгөн дэмжлэг болгож өгсөн аливаа хандивын дүнг тайлагнаагүй. Орон нутгийн захиргаа аймаг, сумдад мөнгөн дэмжлэг болгож ГКЭ компаний зүгээс өгсөн аливаа хандивын дүнг тайлагнаагүй.

Хавсралт В17

Гурван Төхөм

ГУРВАН ТӨХӨМ “ГТ”

Гурван Төхөм нь Монголын эзэмшлийн хувийн компани бөгөөд Төв аймагт алтны уурхайд үйл ажиллгаа явуулж байна. ГТ нь Баянзүрх дүүргийн Татварын хэлтэстэй харьцдаг.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн төлсөн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан дүнд үндэслэж үзвэл Засгийн газрын зүгээс хүлээн авсан төлбөр, Компанийн зүгээс төлсөн татвар, хураамжуудын хоорондын цэвэр зөрүү дараах байдалтай байна. Хүлээн авсан болон төлсөн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ, илэрсэн зөрүүнүүдийг дараах хүснэгтэд харуулав.

(мян.төг)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	140,801	155,517	(14,716)	14,716	0	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	1,988	1,400	588	(588)	(0)	
Гаалийн албан татвар	-	-	-	-	-	
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	137,503	132,800	4,703	(4,702)	0	i
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	342	300	42	(42)	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч зэрэгслийн албан татвар	968	917	51	(51)	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	20,100	(20,100)	20,100	-	ii
1б. Төлбөр	52,099	56,500	(4,401)	156	(4,245)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	37,264	37,300	(36)	36	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	7,812	7,800	12	(12)	-	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	6,400	(6,400)	2,155	(4,245)	iii
Ус, рашаан ашигласны төлбөр	7,023	5,000	2,023	(2,023)	-	iv
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	-	-	-	-	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	2,100	(2,100)	600	(1,500)	
АН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
АН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	v
АН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
АН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	2,100	(2,100)	600	(1,500)	vi
Бусад	-	-	-	-	-	
1ё.Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	13,658	31,600	(17,942)	-	(17,942)	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	2,000	2,000	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	11,658	29,600	(17,942)	-	(17,942)	vii
	-	-	-	-	-	
НИЙТ ДҮН	206,558	245,717	(39,159)	15,472	(23,687)	

i. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

Дээр дурдсанаар ГТ компани эхний тайлагнасан дүнгээ ихэсгэж бүхэлдүүлсэн болохоор уг дүнг 132,800 мянган төгрөг байсныг 137,503 мянган төгрөг болгон өөрчилж, тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

ҮТЕГ тайлагнасан 137,503 мянган төгрөгийн дүнг зөв гэж нотлоод, хүлээн авсан төлбөрийн талаарх нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн.

ii. Бусад мөнгөн төлбөр

ГТ буруу тайлагнасан тоон үзүүлэлтүүдээ хянан тэглэсэн.

iii. Газрын төлбөр

Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	64,324	23,351	40,973	(40,973)	-	iv
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөд төлбөр	123,959	164,736	(40,777)	(275)	(41,052)	v
Газрын төлбөр	-	700	(700)	-	(700)	
Ус, рашаан ашигласны төлбөр	-	1,050	(1,050)	-	(1,050)	vi
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	234,504	39,305	195,199	(195,199)	-	vii
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	283	12,068	(11,785)	8,847	(2,938)	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	300	(300)	300	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	120	(120)	(2,711)	(2,831)	viii
Гаалийн үйлчилгээний хураамж	283	11,648	(11,365)	11,258	(107)	ix
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	1,540	12,300	(10,760)	(11,750)	(22,510)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	3,000	(3,000)	(500)	(3,500)	x
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	1,300	7,500	(6,200)	950	(5,250)	xi
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	240	1,800	(1,560)	(12,200)	(13,760)	xii
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ё.Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	2,970	1,600	1,370	1,000	2,370	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	600	600	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	2,370	1,000	1,370	1,000	2,370	xiii
	-	-	-	-	-	
НИЙТ ДҮН	549,872	801,407	(251,535)	(238,027)	(489,562)	

i. Гаалийн татвар

Анхны тайландаа буруу мэдүүлсэн байсан учраас Шанлун тайлагнасан дүнгээ эргэн харж, 33,113 мянган төгрөг гэснийг 31,998 мянган төгрөг болгож залруулсан. ҮТЕГ 31,859 мянган төгрөг гэж тайлагнасан дүнгээ зөв гэж баталгаажуулж, нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

ii. Үл хөдлөх хөрөнгийн албан татвар

Шанлун тайлагнасан дүнгээ 8,988 мянган төгрөг байсныг 10,010 мянган төгрөг болгон өөрчилсөн ба тайланд тусгагдсан дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн. Эхний

тайланд тусгагдсан татварын төлбөрийн дүн нь тухайн жилд жинхэнэ төлсөн татварын дүн биш, үл хөдлөх хөрөнгийн албан татварт төлөх ёстой мөнгөн дүн байлаа. ҮТЕГ өөрийн тайлагнасан 10,010 мянган төгрөгийн дүнг зөв гэж баталгаажуулсан.

iii. **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

Шанлун тайланд дурдсан дүн 423,542 мянган төгрөгийг зөв гэж нотлоод, үүнд холбогдох нарийвчилсан мэдээ, мэдээллийг ирүүлсэн ба үүнийг Дорнод аймгийн Чойбалсан сумын захиргаанд төлсөн байна. ҮТЕГ хүлээн авсан төлбөрийн аливаа нэг хэмжээг тайланд дурдаагүй. 423,542 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

iv. **Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр**

Шанлун компани тайланд дурдсан төлбөрийн дүн 23,351 мянган төгрөг болж байгаа нь зөв гэдгийг нотолж, холбогдох нарийвчилсан мэдээ, мэдээллийг ирүүлсэн. АМГ тайлагнасан төлбөрийн дүнг эргэн харж, 64,324 мянган төгрөг гэснийг 23,351 мянган төгрөг болгож залруулсан ба холбогдох нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн.

v. **Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр**

Шанлун тайланд дурдсан нөхөн төлбөрийн хэмжээ 164,736 мянган төгрөг байсныг 165,061 мянган төгрөг болгож зассан ба тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан материалыг ирүүлсэн. Ирүүлсэн мэдээллээс харьцуулж үзэхэд Шанлун компанийн 2007 оны зургаадугаар сарын 15 төлсөн 41,008 мянган төгрөгийг АМГ тайлагнасан дүндээ оруулаагүй байна. АМГ 123,959 мянган төгрөгийн төлбөр хүлээж авсан гэжээ.

41,051 мянган төгрөгийн энэ зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. **Ус ашигласны төлбөр**

Шанлун 1,050 мянган төгрөг хүлээж авсан ба үүнийг Дорнод аймгийн Чойбалсан хотод тушаасан байна. ҮТЕГ хүлээж авсан төлбөрийн аливаа дүнгийн талаар тайлан ирүүлээгүй.

1,050 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

vii. **Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр**

Төлбөрийн дүнг эхлээд буруу тайлагнасан байсан учраас Шанлун тайлагнасан дүнгээ эргэн харж, 39,305 мянган төгрөг байсныг 141,977 мянган төгрөг болгон залруулсан байна. Тайланд дурдагдсан дүнгийн талаар нарийвчилсан мэдээллийг ирүүлсэн. ХХҮГ мөн төлбөрийн дүнг 234,504 мянган төгрөг гэснээ 180,065 мянган төгрөг болгож өөрчилсөн ба энэхүү залруулгынхаа талаар нарийвчилсан мэдээлэл, тооцоог ирүүлсэн. Анхны тайландаа түр хугацаагаар ажилласан гадаадын ажилчдад төлсөн төлбөрийг компаниудад нөхөн төлснийг дурдаагүй байсан.

Үлдэж байгаа 38,088 мянган төгрөгийн зөрүү Шанлун 2007 оны дөрөвдүгээр сарын 11-нд төлсөн 23,184 мянган төгрөгийн төлбөрийг оруулаагүй, мөн төлбөрийн дүнг 16,560 мянган төгрөг гэхийн оронд 1,565 мянган төгрөг гэсэн хэвлэлийн алдаатай холбоотой ажээ.

viii. **Холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагуудад төлсөн үйлчилгээний хураамж**

Анхны тайландаа буруу мэдүүлсэн байсан учраас Шанлун төлсөн төлбөрийнхөө дүнг эргэн харж, 120 мянган төгрөг гэснийг 2,831 мянган төгрөг болгож залруулсан. Дараагаар нь тайлагнасан дүнгээ засч 8,658 мянган төгрөг болгосон ба тайлагнасан төлбөрийн дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлжээ. Орон нутгийн захиргаа Шанлунаас авсан хураамжийн дүнг тайландаа дурдсангүй.

2,831 мянган төгрөгийн зөрүүгийн шалтгаан тодорхойгүй үлдлээ.

ix. **Гаалийн үйлчилгээний хураамж**

Шанлун төлсөн хураамжийн дүнг 11,648 мянган төгрөг гэснийгээ залруулж 11,083 мянган төгрөг болгосон ба тайланд дурдсан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. ГЕГ төлсөн хураамжийн дүнг 283 мянган төгрөг гэснээ залруулж 10,976 мянган төгрөг болгосон ба тайланд дурдсан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

x. **Компанийн зүгээс яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг**

Шанлун тайландаа мөнгөн дэмжлэгийн дүнг 3,000 мянган төгрөг гэснийгээ 3,500 мянган төгрөг болгож залруулсан. Энд АМГ болон Худалдаа, аж үйлдвэрийн Яаманд өгсөн хандивын дүн 500 мянган төгрөг ба 3,000 мянган төгрөг тус тус болж байгааг тэмдэглэжээ. Засгийн газар ямар нэг хэмжээний хандив авсан талаар юу ч дурдаагүй байна.

3,500 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xi. **Компанийн зүгээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг**

Шанлун тайлагнасан хандивын дүнг 7,500 мянган төгрөг гэснийгээ 6,550 мянган төгрөг болгон залруулжээ. Тайланд дурдсан хандивын дүн дараах байдалтай байна. Үүнд.

Хүлээн авагч	Хэмжээ ('000 төгрөгөөр)
Дорнод аймгийн Засаг даргын тамгын газар, 2007 оны зургадугаар сарын 18	1,300
Дорнод аймгийн эмнэлэг, 2007 оны зургадугаар сарын 15	250
Дорнод аймаг дахь Хавиргын боомтын хогийг цэвэрлэхэд зориулж өгсөн мөнгөн бус хандив	5,000

Орон нутгийн захиргаа 1,300 мянган төгрөг хүлээж авсан гэж мэдүүлсэн. Гэвч нарийвчилсан тайлан гаргаж ирүүлээгүй байна.

5,250 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

xii. **Компаний зүгээс суманд үзүүлсэн дэмжлэг**

Шанлун тайланд дурдсан хандивын дүнг 1,800 мянган төгрөг гэснийг 14,000 мянган төгрөг болгож өөрчилсөн. Тайланд дурдсан хандивын дүн дараах байдалтай байна.

Хүлээн авагч	Хэмжээ ('000 төгрөгөөр)
Хэрлэн сумын хогийг цэвэрлэхэд зориулж өгсөн мөнгөн бус хандив	10,000
Маршал Чойбалсангийн хөшөөг тойруулж хашаа барихад зориулсан мөнгөн бус хандив	3,000
Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ордонд өгсөн мөнгөн тусламж	1,000

Орон нутгийн захиргаа 240 мянган төгрөг хүлээж авсан гэж мэдүүлсэн. Гэвч нарийвчилсан тайлан гаргаж ирүүлээгүй байна.

13,760 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

xiii. **Байгаль орчныг хамгаалахад зарцуулсан зардал**

Эхэндээ Шанлун 1,000 мянган төгрөгийн зардал гаргасан хэмээн тайландаа дурдсан. Харин дараа нь Шанлун энэ дүнг 00 болгож өөрчилжээ. БОАЖЯ 2,370 мянган төгрөгийн зардал гаргасан хэмээн тайлагнасан. Гэвч тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл алга байна.

2,370 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй хэвээр үлдэж байна.

Тодруулга:

Мэдээлэл хүссэн хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. Шанлуны хариуг анхны Сануулах захидал явуулахаас гурав хоногийн өмнө буюу 2009 оны зургадугаар сарын 16-нд хүлээж авсан. Тэд тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн ба тайлан дахь зарим дүнг өөрчлөн залруулсан байлаа. Тайланд дурдсан дүнгийн талаар тайлбар авах зорилгоор Шанлунтай 2009 оны долдугаар сарын 14-нд уулзаж ярилцсан. Шанлуны өгсөн нарийвчилсан мэдээлэл, тайлбар хангалттай байлаа.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй үлдсэн зөрүүний ихэнхи нь ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр болон төрийн байгууллагуудад өгсөн хандив, тусламжаас үүссэн байна.

ҮТЕГ Шанлуны тайлагнасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн талаар ямар нэгэн зүйл дурдаагүй, мөн АМГ улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн талаар тайлагнаагүй болно. Засгийн газрын харьяа байгууллагууд болон орон нутгийн захиргаа хүлээн авсан аливаа хандивын дүнг тайлагнаагүй буюу Шанлун компанийн зүгээс Засгийн газрын харьяа байгууллагуудад өгсөн хандив, тусламжийн талаар нарийвчилсан мэдээлэл гаргаж өгч өгч чадаагүй.

Хавсралт В28

Шарын Гол

ШАРЫН ГОЛ ХК (“ШГ”)

ШГ компани нь Монголын өмчийн компани бөгөөд 80%-ийг нь Оросын компани, 20%-ийг нь нийтээр эзэмшдэг. ШГ нь Дархан Уул аймгийн Шарын Гол суманд нүүрсний уурхай ажиллуулдаг ба Дархан Уул аймгийн татварын газарт бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээсэн авсан болон компанийн хийсэн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд, Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрүүдийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүний талаар дараах хэсэгт харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	9,210	42,050	(32,840)	32,136	(703)	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	-	32,137	(32,137)	32,130	(7)	i
Гаалийн албан татвар	-	-	-	-	-	
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-	-	-	-	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	9,210	8,499	711	-	711	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	-	1,407	(1,407)	-	(1,407)	ii
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	6	(6)	6	-	
1б. Төлбөр	475,003	307,541	167,462	(165,019)	2,443	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	375,315	192,519	182,796	(182,796)	-	iii
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	33,349	14,042	19,307	(16,997)	2,310	iv
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	54,251	(54,251)	34,774	(19,477)	v
Газрын төлбөр	64,019	44,409	19,610	-	19,610	vi
Ус, рашаан ашигласны төлбөр	2,320	2,320	-	-	-	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	-	-	-	-	
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	44	-	44	(37)	7	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэглэлийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	44	-	44	(37)	7	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	24,000	30,977	(6,977)	(2,255)	(9,232)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	5,500	(5,500)	-	(5,500)	vii
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	24,000	21,443	2,557	(2,255)	302	viii
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	4,034	(4,034)	-	(4,034)	ix
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ё. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	36,350	13,650	22,700	(19,300)	3,400	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	13,650	-	13,650	(10,250)	3,400	x
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	22,700	13,650	9,050	(9,050)	-	xi
НИЙТ ДҮН	544,607	394,218	150,390	(154,475)	(4,086)	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

ШГ компани тайлагнасан 32,137 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба үүний дэлгэрэнгүй задаргааг гаргаж өгсөн. ҮТЕГ төлбөр хүлээн аваагүйгээр анх тайлагнасан. Гэхдээ дараа нь ҮТЕГ 32,130 мянган төгрөг хүлээн авснаар тайлагнаж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ii. **Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар**

ШГ өөрийн тайлагнасан 1,407 мянган төгрөгийн дүнг зөв, уг төлбөрийг 2007 оны 6 дугаар сарын 5-ны өдөр хийсэн гэж баталгаажуулсан. УТЕГ ШГ-оос ямар нэг төлбөр хүлээн аваагүйгээр тайлагнасан.

1,407 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

iii. **Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр**

ШГ өөрийн тайлагнасан 192,519 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан. УТЕГ 375,315 мянган төгрөг хүлээн авснаар тайлагнасан.

Гаргаж өгсөн задаргаа мэдээллээс харахад УТЕГ нь ШГ компанийн 182,796 мянган төгрөгийн илүү төлөлтийг тайлант дүнд оруулж тайлагнасан байхад, харин ШГ компани 2007 онд харгалзах бодит төлбөрийн дүнг тайлагнасан байна.

iv. **Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр**

ШГ өөрийн тайлагнасан 14,042 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулсан ба төлсөн төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. АМГ 33,349 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаар тайлагнасан хэдий ч нарийвчилсан мэдээлэл өгөөгүй.

19,307 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

v. **Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр**

ШГ анх тайлагнасан нөхөн төлбөрийн дүн болох 54,251 мянган төгрөгийг 45,447 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хийсэн төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Өгсөн нарийвчилсан мэдээлээс 2007 оны нэгдүгээр сарын 15-ны өдөр 26,000 мянган төгрөгийн төлбөр хийснийг тогтоосон. Гэхдээ 2007 онд зөвхөн 19,477 мянган төгрөг төлснөөр тайланд тусгагджээ. АМГ хүлээн авсан төлбөрийн аливаа дүнг тайлагнаагүй.

19,447 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. **Газрын төлбөр**

ШГ тайлагнасан 44,409 мянган төгрөгийн төлбөрийн дүнг зөв гэж баталгаажуулж, үүнийг Шарын Гол сумын газрын алба ба татварын албанд төлснөө мэдэгдсэн. УТЕГ 64,019 мянган төгрөг хүлээн авснаар тайлагнажээ.

19,610 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vii. **Компаниас яам, агентлагтуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг**

ШГ тайлагнасан 5,500 мянган төгрөгийн хандивын дүнг зөв гэж баталгаажуулсан ба хандивын дүнгийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Засгийн газрын харьяа байгууллагууд ШГ-оос авсан мөнгөн хандивын аливаа дүнг тайлагнаагүй.

5,500 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

viii. **Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг**

ШГ тайлагнасан 21,443 мянган төгрөгийн хандивын дүн зөв ба үүнийг цэцэрлэгт хүрээлэн байгуулахад нь зориулж Дархан-Уул аймагт хандивласан гэж баталгаажуулсан. Орон нутгийн захиргаа 24,000 мянган төгрөгийн хандив хүлээн авснаар тайлагнасан хэдий ч энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгөөгүй. Гэхдээ Дархан-Уул аймаг 21,745 мянган төгрөг хүлээн авсан гэж дараа нь тайлагнасан.

ix. Компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ШГ өөрийн тайлагнасан 4,034 мянган төгрөгийн хандивын дүнг зөв гэж баталгаажуулсан ба Дархан-уул аймгийн Шарын Гол суманд хандивласан. Орон нутгийн захиргаа ШГ компаниас үзүүлсэн мөнгөн дэмжлэгийн ямар нэгэн дүнг тайлагнаагүй.

4,034 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

x. Тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50%

ШГ тусгай дансанд байршуулах байгаль орчныг хамгаалах зардлын 50% болох 13,650 мянган төгрөгийг байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал гэж буруу тайлагнасан.

БОАЖЯ анх тайлагнасан 13,650 мянган төгрөгийн дүнг 17,050 мянган төгрөг болгон өөрчилсөн ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. ШГ-оос 2007 оны 5 дугаар сарын 9 ба 29-ний өдрүүдэд хийсэн нийт 3,400 мянган төгрөгийн хоёр төлбөрийг орхисон байсан. 3,400 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн.

xi. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

Дээр тайлбарласанчлан ШГ энэ зардлыг буруу тайлагнасан. Гэхдээ дараа нь ШГ энэ дүнг 22,700 мянган төгрөг болгож өөрчилсөн. БОАЖЯ ШГ компаниас 22,700 мянган төгрөг хүлээн авснаар тайлан гаргажээ. Гэхдээ нарийвчилсан мэдээлэл өгөөгүй.

Тодруулга:

Мэдээлэл хүссэн захидлыг 2009 оны 5 дугаар сарын 23-нд илгээсэн. ШГ-ын хариуг 2009 оны 6 дугаар сарын 15-ны өдөр буюу анхны Сануулах захидал явуулахаас 4 хоногийн өмнө хүлээн авсан. Тэд тайлагнасан дүнгийнхээ дэлгэрэнгүй задаргааг гаргаж өгсөн. 2009 оны 7 дугаар сарын 23-ны өдөр ШГ компанитай утсаар ярьж тайлагнасан дүн дээр нэмэлт тайлбар авсан. ШГ компанийн гаргаж өгсөн мэдээлэл шаардлага хангахуйц байсан.

ШГ компани хуучин загвараар ОҮИТБС-ын маягт 1-ийг бөглөсөн байсан. МОҮИТБСАА тайлангийн маягтыг сайжруулах талаар өмнөх зөвлөгчийн өгсөн зөвлөмжүүдийн дагуу маягтыг засаж сайжруулах шаардлагатай байсан учраас шинэ маягтыг 2008 оны 5 дугаар сард гаргасан. Зарим компани хуучин маягтаар тайлагнасан байсан тул МОҮИТБСАА эдгээр компаниудад дахин ажил удахгүйн тулд эдгээр тайланг хүлээн авсан

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй зөрүү нь голчлон тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан шилжүүлсэн санхүүжилт ба байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардалтай холбоотойгоор гарсан байна.

Орон нутгийн захиргаа тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан уг компаниас хүлээн авсан ямар нэг тайлагнаагүй байна. Байгаль хамгаалахтай холбогдон гарсан зардлыг тусдаа дансанд бүртгэдэггүй учраас дэлгэрэнгүй задаргаа мэдээлэл гаргаж өгөх боломжгүй гэсэн учраас цааш ажиллах боломжгүй болсон.

Хавсралт В29

Шижир Алт

Шижир Алт "ША"

Шижир Алт компани нь төрийн өмчийн оролцоотой Монголын компани бөгөөд Төв аймгийн Заамар, Булган аймгийн Бүрэгхангай сумдад алтны уурхай ажилуулдаг.

ША компани УТЕГ-т бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компаний зүгээс хийсэн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзвэл Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүнүүдийг дараах хэсэгт харуулав.

(мян.төг)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	3,399,674	4,043,945	(644,272)	644,272	-	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	751,260	703,856	47,404	(47,404)	-	i
Гаалийн албан татвар	48,070	156,219	(108,149)	108,149	-	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	2,587,945	3,171,552	(583,607)	583,607	-	iii
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	10,372	10,392	(20)	20	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	2,026	1,926	100	(100)	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	1,083,844	1,140,201	(56,357)	856	(55,501)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	807,279	807,279	0	-	0	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	594	1,450	(856)	856	-	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	7,302	13,118	(5,816)	-	(5,816)	iv
Ус, рашаан ашигласны төлбөр	214,512	259,303	(44,791)	-	(44,791)	v
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	54,156	59,051	(4,895)	-	(4,895)	vi
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	90	-	90	52	142	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	90	-	90	52	142	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	2,762,073	(2,762,073)	2,762,073	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	2,762,073	(2,762,073)	2,762,073	-	vii
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	4,325	-	4,325	(5,000)	(675)	
АН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	(5,000)	(5,000)	viii
АН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
АН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	4,325	-	4,325	-	4,325	ix
АН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1ё.Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	916,117	916,117	-	-	-	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	26,000	26,000	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	890,117	890,117	-	-	-	
	-	-	-	-	-	
НИЙТ ДҮН	5,404,050	8,862,336	(3,458,286)	3,402,251	(56,034)	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

ША аж ахуйн нэгжийн орлогын албан татварт 703,851 мянган төгрөг төлснөөр тайлагнасан. УТЕГ тайлагнасан татварын дүн 751,260 мянган төгрөг нь зөв гэж баталгаажуулж, хүлээн авсан татварын талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Хэлэлцүүлгийн явцад ША компани 2007 оны дүнг зарлагадсанаар бус, өссөн дүнгээр тайлагнасан тул зөрүү үүссэн нь тогтоогдсон.

ii. Гаалийн татвар

ША гаалийн татварт 156,219 мянган төгрөг төлснөөр тайлагнасан. ГЕГ өөрийн тайлагнасан 48,070 мянган төгрөгийн дүн зөв гэж нотолж, хүлээн авсан татварын талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ША компани 2007 оны дүнг зарлагадсанаар бус, өссөн дүнгээр тайлагнаснаас үүдэн зөрүү үүссэн байна.

iii. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар

ША зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварт 3,171,552 мянган төгрөг төлснөөр тайлагнасан. УТЕГ 2,587,945 мянган төгрөгийн тайлагнасан дүнг зөв гэж баталгаажуулж, хүлээн авсан татварын төлбөрийн холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ША компани 2007 оны дүнг зарлагадсанаар бус, өссөн дүнгээр тайлагнаснаас үүдэн зөрүү үүссэн байна.

iv. Газрын төлбөр

ША компани тайлагнасан 13,118 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан боловч нягтлан бодогч нь ээлжийн амралттай байгаа, 2009 оны 9 дүгээр сард ажилдаа орох тул нарийвчилсан мэдээллийг өгч чадаагүй.

УТЕГ хүлээн авсан 7,302 мянган төгрөгийн төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 5,816 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

v. Ус ашигласны төлбөр

ША компани тайланд дурдсан 259,303 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан боловч дээр дурдсан шалтгаанаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

УТЕГ хүлээн авсан 214,512 мянган төгрөгийн төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

44,791 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

ША компани тайлагнасан 59,051 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан боловч дээр дурдсан шалтгаанаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй. ХХҮГ хүлээн авсан 54,156 мянган төгрөгийн төлбөртэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн. 4,895 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна

vii. Төрийн өмчийн ногдол ашиг

ША компани тайлагнасан ногдол ашгийн төлбөрийн дүн 2,762,073 мянган төгрөгийг 508,576 мянган төгрөг болгон өөрчилсөн ба үүнийг Монголросцветмет нэгдэлд төлсөн гэж мэдэгдсэн. Монголросцветмет нэгдэл хамтарсан компани (төрийн оролцоотой) тул ША компани хийсэн төлбөрөө төрийн өмчийн ногдол ашиг гэж буруу ойлгосон байна.

viii. Компаниас яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ША компани нь анхандаа мөнгөн дэмжлэг үзүүлсэн тухайгаа тайлагнаагүй. Гэвч энэ талаар санал солилцсоны дараа Онцгой байдлын Ерөнхий газарт 5,000 мянган төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн тухайгаа мэдэгдсэн. Нягтлан бодогч нь орос үндэстэн тул монгол хэл

дээрх ОУИТБС-ын маягтыг бөглөх зааврыг ойлгоогүй тул мөнгөн дэмжлэгийн талаар өмнө нь мэдээлээгүй гэсэн тайлбар өгсөн.

Засгийн газар тус компаниас үзүүлсэн мөнгөн хандив, тусламжийн дүнг тайлагнаагүй.

5,000 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ix. Компаниас сумдад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ША компани сумдад мөнгөн дэмжлэг үзүүлээгүй гэсэн. Орон нутгийн захиргаа тус компаниас 4,325 мянган төгрөгийн хандив авсан гэж тайлагнасан боловч энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

4,325 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

Тодруулга:

ША компани бидний зүгээс мэдээлэл ирүүлэх хүсэлт тавьснаас хойш долоо хоногийн дараа буюу 2009 оны зургадугаар сарын 16-нд хариу ирүүлсэн. Гэвч тэдний хариунд тайлагнасан дүнгүүдийг баталгаажуулсан буюу өөрчилсөн байснаас бус нарийвчилсан мэдээллийг тусгаагүй байлаа.

Нарийвчилсан мэдээлэл болон илэрсэн зөрүүний талаар нэмж тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 2-нд ША компанитай уулзалт хийсэн. Нягтлан бодогчийн өгсөн нарийвчилсан мэдээлэл болон тайлбар хангалттай байсан. Уулзалтын үеэр нягтлан бодогч нь зарим зөрүүний талаарх нэмэлт мэдээллийг удахгүй өгөхөөр тохирсон боловч бидний хүссэн мэдээлэл одоогоор алга байна. Нягтлан бодогч нь 2009 оны 9 дүгээр сар хүртэл эзгүй байх юм байна.

Хэд хэдэн зөрүү ША компанийн нягтлан бодогч тайланг буруу үйлдэж, дүнг зарлагдсанаар бус, өссөн дүнгээр тайлагнасантай холбоотой. Нягтлан бодогч нь орос үндэстэн тул монгол хэл дээрх ОУИТБС-ын маягтыг бөглөх зааврыг сайн ойлгоогүй юм байна.

Хураангуй тайлбар:

Шийдэгдээгүй үлдсэн зөрүү нь газрын төлбөр, ус ашигласны төлбөр, гадаадын мэргэжилтэн ажилчдын ажлын байрны төлбөр мөн сум, Засгийн газрын яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн тусламжийн дүнгээс голлон үүсэн байна.

ША компанийн асуудал хариуцсан нягтлан бодогч тухайн үед байгаагүйн улмаас газрын төлбөр, ус ашигласны төлбөр болон гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөрийн талаар нарийвчилсан дүн мэдээ гаргах боломжгүй байсан учир цааш харьцуулалт хийх боломжгүй болсон. Засгийн газрын харьяа байгууллагууд ША компаниас авсан хандивын тухай тайлагнаагүй, ҮТЕГ ч орон нутгийн захиргааны ША компаниас авсан мөнгөн хандивийн талаар нарийвчилсан мэдээ гаргаж чадаагүй.

Хавсралт В30

Шим Текноложи

Шим Текноложи \”ШТ”\

Шим Текноложи нь Эрдэнэт уул уурхайн корпорацийн 30% , Израиль улсын МеталТек компанийн 70 хувийн хөрөнгө оруулалт бүхий хамтарсан компани болно.

Тус компани Эрдэнэтэд үйл ажиллагаа явуулдаг ба Хятад, Өмнөд Солонгос, Энэтхэг, Япон, АНУ-д экспортолдог молибдений хүчил үйлдвэрлэдэг.

Шим Текноложи УТЕГ-т бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүний талаар дараах хэсэгт харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	714,472	1,688,060	(973,588)	964,835	(8,753)	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	427,914	1,395,559	(967,645)	967,645	-	i
Гаалийн албан татвар	281,126	287,733	(6,607)	(2,127)	(8,734)	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-	-	-	-	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	5,185	4,502	683	(683)	0	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	247	266	(19)	-	(19)	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	-	27,979	(27,979)	24,250	(3,729)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	-	-	-	-	-	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордон нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	3,729	(3,729)	-	(3,729)	iii
Ус, рашаан ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	-	24,250	(24,250)	24,250	-	iv
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	-	8,662	(8,662)	1,885	(6,777)	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	-	8,662	(8,662)	1,885	(6,777)	v
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдоо бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	9,193	(9,193)	9,193	-	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	7,600	(7,600)	7,600	-	vi
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	1,593	(1,593)	1,593	-	vii
Бусад	-	-	-	-	-	
1ё. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	-	-	-	-	-	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	-	-	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	-	-	-	-	-	
НИЙТ ДҮН	714,472	1,733,894	(1,019,422)	1,000,163	(19,259)	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Шим Текноложи компани 2007 онд төлсөн төлбөрийн бодит дүнг бус, төлөх ёстой аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хэмжээг тайлагнасан тул 1,395,558 мянган төгрөгийг өөрчлөн 427,914 мянган төгрөг болгосон. УТЕГ тайлагнасан 427,914 мянган төгрөгийн татварын төлбөрийн дүнг баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

ii. Гаалийн татвар

Шим Текноложи тайлагнасан 287,733 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. Дараа нь үүнийгээ өөрчилж 289,860 мянган төгрөг болгосон ба гаалийн татварын шинэчилсэн жагсаалтыг өгсөн.

ГЕГ өөрийн тайлагнасан 281,126 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээллийг өгсөн.

8,734 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

iii. Газрын төлбөр

Шим Текноложи тайлагнасан 3,729 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг өгсөн. Шим Текноложи газрын төлбөрийг Орхон аймгийн газрын албанд төлжээ. УТЕГ Шим Текноложи компаниас авсан газрын төлбөрийн дүнг тайлагнаагүй.

3,729 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

iv. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

Шим Текноложи анхандаа 24,250 мянган төгрөгийн төлбөр хийснээр тайлагнасан. Гэвч дараа нь үүнийг өөрчилж 24,264 мянган төгрөг болгосон ба энэ талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн. Төлбөрийг Орхон аймгийн хөдөлмөрийн албанд хийжээ.

ХХҮГ анхандаа төлбөр авсан тухай тайлагнаагүй. Харин дараа нь 26,616 мянган төгрөгийн төлбөр хүлээн авснаа мэдэгдэж, үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл өгсөн. Шим Текноложитэй цааш ярилцсаны дүнд ХХҮГ-аас тайлагнасан тоон үзүүлэлтийг баталгаажуулж, Шим Текноложи 2007 оны хоёрдугаар сарын 9 болон гуравдугаар сарын 7-нд хийсэн хоёр төлбөрийг оруулаагүй үлдээсэн, гурван төлбөрийг тооцохдоо алдаа гаргасан байсныг тогтоосон.

v. Гаалийн үйлчилгээний хураамж

Шим Текноложи өөрийн тайлагнасан 8,662 мянган төгрөгийн төлбөрийн дүнг баталгаажуулсан ба холбогдох нарийвчилсан мэдээллийг өгсөн. ГЕГ анхандаа ямар нэгэн төлбөр авсан тухай тайлагнаагүй. Харин дараа нь 1,885 мянган төгрөгийн төлбөр авсан гэж мэдэгдсэн ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

6,777 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vi. Компаниас яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

Шим Текноложи өөрийн тайлагнасан 7,600 мянган төгрөгийн хандивын дүнг баталгаажуулсан ба энэ талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн. 6,600 мянган төгрөг болон 1,000 мянган төгрөгийн мөнгөн хандивыг Монголын хөнгөн атлетикийн холбоо болон Атлантын Олимпийн судалгааны төвд тус тус өгсөн байна. Эдгээр байгууллага Засгийн газрын агентлаг биш учраас тайлагнасан төлбөрийг хасах шаардлагатай.

vii. Компаниас тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зарцуулсан хөрөнгө

Шим Текноложи анхлан 1,593 мянган төгрөг зарцуулснаар тайлагнасан. Гэвч дараа нь үүнийг өөрчилж 4,587 мянган төгрөг болгосон. Мөнгөн хандивыг дараах байгууллагуудад өгчээ. Үүнд:

Хүлээн авагч байгууллага	Дүн (мян. төг)
Энэрэл төвд оюутны сургалтын төлбөр	1,987
Номин телевиз	1,100
Эрдмийн сан сургуульд	1,500

Орон нутгийн захиргаа тус компаниас мөнгөн дэмжлэг авсан тухай тайлагнаагүй.

Зөвхөн тодорхой аймаг буюу суманд зориулж байгуулсан хөгжлийн санд хийсэн төлбөрийг тайлагнах учиртай. Дээрх мөнгөн хандивыг энэ зүйл ангиар тайлагнах шаардлагагүй.

Тодруулга:

Мэдээлэл ирүүлэх хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. Шим Текноложийн хариуг хүсэлт тавьсны дараа хоёр долоо хоногийн дотор 2009 оны зургадугаар сарын 5-нд факсаар авсан. Тэд тайлагнасан тоон үзүүлэлтийн талаар нарийвчилсан мэдээллийг өгсөн. Дутуу мэдээлэл болон тайлагнасан тоон үзүүлэлтийн талаар нэмж тайлбар авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 17-нд Шим Текноложитэй уулзаж ярилцсан.

Засгийн газрын харьяа байгууллагуудаас ирүүлсэн нарийвчилсан мэдээллийг авсны дараа тайлагнасан тоон үзүүлэлт болон илэрсэн зарим зөрүүг баталгаажуулах үүднээс 2009 оны наймдугаар сарын 5-нд утсаар ярьсан болно. Шим Текноложи компаниас өгсөн мэдээлэл болон тайлбар хангалттай байсан.

Хураангуй тайлбар:

Гол зөрүү нь гаалийн татвар болон гаалийн үйлчилгээний хураамжтай холбоотойгоор гарчээ. Шалтгаан нь тодорхойгүй байна.

Хавсралт В31

Шинь Шинь

Шинь Шинь \ШШ\

Шинь Шинь компани нь Хятадын 100 хувийн эзэмшлийн компани юм. Тус компани полиметаллын орд газраас цайр олборлох бэлтгэлийг хангаж байгаа бөгөөд өдөрт 3,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барина. ШШ компани Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг.

ШШ компани Дорнод аймгийн татварын газарт бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн хийсэн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан тоон үзүүлэлтүүдээс үзэхэд Засгийн газрын хүлээн авсан төлбөр, компанийн хийсэн төлбөрийн хооронд дараах цэвэр зөрүү гарч байна. Хүлээн авсан болон хийсэн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ болон илэрсэн зөрүүний талаар дараах хэсэгт тусган харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	510,079	933,221	(423,142)	421,831	(1,311)	
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	100	100	-	-	-	
Гаалийн албан татвар	509,812	932,954	(423,143)	421,832	(1,311)	i
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	-	-	-	-	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	56	56	0	(0)	-	
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	111	111	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	1,293,015	1,351,283	(58,268)	58,228	(40)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	119,890	44,676	75,214	(75,214)	-	ii
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордны нөхөд төлбөр	1,062,850	1,151,394	(88,544)	88,544	-	iii
Газрын төлбөр	1,405	1,405	-	-	-	
Ус, рашаан ашигласны төлбөр	540	540	-	-	-	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	108,330	153,228	(44,898)	44,898	-	iv
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	40	(40)	-	(40)	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	783	-	783	(425)	358	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгтийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	783	-	783	(425)	358	v
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	1,300	14,225	(12,925)	7,800	(5,125)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	6,000	(6,000)	5,000	(1,000)	vi
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	1,300	4,925	(3,625)	4,925	1,300	vii
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	3,300	(3,300)	2,800	(500)	viii
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	(4,925)	(4,925)	ix
Бусад	-	-	-	-	-	
1ё.Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	11,000	8,770	2,230	(230)	2,000	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	9,000	8,770	230	(230)	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	2,000	-	2,000	-	2,000	x
	-	-	-	-	-	
НИЙТ ДҮН	1,816,177	2,307,499	(491,322)	487,204	(4,118)	

i. Гаалийн татвар

ШШ компани анх гаалийн татварт тайлагнасан 932,954 мянган төгрөгийн төлбөрийн дүнг 508,625 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хийсэн төлбөрийн нарийвчилсан задаргааг гаргаж өгсөн. ГЕГ мөн тайлагнасан 509,812 мянган төгрөгийн төлбөрийн дүнг 538,957 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Нарийвчилсан мэдээллээс ШШ компани тавдугаар сарын 21, зургадугаар сарын 11, долдугаар сарын 30, наймдугаар сарын 4, 23,31, арваннэгдүгээр сарын 13, аравдугаар

сарын 4,18, 29, 31 болон есдүгээр сарын 2, 20, 23-нд хийсэн нийтдээ 49,482 мянган төгрөгийн төлбөрийг, мөн ГЕГ 2007 оны зургадугаар сарын 10-нд хүлээн авсан 17,840 мянган төгрөгийн төлбөрийг тус тус хассан байсныг тогтоосон.

1,311 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

ii. Ашигт малтмалын ашиглалт болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр

ШШ компани анх тайлагнасан 44,676 мянган төгрөгийн төлбөрийн дүнг 33,313 мянган төгрөг болгон өөрчилсөн ба үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг өгсөн. АМГ мөн тайлагнасан 119,890 мянган төгрөгийн дүнг 33,314 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хүлээн авсан төлбөрийн талаар нарийвчилсан мэдээлэл өгсөн.

Нарийвчилсан мэдээллийн үндсэн дээр АМГ-ын өөрчилж ирүүлсэн дүнд 2007 оны наймдугаар сарын 13-нд хүлээн авсан 5,342 мянган төгрөгийн төлбөр ороогүй байсныг тогтоосон.

iii. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр

ШШ компани өөрийн тайлагнасан 1,151,394 мянган төгрөгийн төлбөрийн дүнг 1,061,213 мянган төгрөг болгож өөрчилсөн ба холбогдох нарийвчилсан мэдээллийг өгсөн. АМГ өөрийн тайлагнасан 1,062,850 мянган төгрөгийн дүнг зөв гэж баталгаажуулсан. 1,637 мянган төгрөгийн үлдэж байгаа зөрүү нь гадаадын валют хөрвүүлэх ханшны зөрүүгээс үүссэн байна.

iv. Гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөр

ШШ компани өөрийн тайлагнасан 153,228 мянган төгрөгийн төлбөрийн дүнг 154,337 мянган төгрөг болгон өөрчилсөн ба үүнтэй холбоотой нарийвчилсан мэдээллийг өгсөн. ХХҮГ мөн тайлагнасан 108,330 мянган төгрөгийн дүнгээ 107,940 мянган төгрөг болгон өөрчилсөн ба төлбөрийн талаарх нарийвчилсан мэдээллийг өгсөн.

Нарийвчилсан мэдээллийн үндсэн дээр ШШ компани Сангийн яаманд төлсөн 44,959 мянган төгрөгийн үйлчилгээний хураамж болон гадаадын мэргэжилтэн, ажилчдын ажлын байрны төлбөрийг оруулж тооцсоныг тогтоосон. ШШ компани төлбөрийг япон иенээр хийсэн тул үлдсэн 1,438 мянган төгрөгийн зөрүү нь гадаад валют хөрвүүлэх ханшны зөрүүтэй холбоотой байна.

v. Гаалийн үйлчилгээний хураамж

Эхэндээ ШШ компани гаалийн үйлчилгээний хураамжийн талаар огт тайлагнаагүй. Сүүлдээ 7,268 мянган төгрөгөөр тайлан гаргаж, энэ талаар нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн. ГЕГ тайлагнасан дүн 783 мянган төгрөгийг 7,626 мянган төгрөг болгож өөрчлөөд, нарийвчилсан мэдээлэл ирүүлсэн.

Ирүүлсэн нарийвчилсан мэдээлэлээс үзвэл ШШ компани нь уг дүнд тээврийн агентын шимтгэлийг оруулжээ. ШШ компани тээврийн агентад төлсөн шимтгэл, гаалийн хураамжийг хооронд нь ялган салгаж чадаагүй байна.

vi. Компаниас яам, агентлагуудад үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ШШ компани 2008 онд үзүүлсэн мөнгөн дэмжлэгийн дүнг тайланд оруулсан байсан тул анх тайлагнасан 6,000 мянган төгрөгийн хандивын дүнг 1,000 мянган төгрөг болгон өөрчилсөн ба хандивыг АМХЭГ-т өгсөн тухайгаа мэдэгдсэн. Засгийн газар тус компаниас мөнгөн хандив авсан тухай тайлагнаагүй.

1,000 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

vii. Компаниас аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ШШ компани Дорнод аймгийн Хөгжлийн санд 4,925 мянган төгрөгийн мөнгөн хандив оруулсан тухайгаа мэдэгдсэн.

Орон нутгийн захиргаа тус компаниас 1,300 мянган төгрөгийн мөнгөн хандив хүлээн авсан тухай тайлагнасан боловч нарийвчилсан мэдээлэл өгч чадаагүй.

Аймаг, сумын тогтвортой хөгжлийн санд төлсөн дүнг “Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан шилжүүлсэн санхүүжилт” гэсэн зүйлээр тайлагнах ёстой байсан. Дорнод аймгийн хөгжлийн санд өгсөн хандивыг энэ зүйлд оруулж тайлагнах ёсгүй байсан. 1,300 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн.

viii. Компаниас суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг

ШШ компани 2008 онд үзүүлсэн мөнгөн дэмжлэгийг тайланд тусгасан байсан тул анх тайлагнасан 3,300 мянган төгрөгийн хандивын дүнг 500 мянган төгрөг болгож өөрчилсөн. Мөнгөн хандивыг Дорнод аймгийн Дашбалбар суманд өгчээ.

Орон нутгийн захиргаа тус компаниас мөнгөн хандив авсан тухай тайлагнаагүй.

ix. Тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан шилжүүлсэн санхүүжилт

ШШ компани ба орон нутгийн засгийн газар ямар нэгэн дүн тайлагнаагүй. Гэхдээ, ШШ компаниас Дорнод аймгийн хөгжлийн санд өгсөн 4,925 мянган төгрөгийн хандивыг компанийн зүгээс аймагт өгсөн хандив гэж тайлагнасан байгааг олж мэдсэн. 4,925 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдсэн.

x. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардал

ШШ компани байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлыг тусгайлан тооцдоггүй учраас уг зардлыг тайлагнаж чадахгүй байсан.

БОАЖЯ 2,000 мянган төгрөг хүлээн авснаар тайлагнасан боловч нарийвчилсан мэдээлэл өгөөгүй.

2,000 мянган төгрөгийн зөрүү шийдэгдээгүй үлдэж байна.

Тодруулга:

Мэдээлэл ирүүлэх хүсэлтийг 2009 оны тавдугаар сарын 23-нд илгээсэн. ШШ компани анхны Сануулах захидал илгээснээс хойш 3 хоногийн дараа буюу 2009 оны зургадугаар сарын 22-нд хариу ирүүлсэн ба түүндээ тайлагнасан дүнгийн талаар нарийвчилсан мэдээллийг оруулсан байсан. Илэрсэн зарим зөрүүний талаар нэмж тодруулах, мэдээлэл авах зорилгоор 2009 оны долдугаар сарын 1-нд тэдэнтэй утсаар ярьсан. 2009 оны долдугаар сарын 8-нд бидний хүссэн мэдээлэл, тайлбар бүхий захидал хүлээж авсан. ШШ компаниас ирүүлсэн мэдээлэл хангалттай байсан. Хүний алдаа болон 2008 онд үзүүлсэн мөнгөн дэмжлэгийг тайланд оруулсан зэргээс шалтгаалан анх тайлагнасан тоон үзүүлэлтүүдээ олонтаа өөрчилж залруулсан.

Хураангуй тайлбар:

Гол зөрүү тус компаниас тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан аймгийн захиргаанд шилжүүлсэн санхүүжилт болон байгаль орчныг хамгаалахтай холбоотой гарсан зардалтай холбоотой байна.

Орон нутгийн захиргаа тогтвортой хөгжил, орон нутгийн харилцаанд зориулан ямар нэгэн санхүүжилт уг компаниас хүлээн авсан эсэх талаар тайлагнаагүй. ШШ компаниас байгаль орчныг хамгаалахтай холбоотой гаргасан зардлын дүнг тусдаа дансанд бүртгээгүй тул дүнг гаргаж өгөх боломжгүй байгаа тулд цааш ажиллах боломжгүй болсон. тодорхойлох боломжгүй байгаа ба БОАЖЯ–наас төлбөрийн дэлгэрэнгүй мэдээлэл гаргаж өгч чадахгүй байна. ҮТЕГ тус компаниас орон нутагт өгсөн мөнгөн хандивын талаар мэдээлэл өгөх боломжгүй байна.

Хавсралт В32

Шивээ-Овоо

Шивээ-Овоо “ШО”

Шивээ-Овоо нь 90%-ийн төрийн өмчийн оролцоотой Монголын компани бөгөөд Говь-Сүмбэр аймгийн Шивээ-Овоо суманд нүүрсний уурхай ажиллуулдаг.

ШО Говь-Сүмбэр аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй.

Засгийн газрын хүлээн авсан болон компанийн төлсөн төлбөрүүдийн хоорондын зөрүү

Тайлагнасан дүнд үндэслэж үзвэл Засгийн газрын хүлээн авсан төлбөр болон компанийн зүгээс төлсөн татвар, хураамжуудын хоорондын цэвэр зөрүү дараах байдалтай байна. Хүлээн авсан болон төлсөн төлбөрүүдийн нарийвчилсан шинжилгээ, илэрсэн зөрүүнүүдийг дараах хэсэгт харуулав.

(МЯН.ТӨГ)

	Засгийн газрын тайлагнасан дүн	Компани тайлагнасан дүн	Анхны зөрүү	Залруулга	Шалтгаан нь олдоогүй зөрүү	Тодруулга
1а. Төлсөн татварууд	80,732	58,264	22,469	(17,689)	4,780	
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	5,000	-	5,000	(5,000)	-	i
Гаалийн албан татвар	22,469	-	22,469	(17,689)	4,780	ii
Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	-	57,283	(57,283)	57,283	-	iii
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	52,283	-	52,283	(52,283)	-	iv
Онцгой албан татвар (шатах тослох материал борлуулсан бол)	-	-	-	-	-	
Автобензин, дизелийн түлшний албан татвар	-	-	-	-	-	
Авто тээвэр, өөрөө явагч хэрэгслийн албан татвар	981	981	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
Бусад татвар мөнгөн дүнгээр	-	-	-	-	-	
1б. Төлбөр	259,885	8,538	251,347	(253,483)	(2,136)	
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	254,500	-	254,500	(254,500)	-	v
Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	1,065	1,065	-	-	-	
Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөд төлбөр	-	-	-	-	-	
Газрын төлбөр	-	2,136	(2,136)	-	(2,136)	vi
Ус, рашаан ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр	-	-	-	-	-	
Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	4,320	5,337	(1,017)	1,017	-	vii
Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны нөхөн төлбөр	-	-	-	-	-	
Лицензийн төлбөр	-	-	-	-	-	
Бусад төлбөр	-	-	-	-	-	
1в. Хураамж, үйлчилгээний хөлс	-	-	-	292	292	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн улсын тэмдэгийн хураамж, бусад хураамж	-	-	-	-	-	
Зохих хууль тогтоомжийн дагуу төв, о/н-ийн төр захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хөлс	-	-	-	-	-	
Гаалийн үйлчилгээний хураамж	-	-	-	292	292	
Бусад	-	-	-	-	-	
1г. Төрийн болон орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Төрийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
Орон нутгийн өмчийн ногдол ашиг	-	-	-	-	-	
1д. Хүлээн авагч Засгийн газарт төлсөн бусад төлбөрүүд	-	-	-	-	-	
Бүтээгдэхүүн хуваах гэрээ бүхий аж ахуйн нэгжийн Засгийн газарт ногдох бүтээгдэхүүний оронд төлсөн төлбөр /доллар/	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1е. Төрийн байгууллагад үзүүлсэн дэмжлэг	-	3,700	(3,700)	-	(3,700)	
ААН-ээс яам, агентлагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	3,000	(3,000)	-	(3,000)	viii
ААН-ээс аймагт үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	700	(700)	-	(700)	
ААН-ээс суманд үзүүлсэн мөнгөн дэмжлэг	-	-	-	-	-	
ААН-ээс о/н-ийн тогтвортой хөгжилд зарц.хөрөнгө	-	-	-	-	-	
Бусад	-	-	-	-	-	
1б. Байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардал	6,250	2,000	4,250	(4,250)	-	
Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал	2,000	2,000	-	-	-	
Байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулсан зардал	4,250	-	4,250	(4,250)	-	ix
НИЙТ ДҮН	346,867	72,501	274,366	(275,130)	(764)	

i. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

